УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2020-2024 ОНЫ
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА
/2022 оны жилийн эцэс/

2023 оны 01 дүгээр сарын 30

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөний 2021-2022 биелэлтэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөгөөг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөнд 7 ерөнхий чиг үүргийн  22 үндсэн чиг үүргийн 29 зорилт тусгагдсан бөгөөд Төрийн захиргааны удирдлагын газраас 2022 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн ирүүлсэн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан 7 ерөнхий чиг үүргийн 22 үндсэн чиг үүргийн 29 зорилт 100 арга хэмжээний 2021-2022 оны биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **82.5** хувийн биелэлттэй гэж дүгнэв. Үүнд:

- **1. Ерөнхий чиг үүргийн нэр: Геологийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах - 91.6**
- **2. Ерөнхий чиг үүргийн нэр: Уул уурхайн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах – 70.37**
- **3. Ерөнхий чиг үүргийн нэр:  Газрын тосны салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах – 85.00**
- **4. Ерөнхий чиг үүргийн нэр: Хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах – 64.60**

- **5. Ерөнхий чиг үүрэг: Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, зохицуулах, хэрэгжүүлэх – 100.0**
- **6. Ерөнхий чиг үүрэг: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах, хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, бодлого, чиглэлийг тодорхойлох болон энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад бүх талын дэмжлэг үзүүлэх, зохицуулах, тайлагнах – 100.0**
- **7. Ерөнхий чиг үүргийн нэр: Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах – 100.0**

## ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ
**/2022 оны жилийн эцэс/**

| Зорилго, зорилт | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн явц /хувиар/ | | | | | | | Үнэлгээ /%/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | /-/ | |
| **1. Ерөнхий чиг үүргийн нэр: Геологийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.** | | | | | | | | | |
| Үндсэн чиг үүрэг-1: Геологийн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих, бодлогын удирдлагаар хангах. | | | | | | | | | |
| Зорилт-1: Геологийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах. | 4 | 1 | | 2 | 1 | | | | 72.5 |
| Зорилт-2: Геологийн шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хөгжлийн урт хугацааны бодлого, хууль тогтоомжийн төслийн судалгаа хийх, хэрэгжилтийг хангах, салбарын үйл ажиллагааг нийтэд | 4 | 3 | | 1 | | | | | 92.5 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах. | | | | | | | | | |
| Үндсэн чиг үүрэг-2: Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлж, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах. | | | | | | | | | |
| Зорилт-3: Бүх төрлийн геологийн судалгааны ажлыг төлөвлөх, төсвийн саналыг боловсруулах, нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг тодорхойлох, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих. | 10 | 9 | | | | | | 1 | 100.00 |
| Үндсэн чиг үүрэг-3: Геологи-хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг өсгөх. | | | | | | | | | |
| Зорилт-4: Ашигт малтмалын геологи-хайгуулын ажлын хэмжээг нэмэгдүүлэх, улсын эрдэс баялгийн нөөцийг өсгөх ажлыг зохион байгуулах, хяналт тавих. | 6 | 5 | | 1 | | | | | 95.00 |
| Үндсэн чиг үүрэг-4: Геологи, эрдэс баялгийн үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх. | | | | | | | | | |
| Зорилт-5:Геологийн салбарын нэгдсэн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөгжүүлэх, хуулиар зөвшөөрөгдсөн мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй болгох ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих. | 2 | | 1 | 1 | | | | | 80.00 |
| Дүн | 26 | 18 | 1 | 5 | 1 | | | 1 | 91.6 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2. Ерөнхий чиг үүргийн нэр: Уул уурхайн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.** | | | | | | | | | |
| Үндсэн чиг үүрэг-1: Уул уурхайн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох. | | | | | | | | | |
| Зорилт-1: Уул уурхайн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, төсөл, хөтөлбөрийн хувилбар боловсруулах. | 4 | 1 | | 2 | 1 | | | | 72.5 |
| Үндсэн чиг үүрэг-2: Ашигт малтмалын олборлолт, баяжуулалтын хэмжээг нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх | | | | | | | | | |
| Зорилт-2: Ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйгээр хангах, хэрэгжилтийг зохицуулах. | 22 | 6 | 2 | 8 | 2 | 2 | | 2 | 75.0 |
| Үндсэн чиг үүрэг-3: Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх. | | | | | | | | | |
| Зорилт-4: Уул уурхайн салбарын ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хэрэгжилтийг зохицуулах, байгууллагын дэргэдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороодын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах. | 1 | 1 | | | | | | | 100.0 |
| Зорилт-5: Байгаль орчныг хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын менежментийн | 1 | | | | 1 | | | | 50.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| төлөвлөлтөд үнэлэлт дүгнэлт өгөх, хэрэгжилтийг хангуулах. | | | | | | | | | |
| Зорилт-6: Уул уурхайн салбарын судалгаа, шинжилгээ, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх. | 1 | 1 | | | | | | | 100.0 |
| Дүн | 30 | 9 | 2 | 5 | 7 | 4 | | 3 | 70.37 |
| **3. Ерөнхий чиг үүргийн нэр: Газрын тосны салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.** | | | | | | | | | |
| Үндсэн чиг үүрэг-1: Газрын тосны салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах. | | | | | | | | | |
| Зорилт-1: Газрын тосны салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах. | 4 | 4 | | | | | | | 100.0 |
| Үндсэн чиг үүрэг 2: Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, нөөц тогтоох, ашиглалт, олборлолтыг нэмэгдүүлэх. | | | | | | | | | |
| Зорилт 2: Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх, эрлийн гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах, нөөц тогтоох. | 5 | | 3 | 2 | | | | | 82.0 |
| Үндсэн чиг үүрэг: 3: Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах. | | | | | | | | | |
| Зорилт 3:Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг дамжуулах хоолойн хамт барьж байгуулах. | 2 | | | 2 | | | | | 70.0 |
| Үндсэн чиг үүрэг: 4: Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах. | | | | | | | | | |
| Зорилт-4: Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг тогтвортой хангах, чанарын хяналтын | 3 | 1 | | 2 | | | | | 80.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах. | | | | | | | | | |
| Дүн | 14 | 5 | 3 | 6 | | | | | 85.0 |
| **4. Ерөнхий чиг үүргийн нэр: Хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.** | | | | | | | | | |
| Үндсэн чиг үүрэг-1: Хүнд үйлдвэрийн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах. | | | | | | | | | |
| Зорилт-1: Хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах. | 4 | 3 | 1 | | | | | | 97.5 |
| Үндсэн чиг үүрэг-2: Тэргүүний технологи, инновацийг нэвтрүүлэх, нутагшуулах, дамжуулах, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах замаар хүнд үйлдвэрийг хөгжүүлэх. | | | | | | | | | |
| Зорилт-2: Хүнд үйлдвэрлэлийг цогцолбороор хөгжүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний сүлжээг бий болгоно. | 9 | | 1 | 2 | 2 | 4 | | | 50.0 |
| Дүн | 13 | 3 | 2 | 2 | 2 | 4 | | | 64.6 |
| **5. Ерөнхий чиг үүрэг: Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, зохицуулах, хэрэгжүүлэх.** | | | | | | | | | |
| Үндсэн чиг үүрэг-1: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах. | | | | | | | | | |
| Зорилт-1: Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, аппаратын дотоод ажил болон олон нийттэй харилцах, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах. | 1 | 1 | | | | | | | 100.0 |
| Үндсэн чиг үүрэг-2: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэй боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах. | | | | | | | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Зорилт-2:Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө, боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах. | 1 | 1 | | | | | | | 100.0 |
| Үндсэн чиг үүрэг-3: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн талаар олон нийтэд сурталчилан таниулах. | | | | | | | | | |
| Зорилт-3: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн боловсруулах бусад эрх зүйн актын төсөл боловсруулах, өргөн барихад дэмжлэг үзүүлэх. | 1 | 1 | | | | | | | 100.00 |
| Үндсэн чиг үүрэг-4: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх. | | | | | | | | | |
| Зорилт-4:Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын гэрээний талаар гадаад орон, олон улсын эрх зүй, туршлагыг судлах, санал гаргах, дэмжлэг үзүүлэх. | 1 | 1 | | | | | | | 100.0 |
| Үндсэн чиг үүрэг-5: Төсвийн ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх. | | | | | | | | | |
| Зорилт-5: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, сайдын төсвийн багцыг төлөвлөх, зохицуулах, тайлагнах үйл ажиллагааг зохион | 3 | 3 | | | | | | | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| байгуулж, үйлчилгээ үзүүлэх. | | | | | | | | | |
| Дүн | 7 | 7 | | | | | | | 100.0 |
| **6. Ерөнхий чиг үүрэг: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах, хөрөнгө оруулалтын орчин, хэрэгцээ шаардлагыг судлах, бодлого, чиглэлийг тодорхойлох болон энэ чиглэлээр судалгаа шинжилгээ хийх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангахад бүх талын дэмжлэг үзүүлэх, зохицуулах, тайлагнах.** | | | | | | | | | |
| Үндсэн чиг үүрэг-1: Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын бодлого, чиглэлийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах ажлыг зохион байгуулах. | | | | | | | | | |
| Зорилт-1: Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомж, төсөл, хөтөлбөр, зөвлөмжийн төсөл боловсруулах, хэрэгжүүлэх. | 2 | 2 | | | | | | | 100.0 |
| Зорилт-2: Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийг тодорхойлох, хэрэгжилтийг зохион байгуулах. | 1 | 1 | | | | | | | 100.0 |
| Үндсэн чиг үүрэг-2: Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, судалгаа, мэдээллээр хэрэглэгчийг хангах. | | | | | | | | | |
| Зорилт-3:Хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх. | 1 | 1 | | | | | | | 100.0 |
| Зорилт-4:Салбарын хөрөнгө оруулалт, татвар, бүтээгдэхүүний худалдаа, экспортын талаар судалгаа хийх, статистик мэдээллээр хэрэглэгчийг хангах. | 2 | 2 | | | | | | | 75.0 |
| Дүн | 6 | 6 | | | | | | | 100.0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **7. Ерөнхий чиг үүргийн нэр: Хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, цахим шилжилт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ хэрэгжүүлэх ажлыг салбарын хэмжээнд нэгдсэн бодлого, удирдлага, зохицуулалтаар хангах** | | | | | | | | | |
| Үндсэн чиг үүрэг-1: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт зөвлөмж боловсруулах, сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах. | | | | | | | | | |
| Зорилт-1: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, холбогдох байгууллагуудад хүргүүлэх. | 1 | 1 | | | | | | | 100.0 |
| Зорилт-2: Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах. | 1 | 1 | | | | | | | 100.0 |
| Үндсэн чиг үүрэг-2: УУХҮЯ, АМГТГ, ҮГА-ны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн хүрээнд төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах. | | | | | | | | | |
| Зорилт-3: “Эрдэс баялгийн цахим засаглал” хөтөлбөрийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах. | 1 | 1 | | | | | | | 100.0 |
| Зорилт-4:Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд чиглэсэн үйлчилгээг цахимжуулж, түргэн шуурхай хүргэх. | 1 | 1 | | | | | | | 100.0 |
| Дүн | 4 | 4 | | | | | | | 100.0 |
| **Нийт дүн** | 100 | 52 | 8 | 18 | 10 | 8 | 0 | 4 | **82.5** |

**Дөрөв. Дүгнэлт**.

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020-2024 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан 7 ерөнхий чиг үүргийн 22 үндсэн чиг үүргийн 29 зорилт 99 арга хэмжээний 2021-2022 оны биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **82.5** хувийн биелэлттэй гэж дүгнэв.
2. Нийт 100 арга хэмжээний биелэлтийг дүгнэсэн 52 арга хэмжээ 100 хувийн хэрэгжилттэй, 8 арга хэмжээ нь 90 хувийн хэрэгжилттэй, 18 арга хэмжээ 70 хувийн хэрэгжилттэй, 10 арга хэмжээ 50 хувийн хэрэгжилттэй, 8 арга хэмжээ 30 хувийн хэрэгжилттэй, 4 арга хэмжээ үнэлэх боломжгүй байна.

**Тав. Зөвлөмж**.

1. Биелэлт нь 50, 30 хувиар дүгнэгдсэн, хэрэгжилтийн явц удаашралтай байгаа арга хэмжээг эрчимжүүлэх.
2. Хэрэгжээгүй арга хэмжээний талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэх

Жич: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2020-2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2021-2022 биелэлтэд хийсэн үнэлгээг хавсаргав.

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга Т.Баасанпүрэв

Үнэлгээ хийж, танилцуулга боловсруулсан:
ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн Д.Батнайрамдал
/2023.01.30/

# СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

## УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
## (2020-2024 ОН)

| Д/д | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө (2020-2024) | Стратеги /арга зам/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Санхүүгийн эх үүсвэр | Хэрэгжилтийн явц | | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2021 он | 2022 он | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| **1. Ерөнхий чиг үүргийн нэр: Геологийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.** | | | | | | | | | |
| **Үндсэн чиг үүрэг-1: Геологийн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих, бодлогын удирдлагаар хангах.** | | | | | | | | | |
| 1 | Зорилт-1: Геологийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах. | 1.1. Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах. | Батлуулсан хуулийн тоо | 0 | 1 | Улсын төсөв | УУХҮСайдын 2021.04.06-ны өдрийн тушаалаар Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчилэн байгуулсан. Газрын хэвлийн тухай хуулийн хэрэгцээ шаардлага болон өнөөдрийн эрх зүйн актад үнэлэлт өгөх, дүгнэлт гаргах судалгаануудыг Австрали-Монголын хамтын ажиллагааны АМЕР төслийн | Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан. Үүнд:<br>Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагын хүрээнд:<br>• Давхардал, хийдэл, зөрчлийн судалгаа хийгдсэн;<br>• Газрын хэвлийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн судалгааг хийсэн. | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | туслалцаатайгаар хууль эрх зүйчдийн 2 багтай хамтран хийсэн. | • Хуулийн төсөл боловсруулах практик үндэслэл, шаардлагыг гаргасан.<br>• Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээг тодорхойлсон.<br>• Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай саналыг тусгасан.<br>• Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон Улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох хуулийн талаарх саналыг боловсруулсан.<br>Хуулийн үзэл баримтлалын төсөл, төсөл боловсруулагдсан. Үзэл баримтлалын төслийн танилцуулга болон бусад холбогдох материалыг боловсруулж бүрдүүлэн, албан бичгээр ХЗДХЯ-д хүргүүлэхээр бэлэн болсон. | |
| 2 | | 1.2. Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах. | Батлуулсан хуулийн тоо | 0 | 1 | Улсын төсөв | УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн холбогдох судалгааг хийх, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг 2021 оны туршид | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийг УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг 2021.01.27-2021.05.21-ний өдрийг хүртэл вакуумжин ажиллах хугацаандаа Канад, Австрали, Оросын холбооны | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д “хуулийн хэрэгжилтийн үр дагаварыг үнэлэх аргачлал”-ын дагуу Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан;<br>2.Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой болон бусад судалгааны тайлан;<br>3.Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасны дагуу Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал;<br>4.Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;<br>5.Шинэчилсэн найруулгын төсөл боловсруулсантай холбогдуулан дагалдаж гарах хуулийн төслүүд;<br>6.Ашигт малтмалын тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгасан талаарх харьцуулсан судалгаа;<br>7.Одоогийн мөрдөж байгаа ашигт малтмалын тухай хуулиас шинэчилсэн найруулгад тусаагүй хасагдсан заалтын харьцуулалт, тайлбар;<br>8.Шинэчилсэн найруулгад шинээр зохицуулагдаж байгаа заалтын талаар мэдээллийг тус тус боловсруулсан.<br>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 91 дүгээр зүйл. Мэдээллийн сангийн хэлбэр, 92 дугаар | улс, Казакстан зэрэг 10 гаран улсын уул уурхайтай холбоотой хууль тогтоомжийн судалгаа хийж Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Үзэл баримтлалын хэмжээнд салбарын холбогдох мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, судлаачид болон төрийн зарим байгууллагын төлөөлөлтэй нийт 21 удаагийн уулзалт зохион байгуулж хуулийн өөрчлөлттэй холбоотой санал, үзэл санааг сонсох, нэгдсэн нэг байр сууринд хүрэх зорилт тавин ажилласан.<br>Мөн ажлын хэсгийн судлаачдын багийн гишүүдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгаа, тайланг хийсэн. Үүнд: Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үр нөлөө, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг болно. Мөн үзэл баримтлалын төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас санал авахаар хэлэлцүүлгийг зохион байгуулж байна.<br>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төслийг геологийн салбарын ТББ, аж | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зүйл. Эрдэс баялгийн салбарын мэдээллийн сангийн тогтолцоо, төрөл, 93 дугаар зүйл. Мэдээллийн сангийн бүрдэл, 94 дүгээр зүйл. Мета мэдээллийн сан, 95 дугаар зүйл. Мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг хэрэгжүүлэх байгууллага, хугацаа, 96 дугаар зүйл. Мэдээллийн санг хэрэглэгчийн эрх, үүрэг, 97 дугаар зүйл. Мэдээллийн сангийн санхүүжилт, төлбөрийн нөхцөлтэй танилцаж, холбогдох саналыг жижиг ажлын хэсэгт хүргүүлсэн. | ахуйн нэгж болон бусад холбогдох төлөөллүүдэд танилцуулж, санал авах уулзалтыг 2 удаа зохион байгуулсан. | |
| 3 | | 1.3. Үндсэн хууль болон бусад хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан геологийн салбарт мөрдөгдөж байгаа зарим хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулж, батлуулах. | Батлуулсан хуулийн тоо | 0 | 3 | Улсын төсөв | | Монгол Улсын Үндсэн хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан Газрын хэвлийн тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсон. Үүнд:<br>• Газрын хэвлийн тухай хуулийн 1 дүгээр зүйл, Газрын хэвлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийг хүчингүйд тооцсон.<br>• Мөн хуулийн 2 дугаар зүйл. “энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэж заасан байна.<br>Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг Захиргааны хэм, хэмжээний актаар олгох боломжгүй болсон тул Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулан, холбогдох УИХ-ын Байнгийн хороо, УИХ чуулганаар хэлэлцүүлэн батлуулсан. | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Барилга хот байгуулалтын яамнаас ирүүлсэн Газрын багц хуулийн төсөлтэй танилцаж Геологи, хайгуулын салбартай холбогдох хэсгүүдэд тодорхой санал боловсруулан хүргүүлсэн. Уг саналын хүрээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хориглосон хязгаарласан талбайн давхцалаар судалгааг хийж танилцуулахаар бэлтгэж байна.<br>Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсэг ЦЭК-ийн даргын тушаалаар байгуулагдсан. Ажлын хэсэг УУХҮЯ-наас гишүүнээр ажиллаж байна. Холбогдох өөрчлөлтүүд орох санал танилцуулсан. | |
| 4 | | 1.4. Геологийн салбарт мөрдөх дүрэм, журам, заавар, ангилал, норм норматив, аргачилсан зөвлөмж, мэргэжлийн нэр, индексийг боловсруулан батлуулах. | Батлагдсан эрх зүйн актын тоо | 8 | 25 | Улсын төсөв | - УУХҮСайдын 2021.07.27-ны өдрийн А/195 дугаар тушаалаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийг шинэчлэн баталж, захиргааны хэм хэмжээни актын улсын нэгдсэн санд 2021.08.05-ны өдрийн 5413 дугаарт бүртгүүлсэн.<br>- УУХҮСайдын 2021.07.27-ний өдрийн А/195 дугаар тушаалаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийг шинэчлэн баталж, захиргааны хэм хэмжээни актын улсын нэгдсэн санд 2021.08.05-ны өдрийн 5413 дугаарт бүртгүүлсэн.<br>- УУХҮСайдын 2020 оны А/321 дүгээр тушаалаар байгуулагдсан Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журамд нэмэлт, | 1.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний тухай асуудлыг Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн хуралдаанд танилцуулсан бөгөөд 2022.11.25-ны өдрийн 03 дугаар зөвлөмжид:<br>-Үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, Монгол Улсын хөгжлийн бодлогод нийцүүлэн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох асуудлыг цахим хэлбэрээр, сонгон шалгаруулалтын журмаар зохион байгуулах, тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээг тухай сум, дүүргийн нутаг дэвсгэрийн 15 хувиас хэтрүүлэхгүй байх,<br>-Нийт хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлүүдийн хэмжээнд | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Захиргааны хэм хэмжээний актын төслийг боловсруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж Ажлын хэсгийн хуралдааныг цахимаар зохион байгуулж, журмын нэмэлт, өөрчлөлтийн төсөлд санал авах тухай ТНБДаргын 2021.02.09-ний өдрийн 03/325 дугаар албан бичгийг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн. Тус байгууллагаас 2021.02.24-ний өдрийн 1/150 дугаар албан бичгээр ирсэн саналын дагуу Ажлын хэсэг хуралдсан. Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмын шинэчилсэн найруулгын төслийг Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсаны дараа шинэчилэн найруулах нь зүйтэй байна гэсний дагуу Ажлын хэсэг дэмжиж дүгнэлт гаргасан.<br>- Нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмж (мөнгө, цагаан тугалга, хар тугалга-цайр, вольфрам, молибден)-ийг ХБНГУлсын Геошинжлэх ухаан, байгалийн нөөцийн холбооны хүрээлэн буюу BGR-ийн “Монгол Улсын эрдэс баялгийн салбар дахь | хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд холбогдох байгууллагуудыг оролцуулан хяналт, шалгалтын ажлыг тогтмол зохион байгуулж, үр дүнг мэдээлэх гэж тусгуулсан.<br>2.Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Богд уул нэртэй талбайд ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах, эрх олгох асуудлыг ЗГ-ын 2022.03.09-ний өдрийн 110 дугаар тогтоол батлагдсан.<br>3.“Геологийн судалгааны төв” ТӨҮГ, “Геологийн төв лаборатори” ТӨҮГ-ийг нийлүүлэн “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ байгуулах асуудлыг ЗГ-ын 2022.08.24-ний өдрийн 317 дугаар тогтоол батлагдсан.<br>4.Эрдэнэтийн стратегийн ордын хэмжээнд байрлах Хужир, Хөх асгат, Согоот, Зөөхийн гол, Ундрах, Оюут нэртэй газарт ашигт малтмал хайх талбайн солбицлыг батлах, эрх олгох асуудлыг ЗГ-ын 2022.10.19-ний өдрийн 379 дүгээр тогтоол батлагдсан.<br>5.Дэд бүтцийн бүтээн байгуулалтад шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах талбайн солбицол батлах, эрх олгох асуудлуудыг тус тус Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн тус тус батлуулсан.<br>6. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | институцын болон боловсон хүчний чадавхийг хөгжүүлэх-II" төслийн санхүүжилтээр ШУТИС-ийн ГУУС-ийн Эрдэс баялгийн судалгаа, геомэдээлэл, сургалтын төвийн эрдэмтэн, судлаачдаар гүйцэтгүүлж геологичдын дунд олон нийтийн хэлэлцүүлгийг 2021.01.14-ний өдөр цахимаар зохион байгуулсан. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021.04.30-ны өдрийн ХХ-05 дугаар хуралдаанаар мөнгө, цагаан тугалга, хар тугалга-цайр, вольфрам, молибдений аргачилсан зөвлөмжийг хэлэлцүүлж ХХ-05-01-ХХ-05-05 дугаар зөвлөмж гарсан. Аргачилсан зөвлөмж хүлээн авах тухай УУХҮСайдын 2021.06.11-ний өдрийн А/153 дугаар тушаал батлагдсан.<br>- Бал чулуу, давс, карбонат чулуулаг, хөнгөн цагаан, лити-цези, элс хайрга, газрын ховор элементийн аргачилсан зөвлөмжийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021.06.03-ны өдрийн ХХ-07 дугаар хуралдаанаар хэлэлцүүлсэн. Аргачилсан зөвлөмж хүлээн авах тухай УУХҮСайдын 2021.07.09-ний өдрийн А/190 дугаар тушаал батлагдсан. Нийт гарсан Боть-2, 3-ыг товхимол болгон хэвлүүлж, 1000%-ийг геологичдын хүртээл болгосон.<br>- Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр АМЕР-II-ын санхүүжилтээр фосфат, манган, берилли, никель-кобальт, хромын | шинэчлэн УУХҮСайдын 2022.04.12-ны өдрийн А/67 дугаар тушаалаар батлуулж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5821 дугаарт бүртгүүлсэн.<br>7. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох тухай журмыг шинэчилэн УУХҮСайдын 2022.05.02-ны өдрийн А/87 дүгээр тушаалаар батлуулж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5828 дугаарт бүртгүүлсэн.<br>8. Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг (берилли, никель-кобальт, фосфат, манган, хром) төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмжийг УУХҮСайдын 2022 оны А/76 дугаар тушаалаар батлуулсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хайгуулын ажилд хэрэглэх аргачилсан зөвлөмжийн төслийг 2021 оны 10 дугаар сараас эхлүүлсэн ба салбарын эрдэмтдийн оролцоотойгоор боловсруулсан.<br>- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын төсөлд санал авах тухай УУХҮСайдын 2021.04.08-ны өдрийн 01/911 дугаар албан бичгээр яамдаас санал авч нэгтгэн, УУХҮСайдын 2021.04.29-ний өдрийн 01/1130 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. ЗГХЭГ-аас 2021.05.12-ны өдрийн ХЭГ/1287 дугаар албан бичгээр Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцүүлгийг зохион байгуулж дахин ирүүлэхээр материалыг буцаасан. ЗГХЭГ-аас ирүүлсэн чиглэлийн дагуу 2021.05.07, 2021.06.04-ний өдрүүдэд Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлгийг АМГТГ-ын 301 тоот өрөөнд 2 удаа зохион байгуулсан. Журмын төслийн 2 удаагийн хэлэлцүүлэгт 18 аж ахуйн нэгжийн 48 хүн оролцож санал ирүүлсэн бөгөөд саналыг судлан холбогдох өөрчлөлтийг гүйцэтгэж ЗГХЭГ-т хүргүүлсэн. | | |
| 5 | Зорилт-2:<br>Геологийн шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн хөгжлийн урт хугацааны бодлого, хууль тогтоомжийн төслийн судалгаа | 2.1. Салбарт баримтлах бодлогын баримт бичиг, хөтөлбөрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, цаашид улсын хөгжлийн урт, дунд хугацааны | Санал боловсруулах ажлын хувь | 0 | 100 | Улсын төсөв | - | 1.Улсын Их Хурлын гишүүдийн санаачилсан Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал хүргүүлсэн. | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хийх, хэрэгжилтийг хангах, салбарын үйл ажиллагааг нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах. | бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх арга хэмжээний санал, салбарт баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах | | | | | | 2.Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022.06.17-ны өдрийн А/221 дугаар тушаалаар байгуулагдсан Цөмийн энергийн тухай хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж байна. Хуулийн төслийг 2023 оны 01 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | |
| 6 | | 2.2. Салбарын хууль, эрх зүйн баримт бичгүүдэд зөрчил, давхардал, хийдэл, эрэлт хэрэгцээ, шаардлагын судалгаа хийх, судалгааны дүгнэлтэд үндэслэн салбарт шаардлагатай хууль тогтоомжийг шинэчлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах. | Санал боловсруулах ажлын хувь | 0 | 100 | Улсын төсөв | - | Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УУХҮ-ийн Дэд сайдын 2022.11.02-ны өдрийн 02/2872 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100 |
| 7 | | 2.3. Салбарын болон холбогдох бусад чиглэлийн бодлого, хөтөлбөр, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах. | Хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Улсын төсөв | - | “Монгол Улсын хилийн зурвас газрыг Улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Улсын Их хурлын тогтоолын төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг Улсын Их хурлын Байнгын хорооны 2022.11.16-ны өдрийн 05 дугаар тогтоолоор байгуулагдсан. Тогтоолын үзэл баримтлал, анхан болон эцсийн хэлэлцүүлэг Байнгын хороо болон УИХ-ын чуулганаар тус тус хэлэлцэгдсэн. Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар “Монгол Улсын | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хилийн зурвас газрыг тогтоож, улсын тусгай хэрэгцээнд авах тухай” Улсын Их Хурлын тогтоолыг эцэслэн баталсан.<br>Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд өндөр технологийн түүхий эдийн судалгаа, металл ашигт малтмалын эрлийн ажил хийх чиглэлээр: Стратегийн ашигт малтмал (ГАСАМ) төсөл, өндөр технологийн түүхий эд /газрын ховор элемент/-ийн “ӨТТЭ-1”, “ӨТТЭ-2” болон Эрэл үнэлгээний 4-н төслийг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Улсын хилийн болон тусгай хамгаалалттай газар нутагт Улсын төсвийн хөрөнгөөр хийх геологийн судалгааны ажлын талбайнуудыг урьдчилан байдлаар ялгасан.<br>Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох боломжгүй болсон тул Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулан, УИХ-ын Байнгийн хороо, УИХ чуулганаар хэлэлцүүлэн батлуулсан.<br>Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олголтын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, цаашид анхаарах зүйлс, шинээр авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын танилцуулгыг 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдөр ҮАБЗ-д танилцуулсан.<br>ҮАБЗ-ийн 2022.11.25-ны өдрийн 03 дугаар зөвлөмж албажин УУХҮЯ-д ирсэн. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Дээрх асуудлуудтай холбоотойгоор ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох ажлыг эхлүүлсэн.<br>• Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/310 дугаар тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын комисс байгуулагдаж 2022 онд 121,503 га талбай бүхий ашигт малтмалын хайгуулын 50 тусгай зөвшөөрлийг олгож Улсын төсөвт 13.9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн.<br>• 2022 оны 11, 12 дугаар сард ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг 75 талбайн хэмжээнд зарласан.<br>• 2022 оны 12 дугаар сарын 15-ны байдлаар нийт 92 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд ашиглалтын 35, сонгон шалгаруулалтаар 50, Засгийн газрын 110, 379 дүгээр тогтоолоор 7 тусгай зөвшөөрөл олгоод байна.<br><br>Хэмнэлийн тухай хууль хэрэгжүүлэхтэй уялдан ГТЛ, ГСТ-ийг нэгтгэн ГСШТ байгуулах бэлтгэл ажлыг хангаж ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн тогтоол гаргуулсан. Тус байгууллагын захирлаар Д.Мөнхбаатар 2023.01.13-ны өдөр томилогдож, тамгаа хүлээн авсан. | |
| 8 | | 2.4. Орон нутгийн удирдлага, иргэдтэй болон гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, | Хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Улсын төсөв, хувийн хөрөнгө оруулалт | - | 1. Ашигт малтмал, газрын тосны газраас 2022.03.21-ний өдрөөс эхлэн Төр, хувийн хэвшил, орон нутгийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | геологийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, геологичдын дунд чуулга уулзалт зохион байгуулах, салбарын үйл ажиллагааг сурталчлан таниулах. | | | | | | байгууллагын төлөөллүүд салбарт тулгамдсан асуудлыг нээлттэй ярилцаж, бүтээлчээр хэрэгжүүлэх зорилго бүхий “Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудал, шийдэл” уулзалт хэлэлцүүлгийг 18 аймагт зохион байгуулсан.<br><br>2. “Эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, хамтын ажиллагаа, боломж, шийдэл” Зүүн бүсийн хэлэлцүүлгийг салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ил тод, хариуцлагатай уул уурхайг төлөвшүүлэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор Сүхбаатар аймагт зохион байгуулсан.<br>3. Монголын геологи, хайгуул-2022 арга хэмжээний үеэр Орхон, Булган, Өвөрхангай, Говь-Алтай, Дархан-уул, Дорноговь, Дундговь, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Хөвсгөл, Төв зэрэг аймгуудын Засаг дарга, орлогч дарга, холбогдох хэлтсийн дарга, мэргэжилтэн, улсын байцаагч гэсэн орон нутгийн нийт 18 төлөөллийг Улаанбаатар хотод урьж, “Засаг дарга нартай санал солилцох дугуй ширээний уулзалт”-ийг зохион байгуулсан.<br><br>4. Дорноговь аймгийн Мандах сум болон 2 дугаар багийн иргэдэд Геологийн салбар, | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | геологийн судалгааны ажил, түүний онцлог, хэрэгжүүлэлтийг хангах хууль, тогтоомж зэрэг эрх зүйн байдал болон тухайн суманд гүйцэтгэж байгаа геологийн судалгааны ажлын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнгийн тухай уулзалтуудыг 2022.06.12-13-ний өдүүдэд Мандах сумын Соёлын төв болон 2 дугаар багийн Улаан шандад зохион байгуулсан. Уулзалтуудаар сумын иргэдийн асуултад хариулж, геологийн салбарыг сурталчилах ажлыг хийсэн. Мөн сумын Засаг дарга болон сумын захиргааны албан хаагчидттай уулзаж, холбогдох мэдээллээр хангаж ажилласан.<br><br>Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (ҮАБЗ)-ийн Нарийн бичгийн даргын 2022.11.11-ний өдрийн А/17 дугаар захирамжаар Ховд аймгийн Мянгад сумын нутагт орших Халзан бүрэгтэй орд газрын үйл ажиллагаатай танилцан санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг Ховд аймгийн төрийн болон төрийн бус байгууллагууд, Мянгад сумын ард иргэд, компаний төлөөлөлтэй уулзалт хийсэн. | |
| **Үндсэн чиг үүрэг-2: Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлж, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах.** | | | | | | | | | |
| 9 | Зорилт-3:<br>Бүх төрлийн геологийн судалгааны ажлыг төлөвлөх, төсвийн саналыг боловсруулах, нутаг дэвсгэрийн геологийн | 3.1. 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах. | Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь | 41% | 47% | Улсын төсөв 11,602.4 (2021) | Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын дэгдэлтээс шалтгаалан 2020 оны 11-р сараас эхэлсэн бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн онцгой нөхцлөөс хамаарч төслүүдийн үр дүнгийн тайлан боловсруулах | 1.Сүүжийн говь-50, Шүтээн улаан уул-50, Норовлин-50, Чулуун хороот-50, Галбын говь-50, Бүрхтэй уул-50, Цайлангийн нуруу-50 төслүүдийн үр дүнгийн тайлантай танилцаж ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2022.05.31, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг тодорхойлох, үнэлгээ өгөх, гүйцэтгэлийн чанарыг сайжруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих. | | | | | Улсын төсөв 11,387.4 (2022) | ажил удааширсан тул Сүүжийн говь-50, Цайлангийн нуруу-50, Шүтээн улаан уул-50, Норовлин-50, Олон гол-50, Их Өлзийт-50 төслүүдийн хугацааг УУХҮС-ын 2021.02.04-ний өдрийн А/20 дугаар тушаалаар 3-6 сарын хугацаатай сунгасан. 2016-2020 онд хэрэгжсэн Цахир мушгиа уул-50 (ЭБМЗ-ийн 2021.06.24-ний УТХ-07-01 дүгээр дүгнэлт, УУХҮС-ын 2021.08.11-ний А/218 дугаар тушаал), Олон гол-50, Номгоны нуруу-50, Худгийн нуруу-50 төслийн үр дүнгийн тайлантай танилцаж геологийн судалгааны ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэх ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан. Ингэснээр 14,278.29 км2 талбай буюу 0.91%, нийтдээ 41.97%-ийг тус судалгааны ажилд хамруулаад байна.<br>Төлөвлөгөөт онд үргэлжлэн хэрэгжих 23 төслийн хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Үүнд:<br>1.1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн үргэлжлэн хэрэгжих 23 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулсан.<br>2.Үргэлжлэн хэрэгжих 23 төслийн 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2021.03.24, 2021.03.25, 2021.03.26, 2021.03.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЭБМЗ-ийн төсөл тус бүрийн дүгнэлтийг | 06.02, 06.15-нд хэлэлцэж хүлээн авсан. Ингэснээр 29,381.83 км2 талбай буюу 1.88%, нийтдээ 43.86%-ийг тус судалгааны ажилд бүрэн хамруулаад байна. Эдгээр 7 төслийн судалгааны үр дүнд Мангирт (өнгөт металл Р2 зэргээр Cu-2298.94 тн, мөнгө-7.248 тн, алт-2.352 кг, цайр-210 тн, хартугалга-315 тн), Эрдэнэ овоо (Алт шороо Р1 зэргээр 65.5 кг), Хуурай сайр (Р2 зэргээр алт-224.19 кг), Угалзын худаг (Р2 зэргээр алт-1524.1 кг), Дөшийн ам (Р3 зэргээр алт-80 кг), Баян тохой, Цагаан толгой, Их Номгон, зэсийн Урт булаг, Ил худаг, холимог металлын Буйлст, элсний Угалзын ам, шаврын Зуух булаг (Р1 зэргээр 232.8 мян.тн), Ширээ тээг (Р1 зэргээр 26.1 сая тн), Далан шар уул (Р3 зэргээр хром-526526 тн, никель-171515 тн), Дөш уулын төмөр зэрэг ашигт малтмалын хэтийн төлөвтэй талбайг ялгасан.<br>2.2022 онд 33 төслийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:<br>•Үргэлжлэн хэрэгжих болон шинээр эхлэх нийт 33 төслийн 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулсан.<br>•Үргэлжлэн хэрэгжих 27 төслийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЭБМЗ-ийн төсөл тус бүрийн дүгнэлтийг үндэслэн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үндэслэн УУХҮСайдын 2021 оны тушаалаар баталгаажуулсан.<br>3.Улсын тусгай хэрэгцээний газарт судалгаа хийх Дөч гол-50, Өндөр ширээт-50, Борзонгийн говь-50, Зангат-50, Гилбэнт уул-50, Хайрхан овоо-50, Овоот толгой-50, Хар хайрхан-50, Их элээт уул-50, Их бэрх уул-50, Улаангом-50, Уушгийн улаан-50, Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, Торлог уул-50 төслүүдийн гүйцэтгэгч нарт дэмжлэг үзүүлэх тухай УУХҮСайдын 2021.03.18-ны өдрийн 01/620 дугаар албан бичгийг БОАЖЯ-нд, хилийн бүсэд хэрэгжүүлэх Дөч гол-50, Борзонгийн говь-50, Зангат-50, Гилбэнт уул-50, Торлог уул-50, Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, Их бэрх уул-50, Овоот толгой-50, Хар хайрхан-50 төслүүдийн гүйцэтгэгч нарт дэмжлэг үзүүлэх тухай ТНБДаргын 2021.03.18-ны өдрийн 03/634 дүгээр албан бичгийг ХХЕГ-т тус тус хүргүүлсэн.<br>4.2021 онд хэрэгжих 23 төслийн хээрийн болон суурин боловсруулалтын ажилд хээрийн шуурхай хяналт хийх төлөвлөгөө, төсвийг боловсруулан ТНБДаргын 2021.04.30-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар батлуулсан. 2021 онд хээрийн судалгааны ажилтай Хулд-50, Алагбаян-50, Халзан-Овоо-50 төслүүдэд 2021.09.16-2021.09.24-ний өдрүүдэд шуурхай хяналтыг гүйцэтгэн зөвлөмж өгч ажилласан. Мөн Индэртийн нуруу-50, Их | УУХҮСайдын 2022 оны тушаалаар баталгаажуулсан.<br>•Шинээр хэрэгжүүлэх Баянзүрх уул-50, Ханхар уул-50, Үүрэг нуур-50, Мөст уул-50, Ямбат уул-50, Овоот шар-50 нийт 6 төслийн геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайдаар батлуулсан.<br>•Хээрийн судалгааны ажилтай 4 төсөлд шуурхай хяналтыг ҮГА-тай хамтран 8-р сард хийсэн.<br>ЭБМЗ-ийн Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдааныг 2022.03.17, 2022.04.13,14,15, 20-ны өдрийн хурлаар Халзан овоо-50, Хулд-50, Оорцог уул-50, Дөч гол-50, Өндөр ширээт-50, Хайрхан овоо-50, Ширээт уул-50, Алаг баян-50, Уушгийн улаан-50, Овоот толгой-50, Торлог уул-50, Их хараат уул-50, Цэцэрлэг-50, Их элээт уул-50, Загал уул-50, Гилбэнт уул-50, Зангат уул-50, Цагаан овоо-50, Индэртийн нуруу-50, Борзонгийн говь-50, Ямаат уул-50, Буйлст хүрэн уул-50, Бөөн хөх уул-50, Хар хайрхан-50, Үнэгт уул-50, Улаангом-50, Их бэрх уул-50 төслүүдийг хэлэлцсэн.<br>•2022 оны төсөл, төсвийн тодотголын нийт 27 тэмдэглэл, 27 дүгнэлт батлагдсан.<br>•УТХ-2022-01 хурлаар хэлэлцсэн төслийн 2022 оны төсөл, төсвийн тодотголыг УУХҮСайдын 2022.05.12-ны өдрийн А/98, 99, 100, 101, 105, 2022.05.13-ны өдрийн А/110 дугаар тушаалаар баталсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хараат уул-50, Цэцэрлэг-50, Алагбаян-50, Бүрхтэй уул-50, Хулд-50, Асгат уул-50, Их элээт уул-50, Зангат-50, Бөөн хөх уул-50, Уушгийн улаан-50, Халзан овоо-50 төслүүдийн хээрийн судалгааны анхдагч материалыг 2021.11.08-2021.11.30-ны өдрүүдэд хүлээн авсан.<br>Шинээр хэрэгжүүлэх Бөөн хөх уул-50, Буйлст хүрэн уул-50, Ямаат уул-50, Загал уул-50, нийт 4 төслийн геологийн даалгаврыг боловсруулан 2021.03.15-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайдаар батлуулсан. Үүнд:<br>4 төслийн гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдүүдтэй Захиалагчаас өгсөн үүргийн дагуу 2021.06.11-ны өдрийн 14, 15, 16, 2021.07.22-ны өдрийн 25 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн.<br>Төслүүдийн 2021 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2021 оны 11-р сард хүлээн авсан. | •ГЗЕЭА-ын зарим төслийн 2022 оны төсөл, төсвийн тодотголыг батлах тухай УУХҮСайдын 2022.07.04-ны өдрийн А/187, 185, 184, 182, 181, 180, 170, 169, 168, 167, 166, 165, 164, 163, 162, 161, 160, 158, 157. 156, 155 дугаар тушаалаар тус тус баталсан.<br>•Их өлзийт-50, Түдэвтэй-50, Дэвийн хонгор уул-50, Модот толгой-50, Асгат уул-50 төслүүд (нутаг дэвсгэрийн 1.1%)-ийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. | |
| 10 | | 3.2. 1:25000-ны масштабын геологи-орчны судалгааны ажлыг гүйцэтгэх. | Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь | 0% | 0.15% | Улсын төсөв | 1:25000-ны масштабын геологийн зураглалын ажил гүйцэтгэх заавар, түүнд тавигдах шаардлагыг боловсруулахад зарцуулах төсвийг аргачлал, хяналтын зардлаас гаргахаар УУХҮЯ-ны ТНБД-ын 2021.04.30-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар батлуулсан. Заавар боловсруулах хуулийн этгээд буюу ажлын хэсгийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах асуудлыг Үндэсний геологийн албанд шилжүүлсэн. | Төрийн нарийн бичгийн даргын 2022.03.07-ны өдрийн 03/577 дугаар албан бичгээр 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглал гүйцэтгэх, түүнд тавигдах шаадлагын төслийг 2022 оны II улиралд багтаан ирүүлэх тухай албан бичгийг ҮГА-д хүргүүлсэн.<br>•Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлж байгаа Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн 2022-2023 оны санхүүгийн жилийн үйл ажиллагааны | /-/ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төлөвлөгөөнд тус зааврыг боловсруулах саналыг Санхүү хөрөнгө оруулалтын газарт 2022.04.08-ны өдрийн дотоод бичгээр хүргүүлсэн боловч дэмжигдээгүй.<br>•Үндэсний геологийн албаны дарга О.Чулуунаас 2022.07.26-ны өдрийн 1/421 дугаар албан бичгээр 1:25000-ны масштабын зураглалын ажлыг Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх, зааврыг боловсруулах нь эртэдсэн асуудал гэсэн хариуг ирүүлсэн.<br>Төсөвт 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглал гүйцэтгэх, түүнд тавигдах шаардлага боловсруулах болон масштабын геологи-орчны судалгааны ажлыг гүйцэтгэх зардал тусгагдаагүй. | |
| 11 | | 3.3. Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэж дуусах. | Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь | 14% | 100% | Улсын төсөв 1,729.9 (2021)<br><br>Улсын төсөв 1,269.2 (2022) | Монгол орны нутаг дэвсгэрийн 14.1%-ийг хамарсан К хавтгайн хэмжээнд Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх УГЗ-200-К-нэгтгэл төслийн үр дүнгийн тайлантай танилцан ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээн авсан. ЭБМЗ-ийн хуралдаанаар төслийн үр дүнг хүлээн авснаар нутаг дэвсгэрийн 14.1%-ийг 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийн нэгтгэлд хамруулсан. Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг L, M (N) хавтгайн хэмжээнд нэгтгэх төлөвлөгөөт оны ажлыг эхлүүлсэн. Үүнд:<br>1.Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг L, M | •Монгол орны нутаг дэвсгэрийн 14.1%-ийг хамарсан К хавтгайн хэмжээнд Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх УГЗ-200-К-нэгтгэл төслийн үр дүнгийн тайлантай танилцан ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын 2022 оны А/03 дугаар тушаалаар хүлээн авсан.<br>•2022 онд L хавтгайн хэмжээнд хээрийн судалгааны ажлыг бүрэн дуусган нутаг дэвсгэрийн 60%-ийг судалгаанд хамруулсан бол M хавтгайн хэмжээнд хээрийн судалгааны ажлыг үргэжлүүлэн гүйцэтгэсэн.<br>•ЭБМЗ-ийн Геологийн судалгааны асуудал хэлэлцэх | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | (N) хавтгайн хэмжээнд нэгтгэх 2 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулсан.<br>2.Үргэлжлэн хэрэгжих УГЗ-200-L, УГЗ-200-M(N) төсөл /хээрийн судалгаатай/-ийн 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2021.03.25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн баталгаажуулсан.<br>3.Улсын тусгай хэрэгцээний газар болон хилийн бүсэд судалгаа хийх УГЗ-200-L нэгтгэл төслийн гүйцэтгэгчид дэмжлэг үзүүлэх талаар хандан УУХҮСайдын 2021.03.18-ны өдрийн 01/620 дугаар албан бичгийг БОАЖЯ-нд, ТНБДаргын 2021.03.18-ны өдрийн 03/634 дүгээр албан бичгийг ХХЕГ-т илгээсэн.<br>4.2021 онд үргэлжлэн хэрэгжих 2 төслийн хээрийн болон суурин боловсруулалтын ажилд хээрийн шуурхай хяналт хийх төлөвлөгөө, төсвийг боловсруулан ТНБД-ын 2021.04.30-ны өдрийн А/41 дүгээр тушаалаар батлуулсан. Үргэлжлэн хэрэгжих төслүүдийн хээрийн судалгааны ажил цар тахлын хөл хорио, вакцинжуулалттай холбоотойгоор 6-р сарын 10-аас эхэлсэн.<br>5.УГЗ-200-L-нэгтгэл, УГЗ-200-M-нэгтгэл төслүүдийн 2021 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг | салбар хуралдааны УТХ-2022-01 дүгээр хуралдааныг 2022.03.17-ны өдөр зохион байгуулж, хурлаар Монгол орны L хавтгайн хэмжээнд хийгдсэн УГЗ-200-ын масштабтай иж бүрдэл зураг нэгтгэх "УГЗ-200-L", УТХ-2022-04 дүгээр хуралдааныг 2022.04.15-ны өдрийн хурлаар Монгол орны M хавтгайн хэмжээнд хийгдсэн УГЗ-200-ын масштабтай иж бүрдэл зураг нэгтгэх "УГЗ-200-M" төслийг хэлэлцсэн.<br>•УТХ-2022-01-10, УТХ-2022-04-05 тэмдэглэл, УТХ-01-10, УТХ-04-05 дугаар дүгнэлт батлагдсан.<br>•"УГЗ-200-L" төслийн 2022 оны төсөл, төсвийн тодотгол батлах тухай УУХҮСайдын 2022.05.12-ны өдрийн А/106 дугаар тушаал батлагдсан.<br>•"УГЗ-200-M" төслийн 2022 оны төсөл, төсвийн тодотгол батлах тухай УУХҮСайдын 2022.07.04-ний өдрийн А/177 дугаар тушаал батлагдсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2021.11.19-30-нд хүлээн авсан. | | |
| 12 | | 3.4. Агаарын геофизикийн 1:200000-ны масштабын соронзон судалгааны ажлыг зохион байгуулах. | Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь | 63% | 70% | Улсын төсөв 2,153.7 (2021)<br><br>Улсын төсөв 1,269.2 (2022) | Монгол Улсын баруун, баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд 1:200000-ны масштабтай агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг эхлүүлсэн. Үүнд:<br>1.Ховд-2020 төслийн төсөв, төлөвлөгөөг хянаж боловсруулан УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулсан.<br>2.Үргэлжлэн хэрэгжих Ховд-2020 төслийн 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2021.03.25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.<br>3.Төлөвлөгөөт онд нийт 104,044.0 кв.км буюу нутаг дэвсгэрийн 6.6%-д агаарын геофизикийн хэмжилт хийх нислэгийг хийж дуусгахаар төлөвлөн өмнөх оноос үлдсэн 28,677 тууш км-т судалгааны нислэгийг хийж дууссанаар нутаг дэвсгэрийн 1.6%-ийг хамруулсан. Төслийн ажлыг саадгүй гүйцэтгүүлэх зорилгоор дэмжлэг хүсэх тухай УУХҮСайдын 2021.03.18-ны өдрийн 01/620 албан бичгийг БОАЖЯ-нд, ТНБДаргын 2021.03.18-ны өдрийн 03/634 дүгээр албан бичгийг ХХЕГ-т хүргүүлсэн.<br>4.Хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2021.11.30-нд хүлээн авсан. | Монгол Улсын баруун, баруун өмнөд хэсгийг хамарсан талбайд 1:200000-ны масштабтай агаарын геофизикийн цогцолбор судалгааны 2022 оны хээрийн шалгах ажлын төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан.<br>•Ховд-2020 төслийн 2022 оны хээрийн ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн 2022.04.15-ны хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын А/173 дугаар тушаал батлагдсан. 2020-2021 онд нийт 104,044.0 кв.км буюу нутаг дэвсгэрийн 6.6%-д агаарын геофизикийн хэмжилт хийх нислэгийг дуусгасан. Нислэгийн ажлыг дуусгаснаар нутаг дэвсгэрийн 66%-ийг судалгаанд хамруулсан.<br>•2022 онд агаарын соронзон болон спектрометрийн өндөр эрчимжилтэй гажлуудыг 14 талбайд шалгах газрын геофизикийн хэмжилтийн ажлыг төлөвлөн, геологийн маршрут, соронзон орон ба цацраг идэвхижилийн судалгааг төлөвлөсөн хэмжээнд хийсэн. | 100 |
| 13 | | 3.5. Геохимийн 1:1000000-ын масштабын зураг зохиох ажлыг зохион байгуулах. | Нутаг дэвсгэрийн хамрагдсан хувь | 65% | 100% | Улсын төсөв 1,185.6 (2021) | Монгол орны нутаг дэвсгэрийг 1:1000000-ын масштабын геохимийн судалгааны ажилд хамруулж зураг зохиох төслийн хүрээнд 2009-2011 | 1. 2009-2011 онд МУ, БНХАУ-ын хилийн дагуу 501,909 км2 талбайд буюу 32.1%-д 1:1000000-ын масштабын геохимийн судалгааны ажилд | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улсын төсөв 125.5 (2022) | онд МУ, БНХАУ-ын хилийн дагуу 501,909 км2 талбайд хийсэн ажлыг үргэлжлүүлэн 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Геохими-2019 судалгааны талбайн нь 1,062,197.0 км2 буюу нутаг дэвсгэрийн 67.9 хувь -ийг эзлэх бөгөөд 2019, 2020 оны хээрийн судалгаагаар 60.9 хувьд дээжлэлтийн ажлыг хийсэн. Төлөвлөгөөт онд үлдсэн 7 хувийг хээрийн судалгааны ажилд хамруулахаар ажлыг эхлүүлсэн.<br>- Геохими-2019 төслийн төсөв, төлөвлөгөөг боловсруулан УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулсан.<br>- Төслийн 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2021.03.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.<br>- Улсын тусгай хэрэгцээний газар болон хилийн бүсэд судалгаа хийх Геохими-2019 төслийн гүйцэтгэгчид Төслийн ажлыг саадгүй гүйцэтгүүлэх зорилгоор дэмжлэг үзүүлэх тухай УУХҮСайдын 2021.03.18-ны өдрийн 01/620 дугаар албан бичгийг БОАЖЯ-нд, УУХҮСайдын 2021.03.18-ны өдрийн 03/634 дүгээр албан бичгийг ХХЕГ-т тус тус хүргүүлсэн. | хамрагдсан. 2019-2021 онд нутаг дэвсгэрийн үлдсэн 1,062,197.0 км2 буюу 67.9%-д хээрийн судалгаанд хамруулж дуусгаснаар хээрийн судалгааны ажлаар нутаг дэвсгэрийг 100% хамруулсан.<br>2. Геохими-2019 төслийн 2019-2021 онд гүйцэтгэсэн хээрийн судалгааны ажлын үр дүнг боловсруулах 2022 оны ажлын төсөл, төлөвлөгөөг УУХҮСайдын А/29 дүгээр тушаалаар батлуулсан.<br>ЭБМЗ-ийн УТХ-2022-04 дүгээр хуралдааныг 2022.04.15-ны өдөр зохион байгуулж 1:1000000-ны масштабын геохимийн судалгааны Геохими-2019 төслийн 2022 оны төсөл, төсвийг хэлэлцсэн.<br>УТХ-2022-04-02 тэмдэглэл, УТХ-04-02 дугаар дүгнэлтийг албажуулсан.<br>Геохими-2019 төслийн 2022 оны төсөл, төсвийн тодотгол батлах тухай УУХҮСайдын 2022.07.04-ний өдрийн А/174 дугаар тушаал батлагдсан. | |
| 14 | | 3.6. Бүс нутаг болон хотуудын геоэкологи, гидрогеологи, геотермийн судалгааны ажлыг хийх. | Хэрэгжсэн төслийн тоо | 2 | 7 | Улсын төсөв 913.9 (2021) | Төлөвлөгөөт онд үргэлжлэх Эрдэнэт, Дархан хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлыг хэрэгжүүлж эхлүүлсэн. Үүнд: | •Эрдэнэт, Дархан, Ховд хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлыг хэрэгжүүлэхээр ЭР геоэкологи-2019, ДА геоэкологи-2020, ХО | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улсын төсөв 2,437.7 (2022) | 1.“ЭР геоэкологи-2019”, “ДА геоэкологи-2020” төслийн төсөв, төлөвлөгөөг боловсруулан УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулсан.<br>2.Төслүүдийн 2021 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалттай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2021.03.25, 2021.03.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.<br>3.“ДА геоэкологи-2020” төслийн хээрийн судалгааны ажил гүйцэтгэхтэй холбогдуулан эзэмшлийн талбайд нэвтэрч дээжлэлт хийхэд дэмжлэг үзүүлэх тухай ТНБДаргын 2021.06.03-ны өдрийн 03/1408 дугаар албан бичгийг “Шарын гол” ХК, “Дархан дулааны цахилгаан станц” ТӨХК, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК, “Эрэл цемент” ХК, “НИК” ХХК-ийн Дархан НХСалбарын захиргаанд хүргүүлсэн.<br>4.Төслүүдийн 2021 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2021 оны 11 дүгээр сард хүлээн авсан.<br>Шинээр хэрэгжүүлэх Ховд геоэкологи-2021, Гүний хагарал-1 төслийн геологийн даалгаврыг боловсруулан 2021.03.15-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайдаар батлуулсан. Гүний хагарал-1 болон ХО геоэкологи-2021 төслийн гүйцэтгэгчээр шалгарсан хуулийн этгээдтэй Захиалагчаас өгсөн үүргийн дагуу 2021.06.11, 2021.07.21-ний өдрийн 17, 24 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг | геоэкологи-2021 болон Гүний хагарал-1, Гео орчин-2022 нэртэй 5 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан.<br>•ДА геоэкологи-2020, ХО геоэкологи-2021, Гүний хагарал-1 төслүүдийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн 2022.04.14, 2022.04.15, 2022.04.20-ны хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын А/107, А/172, А/175 дугаар тушаалаар батлуулан ажлыг үргэлжлүүлсэн.<br>•2022 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Гео орчин-2022, Сайншанд хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлын геологийн даалгаврыг УУХҮ-ийн Дэд сайд 2022.01.10-нд баталсан.<br>•УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганаар МУ-ын 2022 оны төсөвт тодотгол хийж УУХҮСайдын төсвийн багцад батлагдсан санхүүжилтийг 5.2 тэрбум төгрөгөөр бууруулсантай холбоотойгоор Сайншанд хотын геоэкологи, гидрогеологийн төслийг төлөвлөгөөт оноос хэрэгжүүлэх боломжгүй болсон тул УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар хассан.<br>ЭБМЗ-ийн Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдаанаар:<br>•УТХ-2022-01 дүгээр хуралдааныг 2022.03.17-ны өдөр зохион байгуулж, | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гүйцэтгэсэн Улаанбаатар геоэкологи, гидрогеологийн төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх бэлтгэл гүйцэтгээд байна. | хурлаар Эрдэнэт хотын геоэкололги, гидрогеологи, •УТХ-2022-03 дугаар хуралдааныг 2022.04.14-ний өдөр зохион байгуулж, хурлаар Ховд хотын геоэкололги, гидрогеологи, •УТХ-2022-04 (05) дүгээр хуралдааныг 2022.04.15 (20)-ны өдөр зохион байгуулж, хурлаар Дархан хотын геоэкололги, гидрогеологи төслийг тус тус хэлэлцсэн. •УТХ-2022-01-09, УТХ-2022-03-11, УТХ-2022-04-09, УТХ-2022-05-05 дугаар тэмдэглэл, УТХ-01-09, УТХ-03-11, УТХ-05-05 дугаар дүгнэлтийг батлуулсан. •Эрдэнэт хотын геоэкологи, гидрогеологийн 2022 оны төсөл, төсвийн тодотгол батлах тухай УУХҮСайдын 2022.05.12-ны өдрийн А/107 дугаартай тушаал батлагдсан. •Дархан хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны ажлын 2022 оны төсөл, төсвийн тодотгол батлах тухай УУХҮСайдын 2022.07.04-ний өдрийн А/186 дугаар тушаал батлагдсан. | |
| 15 | | 3.7. Геологийн өв, тулгуур зүсэлт, онцлог тогтоц, тектоник, минерагенийн болон геохими, геофизик, энергийн түүхий эдийн хэтийн төлөвийн сэдэвчилсэн судалгааны ажлыг хэрэгжүүлэх. | Хэрэгжсэн төслийн тоо | 1 | 6 | Улсын төсөв 1,300.0 (2021)<br><br>Улсын төсөв 2,289.4 (2022) | Монгол орны нутаг дэвсгэрийг хамарсан металлогений зураг зохиох Мета-2014 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2021.06.22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн. Тус зөвлөлийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2021.08.13-ны өдрийн А/225 дугаар тушаалаар төслийн үр дүнгийн тайланг хүлээн авсан. | Мезо-Кайнозой-2021 төслийн 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар батлуулж хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Мета-Алт-2022, БМШАМ-2022, Геологийн орчин-2022 төслийн геологийн даалгавр 2022.01.10-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайдын тушаалаар батлагдсан. Геологийн орчин-2022, БМШАМ-2022, Мета-алт-500 төслийн гүйцэтгэгчийг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Мезо-Кайнозой-2021, Гео орчин-2021 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар, геологийн даалгаврыг 2021.03.15-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайдаар батлуулсан.<br>Төслүүдийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн Мезо-Кайнозой-2021 төслийн гүйцэтгэгчтэй 2021.07.07-ны өдрийн 21 дугаартай гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн. Харин Гео орчин-2021 төслийн тендер 2 удаа амжилтгүй болсон тул 2022 оноос хэрэгжүүлэхээр шийдвэрлэн 2022 оны УУХҮСайдын төсвийн багцаар худалдан авах жагсаалт (2021.11.24 А/281)-д оруулсан. | шалгаруулах тендерийг Үндэсний геологийн алба нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу УУХҮСайдаас эрх шилжүүлсэнтэй холбоотойгоор гүйцэтгэж байна.<br>Геологийн орчин-2022, БМШАМ-2022, Мета-алт-500 төслийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг зохион байгуулах Үндэсний геологийн албаны даргын 2022 оны А-04 дүгээр тушаалаар байгуулсан. Үнэлгээний хороо ажиллаж байна. Төслүүдийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан бөгөөд төслүүдийн ажил эхэлсэн.<br>ЭБМЗ-ийн Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдааны УТХ-2022-04 дугаар хуралдааныг 2022.04.15-ны өдөр зохион байгуулж, хурлаар Ховд талбайн 1:200000-ны масштабын агаарын геофизикийн 5 сувгийн судалгааны Ховд-2020 төсөл, Монгол орны төв болон хойд хэсэгт хэрэгжүүлж байгаа Гүний хагарал, Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:500000-ны масштабтай мезозой, кайнозойн зураг зохиох төслийг хэлэлцсэн.<br>УТХ-2022-04-01-УТХ-2022-04-04 тэмдэглэл, УТХ-04-01-УТХ-04-04 дүгнэлт батлагдсан.<br>Мезо-Кайнозой-2021 төслийн 2022 оны төсөл, төсвийн тодотгол батлах тухай | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | УУХҮСайдын 2022.07.04-ний өдрийн А/176 дугаар тушаал батлагдсан.<br>Гүний хагарал-1 төслийн 2022 оны төсөл, төсвийн тодотгол батлах тухай УУХҮСайдын 2022.07.04-ний өдрийн А/175 дугаар тушаал батлагдсан.<br>Ховд-2020 төслийн 2022 оны төсөл, төсвийн тодотгол батлах тухай УУХҮСайдын 2022.07.04-ний өдрийн А/173 дугаар тушаал батлагдсан. | |
| 16 | | 3.8. ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ зэрэг гадаад орнуудтай хамтын ажиллагааны хүрээнд геологийн судалгааны ажлыг хэрэгжүүлэх. | Хэрэгжсэн төслийн тоо | 1 | 3 | Улсын төсөв 150.0 (2021)<br><br>Улсын төсөв 245.6 (2022) | МУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-ын хамтарсан төслийн 4-р үе шатны ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн салбар зөвлөлийн 2021.06.24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн. Тус зөвлөлийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын 2021.08.11-ний өдрийн А/217 дугаар тушаалаар төслийн үр дүнгийн тайланг хүлээн авсан.<br>Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-ын хамтарсан “Хойт, төв, зүүн Азийн гүний геологийн процесс ба металлогени” төслийн IV үе шатны ажлын үр дүнгийн тайланд шинжээч томилох тухай 2021.01.26-ны өдрийн №УТХ-2021/07 дугаар шийдвэрийн шинжээчээр Б.Дэлгэрцогт, Я.Бат-Ирээдүй, Ц.Минжинсор нар томилогдсон.<br>ЭБМЗ-ийн Геологийн судалгааны асуудал хэлэлцэх 2021.06.24-ний өдрийн УТХ-2021-07 дугаар хуралдаанаар Монгол Улс, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-ын хамтарсан “Хойт, төв, зүүн Азийн гүний геологийн | МУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-ын хамтарсан төслийн 5-р үе шатны ажлын 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаал батлагдаж, төслийн хээрийн болон суурин боловсруулалтын ажлын төсөл, төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн 2022.04.13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын А/159 дүгээр тушаалаар батлуулсан. Батлагдсан төсөв, төслийн дагуу 2022 оны хээрийн болон завсрын суурин боловсруулалтын ажлыг үргэлжлүүлэн хээрийн материалыг 2022.11.15-нд хүлээн авснаар төслийн ажлын явц 62%-д хүрсэн.<br>ЭБМЗ-ийн Геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдааны УТХ-2022-02 дугаар хуралдааныг 2022.04.13-ны өдөр зохион байгуулж, хурлаар МУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-ын хамтарсан Хойд, төв, зүүн азийн гүний геологийн процесс ба металлогени төслийг хэлэлцсэн. УТХ-2022-02-04 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | процесс ба металлогени" төслийн IV үе шатны ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэж, ЭБМЗ-ийн УТХ-2021-07-02 хурлын тэмдэглэл, УТХ-07-02 дугаартай дүгнэлтийг албажуулсан. Тухайн тайланг хүлээн авах тухай УУХҮСайдын 2021.08.11-ний өдрийн А/217 дугаартай тушаалыг баталсан.<br>Төслийн V үе шатны ажлын гүйцэтгэгч шалгаруулах сонгон шалгаруулалтын үр дүнд Геологийн судалгааны төв ТӨҮГ шалгарч "Геологийн судалгааны ажил гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний гэрээ"-г ТНБДаргатай 2021.07.21-ний өдрийн 23 дугаар гэрээг байгуулсан.<br>"Эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Байгалийн нөөц, баялгийн яам хоорондын харилцан ойлголцлын Санамж бичиг"-ийн төсөлд хятадын талаас ирүүлсэн саналыг тусган 2021.10.07-ны өдөр хүргүүлсэн бөгөөд санамж бичгийг хоёр тал эцэслэн тохироод байна. Санамж бичигт гарын үсэг зурах ёслолыг цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан Улаанбаатар дахь БНХАУ-ын ЭСЯ-д эсвэл Бээжин дэх Монгол Улсын ЭСЯ-д гарын үсэг зурах эрх олгон зохион байгуулахаар төлөвлөж байна.<br>Монгол Улсын УУХҮЯ болон БНСУ-ын Геологи, эрдэс баялгийн хүрээлэн хооронд хамтран ажиллах тухай | тэмдэглэл, УТХ-02-04 дүгнэлт батлагдсан.<br>Хойд, төв, зүүн азийн гүний геологийн процесс ба металлогени төслийн 2022 оны төсөл, төсвийн тодотгол батлах тухай УУХҮСайдын 2022.07.04-ний өдрийн А/159 дугаар тушаал батлагдсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Харилцан ойлголцлын Санамж бичгийн төсөлд холбогдох саналыг тусган боловсруулж 2021.10.28-ны өдөр БНСУ-д суугаа Монгол Улсын ЭСЯ-нд цахим шуудангаар хүргүүлэв. Хариуг хүлээж байна.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, БНЭУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлд санал авах тухай УУХҮСайдын 2021.10.07-ны өдрийн 01/2416 дугаартай албан бичгээр ГХЯ-д хүргүүлсэн. ГХЯ-аас 2021.10.28-ны өдрийн 09/4798 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналыг тусган дахин хүргүүлсэн.<br>УУХҮСайд Г.Ёндон Бүгд Найрамдах Польш Улсын Сеймийн дэд дарга Малгожата Гошевска тэргүүтэй төлөөлөгчдийг 2021.11.23-ны өдөр УУХҮЯ-д хүлээн авч уулзсан албан уулзалтыг зохион байгуулав. Польшийн талаас БНПУ-ын Сеймийн дэд дарга Малгожата Гошевска, Уур амьсгал, байгаль орчны дэд сайд Пиотр Джиаджио, БНПУ-ын Элчин сайд Крзыштоф Бойко болон Уур амьсгал, байгаль орчны яам, Улсын Геологийн алба, КГХМ компаний төлөөлөгчид оролцсон. Уулзалтын тэмдэглэлийн хувийг УИХ-ын Тамгын газарт хүргүүлсэн. Айлчлалын үеэр КГХМ компаний төлөөлөгчид үйлчлэх унаагаар хангаж, зочдын VIP танхимын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зөвшөөрөл, Эрдэнэт үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцахтай холбогдуулан 2021.11.10-ны өдрийн 02/2735, 2021.11.17-ны өдрийн 04/2824, 2021.11.12-ны өдрийн 04/2779 дугаартай албан бичгийг боловсруулан хүргүүлж, Засгийн газрын авто баазтай Автомашинаар үйлчлүүлэх тухай гэрээг байгуулсан.<br>Монгол Улс, Бүгд Найрамдах Польш улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Монгол Улсын геологийн салбарт хамтран ажиллах тухай УУХҮЯ-ны харьяа Үндэсний геологийн алба, Польш улсын Геологийн хүрээлэн-Үндэсний судалгааны хүрээлэнгийн хооронд байгуулах харилцан ойлголцлын “Санамж бичиг”-ийн төслийг Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолын дагуу гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан санамж бичгийг үйлдэх зөвшөөрлийг авч 2021.11.24-ний өдөр Санамж бичгийг Улаанбаатар хотноо үйлдсэн. Санамж бичиг байгуулах удирдамжийг 2021.07.09-ний өдөр ТНБДаргаар батлуулж Засгийн газрын 2017 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”-ын 8.2-т заасны дагуу холбогдох газарт бүртгүүлсэн болно. | | |
| 17 | | 3.9. Гадаад орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг Геологийн | Хэрэгжилтийн хувь | 0 | 100 | Улсын төсөв, гадаадын зээл тусламж | - | 1.Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | албадтай хамтын ажиллагааг сэргээх, харилцан үр ашигтай төсөл хэрэгжүүлэх санал боловсруулах, хэрэгжилтийг хангах | | | | | | 2022-2023 оны санхүүгийн жилд хэрэгжих үйл ажиллагаанд Ашигт малтмалын ордыг цогц байдлаар судлан дагалдах бүрдвэрийн нөөцийг тооцоолоход мөрдөх аргачилсан зөвлөмжийн төсөл боловсруулах, 1:25000-ны масштабын нарийвчилсан геологийн зураглалын ажлыг гүйцэтгэх заавар, түүнд тавих шаардлага боловсруулах, Орон нутаг, олон нийтэд зориулсан нөлөөллийн аян, контент үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа авах саналыг 2022.04.08-ны өдөр СХОГ-т хүргүүлсэн.<br>2.ХБНГУ-ын санхүүжилтээр хэрэгжиж байгаа Эрдэс баялгийн тогтвортой удирдлагын зөвлөх үйлчилгээний төсөлд 2021 онд өгсөн саналын дагуу Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангиллыг тухайн төрлийн ашигт малтмалд хэрэглэх аргачилсан зөвлөмжийг гүйцэтгэгчээр ажиллах боломжтой салбарын эрдэмтэн, судлаачдын нэрсийг ГБГ-ын Даргын 2022.05.25-ны өдрийн 05/1509 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>3.БНСУ-ын Газар, тээврийн яамны буцалтгүй тусламжаар 2021-2024 онуудад Зүүн Азийн орнуудын төмөр замыг хөгжүүлэх, шинээр баригдах төмөр замын чиглэлүүдийн ачаа тээврийн эргэлт, ачааллыг тооцоолох төсөл хэрэгжинэ. Энэ хүрээнд БНСУ-ын Геологийн шинжлэх | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ухаан, эрдэс баялгийн хүрээлэн болон Монгол Улсын Үндэсний геологийн алба хооронд хамтран ажиллах гэрээ байгуулахтай холбогдуулан саналыг УУХҮСайдын 2022.05.16-ны өдрийн 01/1412 дугаар албан бичгээр ҮГА-д хүргүүлсэн.<br>4.Австрали Улсын Гадаад харилцааны яамтай хийх зөвлөлдөх уулзалтын ярианы сэдэв, АНУ-ын Вашингтон хотноо зохион байгуулагдах “Монголын худалдаа, хөрөнгө оруулалт, өв соёлын өдрүүд”, Канад Улсын Торонто хотноо зохион байгуулагдах PDAC буюу ОУ-ын уул уурхайн чуулга уулзалт, ИБУИНВУ-д зохион байгуулагдах хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын ярианы сэдэвт холбогдох саналыг боловсруулж, ГХАХ-т 2022.01.17-нд хүргүүлсэн.<br>5.Геологи, ашигт малтмалын салбарт хамтран ажиллах тухай БНЭУ-ын Уул уурхайн яам болон МУ-ын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт холбогдох саналыг 2022.01.28-нд ГХАХ-т хүргүүлсэн.<br>6.Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд ажлын хүрээнд гадаад улс, орнуудад суугаа дипломат төлөөлөгчийн газруудаар хийлгэх судалгаанд холбогдох саналыг боловсруулж, ГХАХ-т 2022.02.09-нд хүргүүлсэн. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 7.Эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Бүгд найрамдах Чили Улсын Уул уурхайн яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийн төсөлд холбогдох саналыг боловсруулж, ГХАХ-т 2022.02.21-нд хүргүүлсэн.<br>8.Гадаад харилцааны яам, Канад улсын Гадаад хэргийн яам хоорондын зөвлөлдөх уулзалтад холбогдох саналыг ГХАХ-т 2022.03.04-нд хүргүүлсэн.<br>9.Уул уурхайн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийн Хамтын ажиллагааны хүрээнд холбогдох саналыг ГХАХ-т 2022.05.02-нд хүргүүлсэн.<br>10.Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Франц Улсын Европ, гадаад хэргийн яам хоорондын зөвлөлдөх уулзалтын төлөвлөгөөний биелэлтийг ГХАХ-т 2022.05.10-нд хүргүүлсэн.<br>11.Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд байгуулсан Стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд хийж гүйцэтгэх ажлын хэрэгжилтийн тайлан, УУХҮ-ийн Дэд сайд О.Батнайрамдалын Канадын Ванкувер хотноо 2022.02.01-ний өдөр болох "Mining in | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Changing and Challenging Climate Conditions: Regional Trends, Innovations and Opportunities'' сэдвээр болох цахим уулзалтын ярианы сэдэвт тусгах геологийн салбарын мэдээлэл, төслийн саналыг ГХАХ-т, АНУ-аас хөрөнгө оруулах боломжтой Геологийн судалгааны төслтэй холбоотой саналыг бэлтгэн СХОГ-т хүргүүлсэн.<br>12.АНУ-ийн элчин сайдын яамны ахлах Д.Ричмондтой Эрдэс баялгийн аюулгүй байдлын түншлэл сэдвээр уулзалт хийж харилцан санал солилцсон.<br>13.Чехийн геологийн яамны төлөөлөлтэй 2022.10.13-нд уулзалт хийж 2 яам хоорондын харилцааг сайжруулах, ЗГ хоорондын санамж бичиг байгуулах талаарх санал солилцсон.<br>14.Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын 2022.11.11-ний өдрийн хуралдаанд оролцсон.<br>15.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хамтран ажиллах хэлэлцээрийн төсөл, Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төсөлтэй тус тус танилцаж, холбогдох саналыг ГХАХ-т 2022.10.31-ний өдөр хүргүүлсэн.<br>16.Бүгд Найрамдах Солонгос Улс болон Монгол Улс | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хоорондын хамтын ажиллагааны хүрээнд уул уурхайн салбарын тогтвортой хөгжил, зам тээврийн хөгжлийн стратеги, ашигт малтмалын нөөц ба цаашдын чиг хандлага гэсэн сэдвийн дор 2022 оны 12 дугаар сард зохион байгуулсан хуралд УУХҮЯ-аас танилцуулах илтгэлийг бэлтгэсэн. | |
| 18 | | 3.10. ЭБМЗ-ийн геологийн судалгааны асуудал хэлэлцэх салбар хуралдааны дүгнэлтэд үндэслэн үр дүнг хүлээн авах | Хүлээн авсан ажлын тоо | 5 | 50 | Улсын төсөв | 2021 онд хэрэгжих 53 төслөөс шинээр эхлэх 15 төслийн геологийн даалгаврыг 03.15-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2021.03.19-ний өдөр зарласан шалгаруулалтын ажлаас 11 төслийн гүйцэтгэгч шалгарсан бөгөөд зөвлөх үйлчилгээний 14-17, 19-21, 23-25 дугаар гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн. Төлөвлөгөөт онд үргэлжлэн хэрэгжиж байгаа 38 судалгааны ажлын төсөв, төлөвлөгөөний тодотголтой танилцан 03.25-03.29-нд ЭБМЗ-өөр хэлэлцүүлсэн. Дээрх 38 төслийн 1-10 дугаар сарын ажлын гүйцэтгэлийг ҮГА-аас ирүүлсэн. Мөн Үндэсний Геологийн албанаас 2020 онд гүйцэтгэсэн 52 төслийн жилийн тайланг нэгтгэн 2021.01.08-нд ирүүлсэн. 2021 онд үр дүнгийн тайлантай 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн 9 төслийн үр дүнг хүлээн авснаар нутаг дэвсгэрийн геологийн тогтоцыг судлан зураглаж, ашигт малтмалын тархалт, хэтийн төлөвийг тодорхойлж, | УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн улсын төсвийн болон хайгуулын ажлын тайлан, нөөцийн тооцоо хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдааныг зохион байгуулсан. Үүнд:<br>Улсын төсвийн хуралдаан 8 удаа<br>Хувийн хөрөнгийн хуралдаан 17 удаа<br>Өргөтгөсөн хуралдаан 2 удаа.<br>•Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд үргэлжлэн хэрэгжиж байгаа 42 геологийн судалгааны ажлын төсөв, төлөвлөгөөний тодотголтой танилцан 2022.03.17-2022.03.25-нд ЭБМЗ-ийн улсын төсвийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн. Мөн 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын Чулуун хороот-50, Норовлин-50, Сүүжийн говь-50, Шүтээн улаан уул-50, Бүрхтэй уул-50, Галбын говь-50, Түдэвтэй-50, Цайлангийн нуруу-50, Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологийн судалгааны УБ-геожкологи-2017 төслийн үр дүнгийн тайлантай танилцаж ЭБМЗ-ийн 2022.05.29, 2022.06.03- | 100 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | металл болон металл бус ашигт малтмалын хувирсан бүс, эрдэсжсэн цэг, илрэлийг тогтоосон байна.<br>Чулуун хороот-50, Түдэвтэй-50, Дэвийн хонгор уул-50, Модот толгой-50, Бүрхтэй уул-50, Асгат уул-50, ГАСАМ төслийн суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тооцоололтой танилцан 2021.03.25, 03.29-ний өдрийн ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн.<br>Төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 12 (1:50000-ны масштабын ГЗЕЭА-ын 11, ашигт малтмалын эрэл үнэлгээний 1 төслийн хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 11.08-11.29-ний өдрүүдэд хүлээн авсан.<br>Улсын төсвийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжих:<br>-1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн үр дүнгийн тайлан зохиох 6, хээрийн судалгааны ажилтай 23, шинээр эхлэх 4,<br>-Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох 2,<br>-Сэдэвчилсэн судалгааны ажлын үр дүнгийн тайлан зохиох 1, хээрийн судалгааны ажилтай 6, шинээр эхлэх 7,<br>-Геологийн мэдээллийн сангийн чиглэлээр эхлэх 3,<br>-Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр эхлэх 1, нийт 53 төслийн ажилд хээрийн шуурхай хяналт хийх төлөвлөгөө, төсвийг ТНБДаргын 2021.04.30-ны өдрийн А/41 | ны хуралдаанд тус тус оролцож Чулуун хороот-50, Норовлин-50, Сүүжийн говь-50, Шүтээн улаан уул-50 төслүүдийн үр дүнг хүлээн авсан.<br>•Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын 64 тайланг хэлэлцэх 10 удаагийн ЭБМЗ-ийн салбар хуралдааныг зохион байгуулсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дугээр тушаалаар батлуулсан. Дэлхий нийтийг хамарсан Ковид-2019 цар тахлын тархалт, хөл хорио, вакцинжуулалтаас хамаарч 2021.05.20-ноос эхлэн геологийн судалгааны хээрийн ажил эхэлсэн. Төлөвлөгөөт оны 2-р улирлын сүүлийн сард төлөвлөсөн хээрийн шуурхай хяналтын ажлыг Хулд-50, Алагбаян-50, Халзан-Овоо-50, Борзонгийн говь-50 төслүүдийн хээрийн судалгааны ажлын гүйцэтгэлтэй уялдуулан 9 сард хийж, ажлын явцыг шалган, зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажилласан. Дээрх төслүүдийн хээрийн судалгааны ажлыг 11дүгээр сард хүлээн авсан. | | |
| **Үндсэн чиг үүрэг-3: Геологи-хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлж, эрдэс баялгийн нөөцийг өсгөх.** | | | | | | | | | |
| 19 | Зорилт-4: Ашигт малтмалын геологи-хайгуулын ажлын хэмжээг нэмэгдүүлэх, улсын эрдэс баялгийн нөөцийг өсгөх ажлыг зохион байгуулах, хяналт тавих. | 4.1. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн суурь судалгааны ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх. | Хэрэгжсэн төслийн тоо | 1 | 3 | Улсын төсөв 544.9 (2021)<br><br>Улсын төсөв Батлагдсан: 1,087.3<br><br>Гүйцэтгэл: 969.7<br><br>Санхүүжилт: 969.7 (2022) | Төлөвлөгөөт онд үр дүнгийн тайлан боловсруулах ГАСАМ төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулж ажлыг эхэлсэн. Төслийн 2021 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалтай танилцан хянаж ЭБМЗ-ийн 2021.03.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Төслийн суурин боловсруулалтын ажил үргэлжлэн хийгдэж байна.<br>Өндөр технологийн түүхий эдийн ӨТТЭ-1-2021 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар, геологийн даалгаврыг УУХҮ-ийн Дэд сайд 2021.03.15-ны өдөр | 1. 2022 онд хэрэгжүүлэх өндөр технологийн түүхий эд /газрын ховор элемент/-ийн ӨТТЭ-1-2021, ӨТТЭ-2-2022 төслүүдийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар баталсан.<br>2. ӨТТЭ-1-2021 төслийн 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан.<br>3. Шинээр хэрэгжүүлж эхлэх өндөр технологийн түүхий эдийн судалгаа /ӨТТЭ-2-2022/-ны геологийн даалгаврыг 2022.01.20-ны | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | баталсан. Төслийн ажлыг эхлүүлсэн бөгөөд 2021 оны хээрийн анхдагч баримт материалыг хүлээн авсан. Тус төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн 2021.07.07-ны өдрийн 22 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн. | өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан.<br>4. ӨТТЭ-2-2022 төслийн гүйцэтгэгчтэй зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.06.10-нд байгуулан хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн.<br>5. Дээрх 2 төслийн 2022 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг ҮГА-тай хамтран 2022.11.15-17-ны өдрүүдэд хүлээн авсан. | |
| 20 | | 4.2. Үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл болон металл бус ашигт малтмалын нарийвчилсан, эрэл, үнэлгээний ажил хийх, хэтийн төлөвийн үнэлгээ өгөх. | Хэрэгжсэн тслийн тоо | 1 | 3 | Улсын төсөв 7,049.6 (2021)<br><br>Улсын төсөв Батлагдсан: 8,560.0<br><br>Гүйцэтгэл: 8,560.0<br><br>Санхүүжилт: 8,560.0 (2022) | ЭҮ-1-2020 болон БӨМ-Алт-2019 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар батлуулж ажлыг эхлүүлсэн. Төслийн 2021 оны суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-ийн 2021.03.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Төслүүдийн ажил үргэлжлэн хийгдэж байна.<br>- ЭҮ-2-2021, ЭҮ-3-2021 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар, геологийн даалгаврыг УУХҮ-ийн Дэд сайд 2021.03.15-ны өдрийн тушаалаар баталсан. 2 төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үнэлгээний хорооны зөвлөмжийг үндэслэн 2021.07.07-ны өдрийн 19, 20 дугаар зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажлыг эхлүүлсэн. ЭҮ-2 төслийн 2021 оны хээрийн анхдагч баримт материалыг хүлээн авсан. | 1. Эрэл үнэлгээ-1-2020, Эрэл үнэлгээ-2-2021, Эрэл үнэлгээ-3-2021, Эрэл үнэлгээ-4-2022 болон БӨМ-Алт-2019 төслийн 2022 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, 2022 оны хээрийн болон суурин боловсруулалтын ажлын хэмжээ, арга, аргачлалыг ЭБМЗ-өөр хэлэлцсэн хуралдааны дүгнэлтийг үндэслэн УУХҮСайдын шийдвэрээр баталгаажуулсан.<br>2.Төлөвлөгөөт онд шинээр хэрэгжүүлэх Эрэл үнэлгээ-4-2022 төслийн геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайд баталсан.<br>3.Эрэл үнэлгээ-4-2022 төслийн гүйцэтгэгчтэй геологийн судалгааны ажлын ажлын зөвлөх үйлчилгээний гэрээг 2022.06.10-нд байгуулан судалгааны ажлыг эхлүүлсэн.<br>4.Төслүүдийн 2022 оны хээрийн судалгааны ажилд шуурхай хяналтыг 8-9 дүгээр сард хийсэн.<br>5. Эрэл үнэлгээ-2-2021, Эрэл үнэлгээ-3-2021, Эрэл үнэлгээ-4-2022 төслүүдийн 2022 оны | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг 2022.11.15-21 сард хүлээн авсан. | |
| 21 | | 4.3. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын талбайн хил, заагийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах. | Хил зааг нь батлагдсан ордын тоо | 8 | 16 | Улсын төсөв | Стратегийн ач холбогдол бүхий 7 ордын материалыг бүрдүүлж, судалж байна. Энэхүү 7 ордын материалд дүн шинжилгээ хийж, талбайн хил зааг тогтоох шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлохоор ажиллаж байна. Ордуудын талбайн хил заагийг тогтоох саналыг бэлтгэж эхэлсэн. | УИХ-ын 2007 оны 27 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын 8 ордын талбайн хил заагийг тогтоох бэлтгэл ажлыг гүйцэтгэж, талбайн хил заагийг тогтоон түүний газар зүйн солбицолыг тодорхойлсон хувилбарыг бэлтгэн яамд руу санал авахаар бэлэн болсон боловч Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд “Стратегийн ач холбогдол бүхий орд”-ын тодорхойлолт өөрчлөгдсөнтэй уялдан тухайн асуудлыг Засгийн газарт өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх асуудал тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон. | 70 |
| 22 | | 4.4. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн хил, заагийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах. | Хил заагийг батлуулах ажлын хувь | 0 | 100 | Улсын төсөв | АМГТГ-аас Засгийн газрын 2018 оны 243 дугаар тогтоолоор батлагдсан ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтаар олгох нийт талбайгаас 3.5 сая гектар талбайг хасаж, хэтийн төлөв бүхий улсын төсвийн хөрөнгөөр эрэл, хайгуулын шатны ажил хийгдсэн эрдсийн хуримтлалтай 2.3 сая гектар талбайг нэмж Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэх тухай ТНБДаргын 2021.04.29-ний өдрийн 03/1133 дугаар албан бичгийг АМГТГ-т хүргүүлсэн. Ашигт малтмалын тухай | 1.Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.11-д заасны дагуу Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоолоор баталсан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн хэмжээнд Үндэсний геологийн алба геологи-ашигт малтмалын шалгуур үзүүлэлтэд үндэслэн сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох 408 талбайг ялгаж тогтоосон.<br>2. Монгол Улсын Ерөнхий сайдад говийн аймгийн иргэдийн гаргасан хүсэлтийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгох асуудал тодорхойгүй | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хуулийн шинэчилсэн найруулга, Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын шинэчилсэн найруулгатай холбогдуулан Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгох талбайн хил заагийг 2022 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна. | хугацаагаар түдгэлзүүлсэн байна.<br>3. Дорноговь аймгийн Улаанбадрах сумand “Эрдэнэс Монгол” ХХК-д ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох асуудлаар материал бүрдүүлж, тогтоолын төслийг хүргүүлсэн ба ЗГ-ын 2022.03.09-ны өдрийн 110 дугаар тогтоолоор батлагдсан.<br>4. Орхон, Булган аймгийн нутагт орших Эрдэнэтийн зэс-молбдений ордын хил заагт орших Хужир, Хөх асгат, Согоот, Зөөхийн гол, Ундрах, Оюут нэртэй 99551.54 г ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох асуудлаар 2022.06.03-ны өдрийн 01/1593 дугаар албан бичгээр ХЗДХЯ-д тодруулга, тайлбар хүргүүлсэн. Тус асуудал нь 2022.10.19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэгдэн 379 дүгээр тогтоолоор баталгаажсан байна. | |
| 23 | | 4.5. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлэх. | Олгосон тусгай зөвшөөрлийн тоо | 33 | 230 | Улсын төсөв 73,700.0 (2021) | УУХҮСайдын 2018.02.13-ны өдрийн А/28 дугаар тушаалаар батлагдсан “Сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох журам”-ын дагуу 2021 онд СШ-48, СШ-49, СШ-50, СШ-51, СШ-52, СШ-53, СШ-54, СШ-55, СШ-56, СШ-57, 10 багц талбай зарлаж, холбогдох үнэлгээ дүгнэлтийг гаргасан.<br>2021 онд Нийт 70 талбай олгож Улсын төсөвт 16 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөсөн. Сонгон шалгаруулалтын үйл | 1.Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.11-д заасны дагуу Засгийн газрын 2017 оны 243 дугаар тогтоолоор баталсан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн хэмжээнд Үндэсний геологийн алба геологи-ашигт малтмалын шалгуур үзүүлэлтэд үндэслэн сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох 408 талбайг ялгаж тогтоосон.<br>2. Монгол Улсын Ерөнхий сайдад говийн аймгийн иргэдийн гаргасан хүсэлтийн дагуу хайгуулын тусгай | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагааг тогтмол, түргэн шуурхай явуулсны үр дүнд 102 талбайг олгож 29 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлээд байна.<br>2021 оны 11-р сард СШ-58, СШ-59 зарлаж оролцох хүсэлтэй аж ахуйн нэгжүүдийн техникийн болон үнийн саналыг хүлээн авч байна.<br>СШ-48, СШ-49, СШ-50 дугаар сонгон шалгаруулалтаар 13 тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд СШ-50, СШ-51 дугаар сонгон шалгаруулалтаар 12 тусгай зөвшөөрөл олгохоор хуульд заасан үйл ажиллагааг явуулж байна.<br>Өмнөх оны тоон үзүүлэлттэй харьцуулахад 43%-иар өссөн байна. | зөвшөөрлийг шинээр олгох асуудал тодорхойгүй хугацаагаар түдгэлзүүлсэн байна.<br>3. Дорноговь аймгийн Улаанбадрах суманд “Эрдэнэс Монгол” ХХК-д ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох ЗГ-ын 2022.03.09-ний өдрийн 110 дугаар тогтоол батлагдсан.<br>4. Орхон, Булган аймгийн нутагт орших Эрдэнэтийн зэс-молбденийн ордын хил заагт орших Хужир, Хөх асгат, Согоот, Зөөхийн гол, Ундрах, Оюут нэртэй 99551.54 га ашигт малтмал хайх талбайн солбицол батлах, эрх олгох ЗГ-ын 2022.10.19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэгдэн 379 дүгээр тогтоолоор батлагдсан. | |
| 24 | | 4.6. Ашигт малтмалын хайгуулын ажлыг эрчимжүүлж, геологийн нөөцийг өсгөх. | Улсын нөөцийн бүртгэлд бүртгэгдсэн ордын тоо | 2,250 | 2,330 | Хувийн хөрөнгө оруулалт | • Алт (Үндсэн): 9 орд:<br>• Алт (шороо) 31 орд:<br>• Мөнгө: 1 орд<br>• Зэс: 2 орд,<br>• Төмөр: 3 орд,<br>• Никель: 1 орд,<br>• Гянтболд (үндсэн): 2 орд,<br>• Манган: 2 орд,<br>• Хайлуур жонш: 11 орд,<br>• Нүүрс (чулууны үетэй): 7 орд<br>• Шохойн чулуу: 3 орд,<br>• Барилгын чулуу (дайрга): 16 орд<br>• Бал чулуу: 1 орд<br>• Гөлтгөнө: 1 орд<br>• Шавар: 3 орд<br>• Элс хайрга: 4 орд<br>• Элс: 7 орд:<br>• Элсэн чулуу: 4 орд<br>• Занар: 1 орд<br>• Гантиг: 1 орд<br>• Газрын тос: 1 орд | • Алт (Үндсэн): 8 орд:<br>• Алт (шороо) 20 орд:<br>• Зэс: 2 орд,<br>• Төмөр: 3 орд,<br>• Хайлуур жонш: 8 орд,<br>• Нүүрс (чулууны үетэй): 9 орд<br>• Шохойн чулуу: 2 орд,<br>• Барилгын чулуу (дайрга): 12 орд<br>• Боржин: 3 орд<br>• Өнгөлгөөний чулуу 1 орд<br>• Шавар: 1 орд<br>• Элс хайрга: 5 орд<br>• Элс: 3 орд:<br>• Элсэн чулуу: 1 орд<br>• Гантиг: 1 орд<br>• Кварц: 1 орд<br>• Цахиур: 1 орд | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | • Цагаантулга: 1 орд<br>• Лити: 1 орд<br>• Молибдени: 1 орд<br>Кварц: 1 орд | | |
| **Үндсэн чиг үүрэг-4: Геологи, эрдэс баялгийн үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх.** | | | | | | | | | |
| 25 | Зорилт-5: Геологийн салбарын нэгдсэн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, хөгжүүлэх, хуулиар зөвшөөрөгдсөн мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй болгох ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг зохицуулах, хяналт тавих. | 5.1.Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг бүх төрлийн геологийн судалгааны ажлын үр дүнгийн мэдээллээр баяжуулах, бүрдүүлэх, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах. | Хэрэгжсэн төслийн тоо | 1 | 2 | Улсын төсөв 350.0 (2021)<br><br>Улсын төсөв 800.0 (2022) | Геомэдээллийн дэд сангуудад нэмэлт баяжуулалт хийх, мэдээллийн сан бүрдүүлэх заавар, загвар боловсруулах сэдэвчилсэн судалгааны ажлын үр дүнгийн тайланд шинжээч томилох тухай 2021.02.05-ны өдрийн №УТХ-2021/10 дугаар шийдвэрийн дагуу шинжээчээр Т.Кульжамиш, Б.Энхтуяа, Д.Бямбадэмбэрэл нар томилогдсон.<br>ЭБМЗ-ийн Геологийн судалгааны асуудал хэлэлцэх 2021.06.24-ний өдрийн УТХ-2021-07 дугаар хуралдаанаар Геомэдээллийн дэд сангуудад нэмэлт баяжуулалт хийх, мэдээллийн сан бүрдүүлэх заавар, загвар боловсруулах сэдэвчилсэн судалгааны ажлын үр дүнгийн тайланг хэлэлцэж, ЭБМЗ-ийн УТХ-2021-07-03 хурлын тэмдэглэл, УТХ-07-03 дугаартай дүгнэлтийг албажуулсан. Тухайн тайланг хүлээн авах тухай УУХҮСайдын 2021.08.11-ний өдрийн А/216 дугаар тушаал батлагдсан.<br>Геологийн баримт-1 төслийн 2021 оны төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2020 оны А/322 дугаар тушаалаар, геологийн даалгаврыг УУХҮ-ийн Дэд сайд 2021.03.15-ны өдөр баталсан.<br>Геологийн баримт-1 төслийн тендер 1 удаа амжилтгүй болсон бөгөөд Үндэсний геологийн албанаас | 2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх Геологийн баримт-1-2022 төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дугээр тушаалаар, геологийн даалгаврыг 2022.01.20-ны өдөр УУХҮ-ийн Дэд сайдын тушаалаар баталсан. Төслийн судалгааны ажлын анхдагч материалыг 2022.11.30-нд хүлээн авсан. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Тагнуулын ерөнхий газарт хандан геологийн мэдээллийг боловсруулах энэхүү төслийг өөрсдийн хүчээр хийх хүсэлт гаргасантай холбогдуулан тендерийг зогсоосон. Гэрээ шууд байгуулах ҮГА-ны албан хүсэлтийг Тагнуулын ерөнхий газраас төрийн нууцтай холбоотой мэдээллийг боловсруулах хуулийн этгээдтэй аюулгүй байдлын гэрчилгээ гаргуулан гүйцэтгүүлэх боломжтой хариу ирүүлсэн ба холбогдох хууль, ТЕГ-ын албан бичгүүдийг судлан уг төслийг 2021 онд хэрэгжүүлэх боломжгүй шийдвэр гарсан. Учир нь ҮГА-нд хадгалагдаж байгаа геологийн мэдээлэл нь төрийн нууцын жагсаалтад байхгүй бөгөөд албаны нууцтай холбоотой мэдээллийг ашиглан үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдтэй тендерийн хуулийн 3.4 дахь заалтыг үндэслэн гэрээ шууд байгуулах боломжгүй болсон. Уг төслийг 2022 оноос хэрэгжүүлэхээр шийдвэрлэн УУХҮСайдын 2022 оны төсвийн багцаар худалдан авах жагсаалт (2021.11.24 А/281)-д оруулсан. | | |
| 26 | | 5.2. Геологийн чулуун дээжийн сан болон цахим архивыг бүрдүүлэх, баяжуулах, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулах. | Хэрэгжсэн төслийн тоо | 0 | 2 | Улсын төсөв 450.0 (2021)<br><br>Улсын төсөв 550.0 (2022) | ТНБДаргын 2021.11.25-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/95 дугаар тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр геологийн мэдээллийн санг нэгтгэх, бүрдүүлэх, геологийн баримтын архивын үйлчилгээг цахимжуулах, чулуун дээжийн санг шинэчлэх, баяжуулах зорилго бүхий 3 төслийг 2021 оноос | •2022 оноос шинээр хэрэгжүүлж эхлэх “Чулуун дээжийн сан-1-2022” болон “Цахим архив-1-2022” төслийн төсөв, төлөвлөгөөг УУХҮСайдын 2022 оны А/29 дүгээр тушаалаар, геологийн даалгаврыг УУХҮ-ийн Дэд сайдын 2022.01.20-ны өдрийн тушаалаар баталсан.<br>•Үндэсний геологийн албаны даргын 2022.02.11-ний | 70 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шууд гэрээ байгуулан хэрэгжүүлэх боломжтой эсэх асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд судлан санал, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгээс Чулуун дээжийн сан-1 төслийг 2022 оноос эхлэн хэрэгжүүлэхээр санал гаргасан.<br>Баримт бичгийн менежментийн системийг (DMS) хөгжүүлж байна. Тус систем нь геологийн баримтын төв архивт байгаа тайлан, мэдээллийг татан авах, сканнердах, оптик тэмдэгт мэдрэх, хадгалах, бүртгэх, удирдах үүргүүдтэй. Геологийн баримт материал болон төрөл бүрийн лавлагаа, геомэдээллийг онлайн хэлбэрээр түгээх, хэрэглэгч амар хялбараар мэдээлэл олж авахад хялбар болох системийн хөгжүүлэлтийн ажлыг хийж байна.<br>Үндэсний геологийн мэдээллийн сангийн портал болох www.mris.mn нүүр хуудасны туршилтын загварыг боловсруулж, холбогдох саналыг авч, сайжруулалт хийж, ҮГА-ны веб сервер дээр www.mris.mn нууцлал хамгаалал (SSL certificate) хийгдсэн. Энэхүү систем нь геомэдээллийн сэдэвчилсэн сангуудын бүртгэл болон удирдлагын системүүдээс бүрдэх бөгөөд олон төрөлт хайлт хийх мета сан,газарзүйн мэдээллийн систем бүхий олон хэрэглэгч ашиглах боломжтой мэдээллийн сан юм. | өдрийн А/04 тушаалаар байгуулагдсан 2022 онд УТХ-өөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын гүйцэтгэгч шалгаруулах тендерийн үнэлгээний хороо ажиллаж “Цахим архив-1-2022”, “Чулуун дээжийн сан-1-2022” төслийн гүйцэтгэгчийг шалгаруулсан.<br>•“Цахим архив-1-2022” төслийг Геологийн судалгааны төв ТӨҮГ, Чулуун дээжийн сан-1-2022 төслийг Арвин майнинг ХХК гүйцэтгэхээр шалгарч 2022.11.30-ны өдөр гэрээг байгуулан төслийн ажлыг эхлүүлсэн. ҮГА-ны геологийн архив болон чулуун санд төслийн ажил явагдаж мэдээллийн сан бүрдүүлэх, бүртгэлжүүлэх ажил эхлээд байна. Ажил оройтож эхэлсэнтэй холбоотой гүйцэтгэл хараахан гаргаагүй байна. | |

| 2. Ерөнхий чиг үүргийн нэр: Уул уурхайн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах. | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Үндсэн чиг үүрэг-1: Уул уурхайн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох. | | | | | | | | | |
| 27 | Зорилт-1: Уул уурхайн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, төсөл, хөтөлбөрийн хувилбар боловсруулах. | 1.1. Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах. | Батлуулсан хуулийн тоо | 0 | 1 | Улсын төсөв | УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн холбогдох судалгааг хийх, хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг 2021 оны туршид дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:<br>1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6-д “хуулийн хэрэгжилтийн үр дагаварыг үнэлэх аргачлал”-ын дагуу Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан;<br>2.Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой болон бусад судалгааны тайлан;<br>3.Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д заасны дагуу Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал;<br>4.Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;<br>5.Шинэчилсэн найруулгын төсөл боловсруулсантай холбогдуулан дагалдаж гарах хуулийн төслүүд;<br>6.Ашигт малтмалын тухай хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгасан талаарх харьцуулсан судалгаа; | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийг УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь 2021.01.27-2021.05.21-ний өдрийг хүртэл хугацаанд вакуумжин ажиллах хугацаандаа Канад, Австрали, Оросын холбооны улс, Казакстан зэрэг 10 гаран улсын уул уурхайтай холбоотой хууль тогтоомжийн судалгаа хийж Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаас өмнө салбарын холбогдох мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, судлаачид болон төрийн зарим байгууллагын төлөөлөлтэй нийт 21 удаагийн уулзалт зохион байгуулж хуулийн өөрчлөлттэй холбоотой санал, үзэл санааг сонсох, нэгдсэн нэг байр суурьнд хүрэх зорилт тавин ажилласан. Мөн ажлын хэсгийн судлаачдын багийн гишүүдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгаа, | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 7.Одоогийн мөрдөж байгаа ашигт малтмалын тухай хуулиас шинэчилсэн найруулгад тусаагүй хасагдсан заалтын харьцуулалт, тайлбар;<br>8.Шинэчилсэн найруулгад шинээр зохицуулагдаж байгаа заалтын талаар мэдээллийг тус тус боловсруулсан.<br>Ажлын хэсгээс хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийн яамны удирдлагад 10 орчим удаа танилцуулсан.<br>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 91 дүгээр зүйл. Мэдээллийн сангийн хэлбэр, 92 дугаар зүйл. Эрдэс баялгийн салбарын мэдээллийн сангийн тогтолцоо, төрөл, 93 дугаар зүйл. Мэдээллийн сангийн бүрдэл, 94 дүгээр зүйл. Мета мэдээллийн сан, 95 дугаар зүйл. Мэдээллийн санд мэдээлэл төвлөрүүлэх үүрэг хэрэгжүүлэх байгууллага, хугацаа, 96 дугаар зүйл. Мэдээллийн санг хэрэглэгчийн эрх, үүрэг, 97 дугаар зүйл. Мэдээллийн сангийн санхүүжилт, төлбөрийн нөхцөлтэй танилцаж, холбогдох саналыг жижиг ажлын хэсэгт хүргүүлсэн. | тайланг хийгээд байна. Үүнд: Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үр нөлөө, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг болно. Мөн үзэл баримтлалын төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас санал авахаар хэлэлцүүлгийг зохион байгуулж байна.<br>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаж, геологийн салбартай холбоотой оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг ажлын хэсэгт өгсөн.<br>Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төслийг геологийн салбарын ТББ, аж ахуйн нэгж болон бусад холбогдох төлөөллүүдэд танилцуулж, санал авах уулзалтыг 2 удаа зохион байгуулсан. | |
| 28 | | 1.2. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах. | Батлуулсан хуулийн тоо | 0 | 1 | Улсын төсөв | Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг УУХҮСайдын 2020.11.02-ны өдрийн А/270 дугаар тушаалаар шинэчлэн байгуулагдсан. Хуулийн төслийн үзэл баримтлалыг | | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2020 оны 8 дугаар сард Сангийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан. Хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлалдаа нийцүүлэн боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу яамны цахим хуудас, “Нээлттэй нийгэм форум” болон “Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилга” төслийн цахим хуудсанд тус тус байршуулж санал авч, хуулийн төслийн хэлэлцүүлгийг иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан 2020.10.06-ны өдөр зохион байгуулж, саналыг тусгасан. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хуулийн төсөл, дагалдах хуулийн болон дүрэм, журам боловсруулах үүрэг бүхий олон улсын болон дотоодын зөвлөх 2020 оны 12 дугаар сараас ажиллаж, өмнө боловсруулсан хуулийн төсөлд тулгуурлаж шинэчилсэн хуулийн төсөл, танилцуулгыг боловсруулсан. Зөвлөхүүдийн ажилласан хуулийн төслийг 2021.04.05-нд Ажлын хэсэгт танилцуулсан. Ажлын хэсгийн гишүүд нь хуулийн төслийн бичвэрийг эцэслэн боловсруулсан. | | |
| 29 | | 1.3. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах. | Батлуулсан хуулийн тоо | 0 | 1 | Улсын төсөв | | Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн гишүүдтэйгээр Ерөнхий | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сайдын 2021 оны 89 дүгээр захирамжаар байгуулсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл болон Хөгжлийн сангийн тухай хуулийн төсөл, бусад дагалдах хуулийн төслийг боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн үзэл баримтлалыг баталж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, үр нөлөөний судалгааг хийн хуулийн төсөлд яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зохих зөвшөөрлийг авч, Засгийн газрын 2022.05.11-ний өдрийн хуралдаанд танилцуулж, Улсын Их Хуралд уг хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр тогтсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам болон Сангийн яамнаас 2022.06.17-ны өдөр зохих зөвшөөрлийг авч, улмаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг ЗГХЭГ-аар дамжуулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бүрдлийг ханган хүргүүлсэн болно. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны “Ажлын хэсэг шинэчлэн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгуулах тухай" 192 дугаар захирамжаар Үндэсний баялгийн санг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Улмаар тус Ажлын хэсгийн ахлагчаар Эдийн засаг, хөгжлийн сайд ажиллах болсон тул холбогдох материалуудыг Эдийн засаг, хөгжлийн сайдад 2022.12.15-ны өдрийн 01/3297 дугаар албан бичгээр Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл, дагалдах хуулийн төсөл, холбогдох бусад албан бичгүүдийг хүргүүлээд байна. | |
| 30 | | 1.4. Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах. | Батлуулсан хуулийн тоо | 0 | 1 | Улсын төсөв | | Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг ажиллаж, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага, тандан судалгааны ажлын тайланг хийж гүйцэтгэн, хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулсан. Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төслийг бүх яамдаас саналыг авч нэгтгэн, олон нийтийн хэлэлцүүлгийн 2021.09.27-ны өдөр цахимаар зохион байгуулж, улмаар хуульд заасны дагуу Хууль зүйн асуудал эрхэлсэн болон Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Засгийн газарт өргөн мэдүүлэх зөвшөөрлийг авч, Засгийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | газрын ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д 2022.02.01-ний өдөр өргөн мэдүүлэв. Улсын Их Хурлын дэгийн тухай хуульд заасны дагуу холбогдох Ажлын хэсэг УИХ-ын даргын захирамжаар байгуулагдаж мөн дэд ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Улсын Их хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт орж дэмжигдсэн бөгөөд 2022.12.14-ний өдрийн Улсын Их хурлын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж УИХ-ын чуулганы эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэгдэхээр хүргүүлсэн бөгөөд УИХ-ын намрын ээлжит чуулганы 2022.12.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн батлагдаад байна. | |
| **Үндсэн чиг үүрэг-2: Ашигт малтмалын олборлолт, баяжуулалтын хэмжээг нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх.** | | | | | | | | | |
| 31 | Зорилт-2: Ашигт малтмалын ордыг ашиглах болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрт үнэлэлт, дүгнэлт өгөх, мэргэжил арга зүйгээр хангах, хэрэгжилтийг зохицуулах. | 2.1. Оюутолгойн төслийг Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлж, далд уурхайг ашиглалтад оруулах. | Уурхай байгуулах ажлын явц | 26 хувь | 100 хувь | Гадаадын шууд хөрөнгө оруулалт, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл<br><br>2022 онд далд уурхайн бүтээн байгуулалтын ажилд 765 сая ам.доллар зарцуулахаар төлөвлөсөн. 2022 оны 11-р сарын 30-ны | “Оюу толгойн ордын ашиглалтад Монгол улсын эрх ашгийг хангуулах тухай” Монгол улсын Их хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол улсын Ерөнхий сайдын 2019 оны 174 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх, Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 23 дугаар тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсэг ажиллаж байна.<br>(Дээрх ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021.02.09-ний өдрийн 45 дугаар захирамжаар, ажлын | Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2022 онд далд уурхайн бүтээн байгуулалтыг 73 хувьд хүргэнэ гэж тусгасан. 2022.12.01-ний байдлаар Оюу толгойн далд уурхайн төслийн барилгын ажлын гүйцэтгэл-90%, материал зөөвөрлөх системийн гүйцэтгэл-100%, далд уурхайн бүтээн байгуулалт 84%-д хүрсэн. Оюу толгойн уурхайд шаардлагатай бараа материалыг хил гаалиар саадгүй нэвтрүүлэх талаар холбогдох хүсэлтийг Хилийн боомтын зөвлөлд удаа дараа уламжлан ажиллаа. ЗГҮАХ- | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлаар уурхайд 465 сая ам.доллар зарцуулсан. | дэд хэсгийг ХЗДХ-ийн Сайдын 2021.02.24-ний өдрийн А/29 дүгээр тушаалаар шинэчлэн байгуулсан)<br>Мөн тус яамнаас Ашигт малтмалын тухай хуулийн 35.4 дэх хэсэгт заасны дагуу “Оюутолгойн далд уурхайн хүдэр тээвэрлэх шугам /үе шат1/-ыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах” тухай техникийн ажлын хэсгийг 2021.02.05-ны өдөр зохион байгуулж, Оюутолгойн далд уурхайг Улсын комисс ашиглалтад бүрэн хүлээж авах хүртэл үйлдвэрлэлийн зориулалтаар түр ашиглах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг гаргасан.<br>2021 оны эцсийн байдлаар Оюу толгойн далд уурхайн төслийн барилгын ажлын гүйцэтгэл-89%, материал зөөвөрлөх системийн гүйцэтгэл-85%, далд уурхайн хөндлөн малталтын гүйцэтгэл-49,943 экв.м, туузан дамжуургын малталт-13,851 экв.м, далд уурхайн бүтээн байгуулалт 78 хувьд хүрсэн байна.<br>Хилийн боомтын зөвлөл, Улсын онцгой комисс, Замын-Үүд дэх Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч нарт тус уурхайн ачаа тээврийн хэрэгслийг яаралтай горимоор оруулж ирэх хүсэлтийг 2021.09.14-ний өдрийн 01/2234, 2021.10.07-ны өдрийн 01/2423 дугаар албан бичгээр тухай бүрт уламжлан шийдвэрлүүлж дэмжлэг үзүүлсэн.<br>УУХҮСайдын 2021.11.24-ний өдрийн А/284 дүгээр | ийн хүрээнд “Оюу толгой” ХХК, болон “Эрдэнэс оюу толгой” ХХК-тай байнга холбогдож сар улирал тутамд мэдээлэл авч, холбогдох чиглэл өгч ажиллаж байна.<br>УУХҮСайдын 2022.05.19-ний өдрийн А/113 дугаар тушаалаар “Оюу толгой” ХХК-ийн далд уурхайн бүтээн байгуулалттай газар дээр нь үзэж танилцаж, далд уурхайг ашиглалтад хүлээн авах эсэх асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Комиссын бүрэлдэхүүнийг баталсан. Дээрх тушаалын дагуу УУХҮЯ, ЭХЯ, БОАЖЯ, МХЕГ, АМГТГ, ОБЕГ, Өмнөговь аймгийн засаг даргын тамгийн газар, “Оюу толгой” ХХК, “Эрдэнэс оюу толгой” ХХК-ийн төлөөлөл оролцсон комисс 2022.05.25-ны өдөр Оюу толгойн далд уурхайд ажиллаж, далд уурхайн бүтээн байгуулалт гүйцэтгэлтэй танилцаж, далд уурхайг хүлээж авах хүртэл, хугацаатай үүрэг даалгавар, зөвлөмж өгсөн. Оюутолгой ХХК-иас Комиссын өгсөн зөвлөмж, даалгаварын хэрэгжилтийн тайланг ирүүлсний дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт орших “Оюутолгой” нэртэй зэс, алтны ордыг далд аргаар ашиглах уурхайн 2 дугаар үе шатыг ашиглалтад хүлээн авах тухай шийдвэрийг 2022.08.31-ний өдрийн 22/24 дугаар акт гарсан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тушаалаар Оюу Толгой төслийн анхдагч мэдээлэл, боловсруулсан өгөгдөлд дүн шинжилгээ хийж, талуудын мэдээллийн тэнцвэртэй байдлыг хангах, шаардлагатай тохиолдолд ЭБМЗ-өөс томилогдсон шинжээчдийн хэсэгт техникийн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан Рио тинто ХХК, Оюутолгой ХХК-ийн төлөөлөлтэй Ажлын хэсгийн гишүүд 2021.11.25-ны өдөр уулзалт зохион байгуулсан. | | |
| 32 | | 2.2. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын өмчлөлтэй холбоотой асуудлыг эцэслэн шийдвэрлэж, ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх. | Боловсруулсан хүдрийн хэмжээ | 32.0 сая.тн/жил | 40 сая.тн/жил | Хувийн хөрөнгө оруулалт, Зээл<br><br>322,939.3 сая.төг Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр 13.1 %- ийг, зээлээр 86.9%- ийг (“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ) | ХБНГУ-ын “ЗВ TEC AUFBEREITUNGSSYSTEME” GmbH компани туслан гүйцэтгэгчээр ажиллаж байна. Метал хийц үйлдвэрлэлийн ажлын явц Бутлуурын байгууламж 100%, Туузан дамжуургын систем 100% дууссан Нийт металл хийцийн тээвэрлэлтийн ажлын явц 70%-ийн гүйцэтгэлтэй байна. Механик тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн явц Бутлуурын байгууламж 95%, Туузан дамжуургын систем 90%. Овоолгын хэсгийн металл хийц болон механик тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн явц 48%-тай байна. Нийт механик тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийн ажлын явц 24%-ийн гүйцэтгэлтэй байна. Хилийн боомтын зөвлөл, Улсын онцгой комисс, Замын-Үүд дэх Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч нарт тус уурхайн ачаа тээврийн хэрэгслийг яаралтай горимоор оруулж ирэх хүсэлтийг 2021.11.09-ны | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дотоод аудитын үнэлгээгээр Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 45%-д хүрсэн. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 70%-тай болж буурсан байна. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл 100%-д хүрсэн. Засварын механикийн заводын ТЭЗҮ-г ЭБМЗ-ийн хэлэлцүүлж хүлээн авсан. "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийг хийж, үйлдвэрлэлийн хүчин чадал, өгөөжийг нэмэгдүүлэх ажлын гүйцэтгэл 80%-тай байна.<br>"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн заводод өргөтгөл, шинэчлэлийн ажилд | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдрийн 01/2725, 2021.12.06-ны өдрийн 03/3022 албан тоотоор тухай бүр уламжлан шийдвэрлүүлж дэмжлэг үзүүлсэн. | шаардлагатай бараа материал, үйлдвэрийн тасралтгүй ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалын тээвэрлэлтийн ажлыг хил гаалиар саадгүй нэвтрүүлж өгнө үү гэсэн хүсэлтийг Хилийн боомтын зөвлөлд удаа дараа уламжлан ажилласан. ЗГҮАХ-т хамрагдсан зорилтуудын хүрээнд ажлын гүйцэтгэл, тулгамдаж байгаа асуудлын талаар "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ-ын холбогдох эрх бүхий албан тушаалтантай холбогдож сар, улирал тутам мэдээлэл авч ажилласан. | |
| 33 | | 2.2.1. Мөчлөгт урсгалт тээврийн технологийг нэвтрүүлэх. | Технологи нэвтрүүлэлт ийн явц | 52 хувь | 100 хувь. | 55,483.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтаар 7.7%-ийг, зээлээр 92.3%-ийг/ (2021 он) | ТЭЗҮ 100%-ийн гүйцэтгэлтэй. Инженерийн зураг төслийн ажил 90%-ийн гүйцэтгэлтэй байна. Конвейерийн системийн тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл 50%. Материал тээвэрлэлт 10%-д хүрсэн. Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 35%-д хүрсэн. | Уурхайн тээвэрлэлтийн зай нэмэгдсэнээр олборлолтын зардал ихсэж байгаа тул олборлолтын өөрийн өртгийг бууруулах зорилгоор энэхүү төслийг хэрэгжүүлж байна. Түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ хийгдсэн. /ТЭЗҮ ба Зураг төслийн ажлыг гэрээнд заагдсан графикийн дагуу хийгдэж байна. Барилга угсралтын талбайн түр барилга байгууламжийн ажлын явц бүрэн дууссан. Бутлуурын байгууламж, туузан дамжуургын системийн геодези хэмжилтийн ажлыг эхлүүлэн трассыг чөлөөлөх ажил хийгдэж байгаа. Туузан дамжуургын трассын дагуу газар шороо, бэлтгэл ажил гүйцэтгэж байна. Метал хийц үйлдвэрлэлийн ажлын явц Бутлуурын байгууламж 100%, Туузан дамжуургын систем 100% дууссан. Нийт метал хийцийн тээвэрлэлтийн | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | ажлын явц 70%-ийн гүйцэтгэлтэй байна. Механик тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн явц Бутлуурын байгууламж 90%, Туузан дамжуургын систем 85% байна. Нийт механик тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийн ажлын явц 30%-ийн гүйцэтгэлтэй. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дотоод аудитын үнэлгээгээр Хүдрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлтийн бодит гүйцэтгэл 45%-д хүрсэн гэж бууруулж үнэлсэн байна. Тоног төхөөрөмж үйлдвэрлэх, нийлүүлэх гэрээний хугацаа дууссан. Гэрээг сунгах асуудал төсөвт өртөг нэмэгдсэнтэйгээр хойшлогдоод байна. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ил уурхайн хөрс тээвэрлэлтийн өөрийн өртгийг 10 хүртэл хувиар бууруулах боломж бүрдэнэ. | |
| 34 | | 2.2.2. Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг ашиглалтад оруулах. | Шинээр ашиглалтад орсон үйлдвэрийн тоо | 0 | 1 | Хувийн хөрөнгө оруулалт, Зээл<br><br>"Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, туслан гүйцэтгэгч "Монголиан Инвестмент Корпорэйшн" ХХК | Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн хөрөнгө оруулалт 100 хувь, бүтээн байгуулалтын ажлын явц 35 хувьтай гүйцэтгэгдэж байгаа бөгөөд 2021.10.01-ний өдөр бүрэн ашиглалтад оруулахаар ажиллаж байна. | Тэсрэх бодис үйлдвэрлэх хүчин чадал 15000 тн болсноор Эрдэнэт үйлдвэрийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд тэсрэх бодисоор хангах боломж бүрдэнэ. Ил уурхайн өрөмдлөг, тэсэлгээний хэсэгт эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр барих ажлыг “Монголиан Инвестмент Корпорэйшн” ХХК 2020.05.08-ны өдөр 7/006-20 дугаартай “Ил уурхайн Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийг шинээр барих ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ” байгуулж ажил эхэлсэн. 2021.09.30-ны өдөр гэрээний хугацаа дууссан. 2022.12.31 | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хүртэл дахин сунгасан. 2023.02.28-нд ашиглалтад оруулахаар дахин төлөвлөсөн. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дотоод аудитын үнэлгээгээр Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 70%-тай гэж бууруулж үнэлсэн бөгөөд 2023 онд багтаан ашиглалтад хүлээлгэн өгөх төлөвлөгөөтэй үйлдвэрийн барилга байгууламжийн угсралтын ажил явагдаж байна. | |
| 35 | | 2.2.3. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл. | Өргөтгөл, шинэчлэлийн явц | 14 хувь | 100 хувь | Хувийн хөрөнгө оруулалт, Зээл<br><br>239,003.5 /Төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүүжилтээр 16.6%-ийг, зээлээр 83.4%-ийг/ 2021 он<br><br>558,528.0 сая.төг Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт /Өөрийн хөрөнгөөр 36%- ийг, зээлээр 64%-ийг (“Эрдэнэт | Хилийн боомтын зөвлөл, Улсын онцгой комисс, Замын-Үүд дэх Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч нарт тус уурхайн ачаа тээврийн хэрэгслийг яаралтай горимоор оруулж ирэх хүсэлтийг 2021.10.04-ний өдрийн 01/2374 тоотоор уламжлан шийдвэрлүүлж дэмжлэг үзүүлсэн.<br>Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн 4-р шугам барьж, байгуулах ажилд БНХАУ-аас нийт 151 инженер, техникийн ажилтан урьж ажиллуулах хүсэлт ирүүлснийг тухай бүр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт тодорхойлж өгсөн. | “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын өргөтгөл шинэчлэлийн ажилд шаардлагатай тоног төхөөрөмж, овор ихтэй ачааг хил гаалиар нэвтрүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор БНХАУ-ын талтай хэлэлцээр хийх асуудлаар ГХЯ, Эрээний гаалиар нэвтрүүлэх ачаа тээвэр, вагоны захиалгыг нэмэгдүүлэх талаар ЗТХЯ-нд албан бичгээр тухай бүр уламжилсан.<br>Баяжуулах үйлдвэрийн хаягдлыг өтгөрүүлэх байгууламжийг шинээр байгуулах төслийн техник-эдийн засгийн үндэслэлд УУХҮСайдын 2022.02.21-ний өдрийн А/28 дугаар тушаалаар шинжээчдийн багийг томилон, 2022.05.09-ний өдрийн ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар ТЭЗҮ-ийг хэлэлцүүлэн батлуулсан.<br>2022.08.26-нд Баяжуулах үйлдвэрийн Өөрөө нунтаглах хэсгийн жилд 6 сая тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай өргөтгөлийн 4-р | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлдвэр" ТӨҮГ) 2022 он | | шугамыг ашиглалтад оруулж, улсын комисст хүлээлгэн өгсөн. Уг шугамыг нэмж байгуулсанаар баяжмалын гарц 100 мянган тонноор нэмэгдэж, борлуулалтын орлого жилд 200 орчин сая доллараар өснө. Мөн 68 ажлын байр шинээр бий болж байна. Баяжуулах үйлдвэрийн хүдэр боловсруулах хүчин чадлыг шат дараатай нэмэгдүүлэх өргөтгөл шинэчлэлийн ажлын хүрээнд Өөрөө нунтаглах хэсэгт жилийн 6 сая.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай өргөтгөлийн 4-р шугамыг байгуулах ажил 2019-2022 онд хийгдэж, ашиглалтад ороод байна. Уг шугам нь 2015 онд ашиглалтад орсон 3-р шугамтай тоног төхөөрөмж, технологийн хувьд мөн адил юм. 2022 оны 08 сард эхний 2 төслийн ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулсан. Үлдсэн 3 ажил тендер зарлах түвшинд хэрэгжиж байна. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн ажил 100% хүрсэн. | |
| 36 | | 2.2.4. Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл. | Өргөтгөл, шинэчлэлийн явц | 15 хувь. | 100 хувь. | Хувийн хөрөнгө оруулалт, Зээл<br><br>28,452.8 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт | Хүйтнээр хатуурах холимгоор хэв бэлтгэх хагас автомат шугамын гүйцэтгэл 100%, засвар, механикийн заводыг үндэсний машин үйлдвэрлэлийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл болон инженерийн зураг төслийг боловсруулах ажил 30 орчим хувьтай, Шинэ Засвар механикийн завод–II төслийн техник, эдийн | Техник технологийн шинэчлэлийг үе шаттай хийж цутгамал бүтээгдэхүүн, механик боловсруулалттай эд анги, барилгын болон үйлдвэрийн зориулалттай ган хийц, стандартын бус тоног төхөөрөмж, резинэн эдлэлийн дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж импортоор авах төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүний хэмжээг зохих түвшинд бууруулна. | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | /Өөрийн хөрөнгөөр 22%-ийг, зээлээр 78%- ийг (“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ) | засгийн үндэслэлийн техникийн даалгавар боловсруулах ажил хийгдэж байна. Засвар, механикийн заводын Цутгуурын цехийн элчийн боловсруулалтын тасгийн өргөтгөл шинэчлэлийн ажил 10%. Засварын механикийн заводын өргөтгөл, шинэчлэл 20%-д хүрсэн. Ажлын явц гэрээнд заасан график төлөвлөгөөний дагуу хэвийн үргэлжилж байна. | Ажил эрхлэлтийг дэмжиж төсөл хэрэгжснээр шинээр ажлын байр бий болно. Зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт явагдаж, гүйцэтгэгчээр шалгарсан “Ди Ди Эй Жи” ХХК-тай 2021 оны 08 дугаар сарын 24-ны өдөр 5/196-21 дугаар бүхий гэрээ байгуулсан. “Ди Ди Эй Жи” ХХК “Засвар, механикийн заводыг үндсний машин үйлдвэрлэлийн суурь болгон хөгжүүлэх өргөтгөл, шинэчлэлийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулах” төслийн ажлыг гүйцэтгэж, 2022 оны 05 сард УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлсэн, Дээрх төслийн хүрээнд Цутгуурын үйлдвэрлэлийн Илчийн боловсруулалтын тасгийн болон Механик цехийн өргөтгөл шинэчлэлийн техник, технологийн сонголт, барилга байгууламж, дэд бүтцийн зэрэг иж бүрэн зураг төсөл боловсруулах ажил, Үйлдвэрийн газрын Зураг төслийн хүрээлэнд хийгдэж дуусаад байна. Цутгуурын үйлдвэрлэлийн Илчийн боловсруулалтын тасгийн төслийн гүйцэтгэгчээр “Аглуут” ХХК шалгарч, 2022 оны 08 сард гэрээ байгуулсан. 2022 оны 09 сард ЗМЗ-ын өргөтгөл шинэчлэлийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн | |
| 37 | | 2.3. Цагаансуваргын зэс, молибдений ордыг ашиглалтад оруулах ажлыг зохион байгуулах. | Ашиглалтад орсон ордын тоо | 0 | 1 | Хувийн хөрөнгө оруулалт, хөнгөлөлттэй зээл | Цагаан суваргын зэс, молибдений ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг боловсруулж ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн. Өнөөдрийн байдлаар бүтээн байгуулалтын ажил 69 хувьд | Цагаан суваргын зэс, молибдений ордыг ашиглах ТЭЗҮ-ийн тодотголыг өнгөрсөн онд ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн. Төсөл боловсруулагч хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1,166,564.8 /Өөрийн хөрөнгө, гадаадын хөнгөлөлттэй зээл/ 2021 он<br><br>796,678.0 сая төгрөг. 2022 он | хүрсэн. Улын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2023 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.<br>Тус төслийн уулын баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад ашиглагдах тоног төхөөрөмж, материал нь цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж БНХАУ-ын Эрээн боомтын хил, гаалиар нэвтрэхэд доторхой хүндрэлүүд үүссэн бөгөөд тус яамнаас Хилийн Замын-Үүд боомтын зөвлөлд хандаж бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай бараа материалыг хил, гаалиар саадгүй нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж ажилласан.<br>Тус төслийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх хүрээнд Засгийн газрын тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг боловсруулж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад 2021.11.22-ны өдөр танилцуулсан. | зорилгоор уулзалт хэлэлцээрүүд хийгдэж байна. Өнөөдрийн байдлаар бүтээн байгуулалтын ажил 69%-тай. Уулын баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохируулгын ажлыг 2023 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Төслийн талбайд 2022 онд барилга угсралтын ажил хийгдээгүй. Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 1 дүгээр албан даалгаварт тусгагдсан Цагаан суваргын зэс, молибдений төслийг эрчимжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга бэлтгэн Засгийн газрын 2022.04.20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулсан.<br>Монгол Улсын засгийн газрын 2022.04.20-ны өдрийн 24 дүгээр тэмдэглэлийн 1-д Цагаан суваргын зэс, молибдений ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хүрээнд тоног төхөөрөмж суурилуулалт, барилгын бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай гадаадаас ажиллах хүч, мэргэжилтнийг авах талаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээ авч ажиллахыг УУХҮЯ, ХНХЯ-нд даалгасан. УУХҮСайд тус төслийн бүтээн байгуулалттай газар дээр нь очиж танилцсан.<br>Уул уурхайн салбарын нэн тэргүүнд хэрэгжүүлэх 10 том төслийн тоонд Цагаан суваргын зэс, молибдений төслийг хамруулж холбогдох | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | судалгаа танилцуулга хийсэн. | |
| 38 | | 2.4. Багануурын уурхайд өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж, өртөг, зардлыг бууруулах. | Олборлосон нүүрсний хэмжээ<br><br>Үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлийн явц | 4.0 сая.тн/ жил<br><br>51 хувь | 5.7 сая.тн/жил<br><br>100 хувь | Гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламж<br><br>Урьдчилгаа төлбөрт 4,468.0 сая төгрөг, зээлийн шимтгэлд 6.85 сая иен. | “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-иудын тоног төхөөрөмжийг шинэчлэх хүрээнд Япон улсын олон улсын хамтын ажиллагааны банк /JBIC/-ны хөнгөлөлттэй зээлийг ашиглах дамжуулан зээлдүүлэх гэрээний төслийг батлуулахаар тус яаманд “Эрдэнэс Монгол” ХХК-иас 2021.03.05-ний өдрийн 01/122 дугээр албан бичгээр ирүүлсэн бөгөөд хариуг 2021.03.15-ны өдрийн 01/593 дугээр албан бичгээр хүргүүлсэн.<br>Улмаар Япон улсын олон улсын хамтын ажиллагааны банк /JBIC/-ны хөнгөлөлттэй зээлийг ашиглах дамжуулан зээлдүүлэх гурвалсан гэрээг 2021.03.05-ны өдөр байгуулсан байна.<br>Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, УУХҮСайд нарын 2021.02.26-ны өдрийн 16,А/32 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан Эрдэнэс Монгол ХХК-ийн 2019, 2020 оны үйл ажиллагаа, санхүүгийн аудит хийх Ажлын хэсэгт ажиллаж, холбогдох дүгнэлтийн боловсруулсан.<br>Ажлын хэсгийн тайланг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар хүлээгдэж байгаа бөгөөд тайланд “Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний ордуудын олборлолтын өөрийн өртгийг бууруулж, компанийн өр төлбөрийг бууруулах, тоног төхөөрөмжийн шинэчлэлтийн хийж, хүчин чадлыг нэмэгдүүлэх, арга хэмжээний | JBIC-ийн төслийн зээлийн урьдчилгаа төлбөрт 4,468.0 сая төгрөг, зээлийн шимтгэлд 6.85 сая иен тус тус төлсөн. МУ-ын ЗГ-ийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Багануур ХК-ийн парк шинэчлэлт, уурхайн жилийн олборлолтын хүчин чадлыг 5.7 сая тоннд хүргэх санхүүжилтийг ЗГ-ийн мөрийн хөтөлбөрт 2 үе шаттайгаар тусгасан. 2020 онд JBIC-ийн хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр 29.8 тэрбум төгрөгийн 12 тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн. 2021 онд 2-р шатны техникийн шинэчлэлд шаардлагатай 33.6 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдэх ёстой боловч өнөөдрийн байдлаар шийдвэрлэгдээгүй байна. Багануурын нүүрсний уурхай үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 50%-д хүрсэн. | 70 |
| 39 | | 2.5. Шивээ-Овоогийн нүүрсний өргөтгөл хийж, олборлолтын хүчин чадлыг нэмэгдүүлж, өртөг, зардлыг бууруулах. | Олборлосон нүүрсний хэмжээ<br><br>Үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлийн явц | 2.0 сая.тн/ жил<br><br>36 хувь | 2.6 сая.тн/жил<br><br>71 хувь | Гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламж<br><br>40,402.1 /Гадаадын хөнгөлөлттэй зээл тусламжаар (JBIC) 100%-ийг 2021 он | | Шивээ Овоо ХК 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 2 технологийн автомашины урдчилгаа төлбөрийг шийдвэрлэснээр техникийн шинэчлэлийн түвшин 70 хувийн биелэлттэй байна. | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 6794.1 сая.төг /Зээлийн шимтгэл, даатгал орсон дүнгээр/ 2022 он | саналыг боловсруулж танилцуулахыг Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Эрдэнэс Монгол ХХК /Д.Хаянхярваа/ нарт" даалгах саналыг тусгуулсан. Өнөөгийн байдлаар "Багануур" ХК Япон улсын олон улсын хамтын ажиллагааны банк /JBIC/-ны хөнгөлөлттэй зээлээр нийт 12 техник, тоног төхөөрөмжийг шинэчлээд байна. Багануурын нүүрсний уурхай үндсэн тоног төхөөрөмжийн шинэчлэлт 50%-д хүрсэн. | | |
| 40 | | 2.6. Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх. | Ашиглалтад орсон ордын тоо | 0 | 1 | Хувийн хөрөнгө оруулалт<br><br>1,484.5 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр 100%-ийг/ 2021 он | Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн XII.4.2 "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв"-ийн жагсаалтад 500,000,000 /таван зуун/ сая төгрөгийн төсөвт өртөгийг тусгуулж "Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлын хүрээнд ордын штольня-1, штольня-2 болон штольня-5 хэвтээ амнуудаас хүдэр тээвэрлэх технологийн зам, гүүр, туннелийн шинэ маршрут тодорхойлох" нарийвчилсан зураг төслийг хийх ажлын даалгаврыг УУХҮЯ-ны ТНБДаргаар батлуулж, 2021.04.09-ний өдрийн 03/949 дугаар албан бичгээр БХБЯ-ны ТНБДарга С.Магнайсүрэнд хүргүүлсэн. Тус зураг төслийг гүйцэтгэх тендерт шалгарч гэрээ байгуулсан аж ахуйн нэгжээс 2021.09.01-ний өдөр төслийн эхлэлийн тайланг | 2022 оны байдлаар Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх ажил 7%-д хүрсэн. БНХАУ-ын Гашуун сухайт, Ганц модны боомтын хил нэвтрүүлэлт эрс буурсантай холбоотой "Эрдэнэс Монгол" ХХК-ийн санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тул тус ажил нь тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна. Асгатын мөнгөний ордын хүдрийн дээжид лабораторийн туршилтын ажлыг гүйцэтгэж байгаа SGSIMME MONGOLIA ХХК-нь 3/15 (Mon)-ны байдлаар Гэрээний хэрэгжилт явцын тайланг ирүүлсэн. Туршилт судалгааны ажилд ирүүлсэн дээж нь ордыг төлөөлөхгүй байна гэж дахин дээж авах ажлыг эхлүүлээд байна. Цаашид далд уурхайд 3-н хэмжээст зураглал хийхэд уурхай хэвтээ амыг нээж ажиллах орчин бүрдүүлэх, | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулан ирүүлээд байна. Мөн тус зураг төслийн ажлыг гүйцэтгэгч компаниас 2021.11.16-ны өдрийн 486 дугаар албан бичгээр Авто замын маршрутын судалгааг ирүүлсэн бөгөөд тус асуудлыг судлан үзэж холбогдох саналыг “Эрдэнэс Монгол” ХХК-иас авч Авто замын маршрутыг тогтоод байна. | хагас үйлдвэрлэлийн туршилтад хэрэглэх 150 тонн дээж бэлдэх зэрэг ажилд зарцуулахаар 2022 оны төсвийн төсөлд 1.5 тэрбум төгрөгийг төсөвлөн холбогдох саналыг Сангийн яаманд хүргүүлж Барилга хот байгуулалтын яамны төсөвт тусгуулсан. Цар тахалтай холбоотой төсөв танах ЗГ-ын чиглэлийн дагуу цуцлагдсан. Засгийн газрын 2022.03.16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх саналаа танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-д (О.Хуланд) даалгасан. УУХҮСайдын 2022.03.31-ний өдрийн 01/801 дугаар албан бичгээр ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын нарийвчилсан төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх саналаа яаралтай танилцуулахыг үүрэг болгосон. УУХСайд Г.Ёндон, Эрдэнэс Монгол ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч О.Хулан, АМГТГ-ын дарга Л.Баярмандал болон ҮГА-ын дарга О.Чулуунтай Асгатын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлаар 2022.05.23-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтаас дараах арга хэмжээг авч ажиллахаар шийдвэрлэсэн. Үүнд:<br>-Асгатын ордод өмнө хийгдсэн геологи хайгуул, судалгааны тайлан болон техник, эдийн засгийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үндэслэлтэй танилцаж 2022, 2023 онуудад хийгдэх хайгуул судалгааны ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах, тус хайгуулын ажлыг хийхэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх талаар санал танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн захирлын үүргийг гүйцэтгэгч О.Хуланд;<br>-Хайгуулын ажлын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг ҮГА, АМГТГ-т;<br>-Асгатын ордын хүдэр тээвэрлэх зам гүүр, туннелийн шинэ маршрут тодорхойлох нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явцын талаар “Эн Би Си Си” ХХК-тай уулзалт зохион байгуулж танилцуулахыг “Эрдэнэс Монгол” ХХК-д тус тус даалгасан.<br>Асгатын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлын хүрээнд хүдэр тээвэрлэх технологийн зам, гүүр, туннелийн шинэ маршрут тодорхойлох нарийвчилсан зураг төслийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Эн Би Си Си” ХХК болон ЗТХЯ, УУХҮЯ-ны төлөөлөл оролцсон хурлыг 2022.07.06-ны өдөр зохион байгуулж, тус компаниас ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах төслийн ажлын явц, тулгамдаж буй асуудал болон холбогдох асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцсэн. Улмаар тус компаниас холбогдох | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | асуудлаар үндэслэл бүхий тайлбар, тооцоо судалгаа, саналыг 2022.07.19-ны өдрийн 186 дугаар албан бичгээр хүлээн авч Эрдэнэс Монгол ХХК-нд уг асуудлыг судлан үзэж яаралтай хариу ирүүлэхийг даалгасан. “Эрдэнэс Монгол” ХХК-иас ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх нарийвчилсан төлөвлөгөө ирүүлээгүй байна. | |
| 41 | | 2.6.1. Асгатын мөнгөний ордыг ашиглах туршилт, судалгаа хийх. | Лабораторын туршилт, судалгааны ажлын гүйцэтгэл | 50 хувь. | 100 хувь | Гадаадын шууд хөрөнгө оруулалт<br><br>714.5 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр 100%-ийг/ 2021 он | Асгатын мөнгөний ордын хүдрийн дээжид лабораторийн туршилтын ажлыг гүйцэтгэж байгаа SGSIMME MONGOLIA ХХК-нь 3/15(Mon)-ны байдлаар Гэрээний хэрэгжилт явцын тайланг ирүүлсэн. Энэ хугацаанд Асгатын ордоос авчруулсан дээж нь тус ордыг төлөөлөхүйц байж чадахгүй гэж үзэн тус ажлыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулах мэдэгдлийг SGSIMME MONGOLIA ХХК-д 2021.01.21-ний өдөр цахим шуудангаар өгсөн. Тайлбар: (Асгатын мөнгөний ордын ашиглалтын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд тус уурхайн хэвтээ амнуудыг нээх, нэвтрэх, далд малталтуудаас технологийн дээж бэлтгэх тендерт “Асгат Кент” ХХК шалгаран 2019.11.06-2019.12.25-ны хооронд дээж бэлтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн. Ажлын даалгаварт тусгасан ажил үүргийн хуваарь, ажлын гүйцэтгэлийн тайлан зэрэгтэй танилцахад Штольня 1-5 амнуудыг нээж чадаагүйн улмаас ордыг төлөөлөхүйц | Асгатын мөнгөний ордын хүдрийн дээжид лабораторийн туршилтын ажлыг гүйцэтгэж байгаа SGSIMME MONGOLIA ХХК-нь 3/15 (Mon)-ны байдлаар Гэрээний хэрэгжилт явцын тайланг ирүүлсэн. Туршилт судалгааны ажилд ирүүлсэн дээж нь ордыг төлөөлөхгүй байна гэж дахин дээж авах ажлыг эхлүүлээд байна. Цаашид далд уурхайд 3-н хэмжээст зураглал хийхэд уурхай хэвтээ амыг нээж ажиллах орчин бүрдүүлэх, хагас үйлдвэрлэлийн туршилтад хэрэглэх 150 тонн дээж бэлдэх зэрэг ажилд зарцуулахаар 2022 оны төсвийн төсөлд 1.5 тэрбум төгрөгийг төсөвлөн холбогдох саналыг Сангийн яаманд хүргүүлж Барилга хот байгуулалтын яамны төсөвт тусгуулсан. Цар тахалтай холбоотой төсөв танах ЗГ-н чиглэлийн дагуу цуцлагдсан. | /-/ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дээж авч чадаагүй, ажлын даалгаврын дагуу ажлууд бүрэн хийгдээгүй байна. Эндээс харахад Штольня 1-5 амнуудыг нээх, түүнд нэвтрэн дотор нь ажиллах орчин бүрдүүлэх, хүдрийн дээж бэлтгэх зам талбайг засах нээх зэрэг ажлуудад шаардлагатай ТӨСӨВ ТООЦОО-г судалгаагүй хийсэн. Мөн уулын геологи техникийн нөхцөл нэн хүндрэлтэйн дээр цаг уурын нөхцөл байдлыг тооцоолоогүй зэрэг шалтгаанаас үүдэн ордыг бүрэн төлөөлөхүйц дээж бэлтгэхэд ихээхэн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн байна.<br>Орд ашиглах бэлтгэл ажлын хүрээнд далд уурхайд 3-н хэмжээст зураглал хийх, уурхай хэвтээ амыг нээж ажиллах орчин бүрдүүлэх, хагас үйлдвэрлэлийн туршилтад хэрэглэх 150 тонн дээж бэлдэх зэрэг ажилд зарцуулахаар Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлд 1.5 тэрбум төгрөгийн саналыг Сангийн яаманд хүргүүлэн улмаар Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн гуравдугаар хавсралтаар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад тусгуулсан. | | |
| 42 | | 2.6.2. Асгатын мөнгөний ордыг ашиглах зөвлөх үйлчилгээ авах. | Зөвлөх үйлчилгээний ажлын явц | 55 хувь | 100 хувь | Гадаадын шууд хөрөнгө оруулалт<br><br>770.0 | Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн XII.4.2-д багтсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник эдийн засгийн үндэслэл, | Цар тахалтай холбоотой төсөв танах ЗГ-н чиглэлийн дагуу төсвийн санхүүжилт цуцлагдсан. | /-/ |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр 100%-ийг/ | зураг төсөв"-ийн жагсаалтад багтсан 500000000 /таван зуун/ сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах, үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлын хүрээнд ордын штольня-1, штольня-2 болон штольня-5 хэвтээ амнуудаас хүдэр тээвэрлэх технологийн зам, гүүр, туннелийн шинэ маршрут тодорхойлох" нарийвчилсан зураг төслийг хийх ажлын даалгаврыг УУХҮЯ-ны ТНБДаргаар батлуулж, 2021.04.09-ний өдрийн 03/949 дугаар албан бичгээр БХБЯ-ны ТНБДарга С.Магнайсүрэнд хүргүүлсэн. БХБЯ-ны сайдын 2021.06.02-ны 1/2087 тоот албан бичгээр дээрх ажил дэлгэрэнгүй жагсаалт үүсгэх мэдүүлэг авах шатанд байна гэсэн хариу ирүүлсэн.<br>Зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалтыг 60%-д хүрсэн. Ордын хэмжээнд 5000 га талбайд М 1:2000 гадаргын бүрэн зураглал хийх, тусгай зөвшөөрлийн хил хязгаар тогтоох шав тэмдэг тавих тендерийн баримт бичиг, техникийн даалгаврыг боловсруулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулахаар ажиллаж байна.<br>Асгатын нөөцийн тодотголын тайланг хийхээр тендер 2020 онд зарласан. Сонгон шалгаруулалтаар Стийл-Айрон ХХК шалгарсан бөгөөд давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээг 2021.06.01-ний өдөр хүртэл сунгасан. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Гэрээний хугацааны дагуу боловсруулсан тайланг хүлээж авсан бөгөөд тайланд шинжээч томилуулахаар ажиллаж байна.<br>“Эрдэнэс Монгол” ХХК нь Баян-Өлгий аймгийн Ногооннуур суман дахь өөрийн эзэмшлийн “Асгат”-ын мөнгө, полиметаллын ордын эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай геологи хайгуулын ажил хийх, дэд бүтэц, уулын баяжуулах, боловсруулах, цэвэршүүлэх үйлдвэрийн инженерчлэл, барилгын ажлыг төлөвлөх, ашиглалтад оруулах, бүтээгдэхүүн гаргах, худалдах замаар үр ашигтайгаар ашиглах зорилгоор АНУ-ын “Commonwealth American Partners” хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлтэй “Хамтын ажиллагаа, түншлэлийн санамж бичиг”-ийг 2021.08.30-ны өдөр Улаанбаатар хотноо байгуулсан.<br>Санамж бичигт тусгагдсан үе шаттай ажлуудыг цаашид шуурхай зохион байгуулж, хэрэгжүүлэх зорилгоор тус хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн төлөөллийг Монгол Улсад урьсан бөгөөд энэхүү уулзалтын үеэр хөрөнгө оруулалтын асуудал болон тусгай зөвшөөрлийг хөрөнгө оруулагч талтай хамтран эзэмших асуудлаар санал солилцсоны үндсэн дээр холбогдох тооцоо судалгааг хийж Засгийн газарт танилцуулахаар ажиллаж байна. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 43 | | 2.6.3. Асгатын мөнгөний ордод нэмэлт хайгуул хийх. | Нэмэлт хайгуулын ажлын явц | 0 хувь | 100 хувь | Гадаадын шууд хөрөнгө оруулалт | | Цар тахалтай холбоотой төсөв танах ЗГ-н чиглэлийн дагуу төсвийн санхүүжилт цуцлагдсан. | |
| 44 | | 2.6.4. Асгатын мөнгөний ордын дэд бүтэц, бэлтгэл ажил. | Дэд бүтэц, бэлтгэл ажлын явц | 0 хувь | 100 хувь | Гадаадын шууд хөрөнгө оруулалт<br><br>"Эрдэнэс Монгол" ХХК | | Асгатын ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах үйл ажиллагааг идэвхжүүлэх ажлын хүрээнд хүдэр тээвэрлэх технологийн зам, гүүр, туннелийн шинэ маршрут тодорхойлох нарийвчилсан зураг төслийн ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Эн Би Си Си” ХХК болон ЗТХЯ, УУХҮЯ-ны төлөөлөл оролцсон хурлыг 2022.07.06-ны өдөр зохион байгуулж, тус компаниас ТЭЗҮ, Зураг төсөл боловсруулах төслийн ажлын явц, тулгамдаж буй асуудал болон холбогдох асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцсэн. Улмаар тус компаниас холбогдох асуудлаар үндэслэл бүхий тайлбар, тооцоо судалгаа, саналыг 2022.07.19-ны өдрийн 186 дугаар албан бичгээр хүлээн авч Эрдэнэс Монгол ХХК-нд уг асуудлыг судлан үзэж яаралтай хариу ирүүлэхийг даалгасан. “Эрдэнэс Монгол” ХХК-иас ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх нарийвчилсан төлөвлөгөө ирүүлээгүй байна. | 30 |
| 45 | | 2.7. Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах. | Баяжуулсан нүүрсний хэмжээ | 0 | 10 сая.тн/жил | Хувийн хөрөнгө оруулалт, Зээл<br><br>263,472.9 /Төрийн өмчит компанийн | УУХҮСайдын 2020 оны А-292 дугаар тушаалаар байгуулагдсан стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн ордод үйл ажиллагаа эрхэлж байгаа “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн техник, эдийн | Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн гүйцэтгэл 20%-тай байна. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7 хувьд хүрсэн. Ачилтын нэгдсэн төвийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 46.1%-тай байна. Загийн усны хоолой усан | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санхүүжилтаар 30%-ийг, бүтээгдэхүүн урьдчилан борлуулах гэрээгээр 70%-ийг/ 2021 он<br><br>640,188.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ 2022 он | засгийн үндэслэлд шүүмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчдийн хэсэг нүүрс баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд холбогдох дүгнэлтийг 2021.01.22-ны өдөр төсөл боловсруулагчид өгсөн бөгөөд ЭБМЗ-ийн 2021.04.01-ний өдрийн өргөтгөсөн хурлаар нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г хэлэлцэн хүлээн авсан.<br>Тавантолгойн нүүрсний баяжуулах үйлдвэрийг 2021 оны гуравдугаар улиралд багтаан барьж эхлүүлэх арга хэмжээний тухай тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2021.04.28-ны өдрийн 113 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Улмаар Засгийн газрын 2021 оны 113 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 335.6 сая. ам долларын өртөг бүхий жилд 10 сая.тн нүүрс баяжуулах хүчин чадалтай эхний үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2021.08.13-ны өдөр зарласан бөгөөд 2021.09.27-ны өдөр хааж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан боловч шалгарсан хуулийн этгээд нь зураг төсөл боловсруулагч Чайна Металлуржикал Инженеринг ХХК-тэй хамаарал бүхий байх тул 2021.11.15-нд тендерийг ахин зарласан байна. Тендерийн материал хүлээн авах хугацаа 2021.12.15-нд дуусах | хангамжийн төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн бөгөөд төслийн нийт гүйцэтгэл 69.7%-д хүрсэн. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бөгөөд материал хүлээн авсны дараа 28 хоногийн дотор үнэлгээ болон гэрээ байгуулах ажлыг хийхээр хүлээгдэж байна. | | |
| 46 | | 2.7.1. Нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийг шинээр нэвтрүүлэх. | Тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлтийн явц | 0 хувь. | 21 хувь | Хувийн хөрөнгө оруулалт, Зээл<br><br>61,742.6 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр 30%-ийг, бүтээгдэхүүн урьдчилан борлуулах гэрээгээр 70%-ийг/ 2021 он<br><br>2022 оны хагас жилийн байдлаар 86.0 тэрбум төгрөг зарцуулсан.// | "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 245 дугаар тогтоолын дагуу тус яам нь тус компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийн хэрэгжүүлэгчийн үүргийг гүйцэтгэж байна.<br>Энэ хүрээнд тус яамнаас "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд удирдаж хүргүүлэн ажиллаж (2021.05.24-ний өдрийн 01/1345) байна. Улмаар "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020.12.31-ний өдрийн 20 дугаар тогтоолоор батлагдсан тус компанийн хөрөнгө оруулалтын 2021 оны төсөвт техник, тоног төхөөрөмжийн худалдан авахад шаардагдах хөрөнгө оруулалтыг тусгасан.<br>Мөн тус яамнаас "Эрдэнэс Тавантолгой" ХК-д Тавантолгойн ордын Цанхийн зүүн уурхайн гэрээт олборлогчоор ажиллаж байсан "Ти Ти Жи Ви Си Өү" ХХК-ийн хувьцаа эзэмшигч Сингапур улсын Five Hills Holdings PTE LTD компаниас өөрийн компанийн хувьцааг худалдах саналыг ирүүлсэнтэй танилцаж, саналыг олон улсын болон манай улсын хууль, тогтоомжиийн хүрээнд | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2021 онд нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 5 хувьд хүргэхээр төлөвлөсөн. 2022 оны байдлаар уурхайд 86 тэрбум төгрөг бүхий 23 ш техник, тоног төхөөрөмжийг худалдан авч нүүрс, хөрс тээврийн техник, тоног төхөөрөмжийн нэвтрүүлэлт 7%-д хүрсэн. 130 тн даацтай автосамосвал 12 ш, 12 м3 утгуурын багтаамжтай экскаватор 2ш, 7-8 м3 утгуурын багтаамжтай экскаватор 2 ш, 13.7 м3 хутганы багтаамжтай бульдозер 1 ш, 10 м3 хутганы багтаамжтай дугуйт түрэгч 1ш, 8.5 м3 хутганы багтаамжтай бульдозер 1 ш, 4.3 м3 хутганы урттай автогрейдер 1 ш, тус бүр 20 м3 ёмкостой усны болон түлшний автоцистерн зэрэг техник тоног төхөөрөмжүүдийг худалдан авсан байна. | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | судлан үзэхийн зэрэгцээ “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-ийн эзэмшиж байгаа тоног, төхөөрөмж барилга байгууламж болон бусад хөрөнгийн үнэлгээг тодорхойлж ирүүлэх чиглэлийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх удирдлагад өгөх албан бичгийг боловсруулан 2021.06.10-ны өдөр хүргүүлсэн.<br>“Эрдэнэс Тавантолгой” ХК 2021 онд 12ш автосамосвал, 1ш дугуйт ачигч, 1ш бульдозер, 2ш экскаватор шинээр худалдан авсан байна. | | |
| 47 | | 2.7.2. Цанхийн баруун уурхайд хөрсний конвейерийн систем нэвтрүүлэх. | Конвейерийн систем нэвтрүүлэлтийн явц | 0 хувь | 79 хувь | Хувийн хөрөнгө оруулалт, Зээл<br><br>"Эрдэнэс-Тавантолгой" ХК<br><br>2022 онд 99.30 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ | | Конвейерийн системийн ТЭЗҮ боловсруулах, зөвлөх үйлчилгээг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн инженерүүд гүйцэтгэж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/249 дугаар тушаалаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордын ил уурхайн хөрс, нүүрс тээвэрт авто-конвейерийн хосолсон тээвэр бүхий мөчлөг-урсгал технологи нэвтрүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт гаргах үүрэг бүхий Шинжээчийн хэсгийн шүүмжийг нэгтгэн урьдчилсан байдлаар 2022.10.20-ны өдөр Цахимаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-д хүргүүлсэн. Шинжээчдийн шүүмжийг хүлээн авч | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | холбогдох засварын ажлыг гүйцэтгэж байна. | |
| 48 | | 2.7.3. Нүүрс баяжуулах үйлдвэрийн 1 дүгээр модулийг барьж байгуулах. | Бүтээн байгуулалтын ажлын явц | 0 хувь | 100 хувь | 263,472.9 /Төрийн өмчит компанийн санхүүжилтаар 30%-ийг, бүтээгдэхүүн урьдчилан борлуулах гэрээгээр 70%-ийг/<br><br>Хувийн хөрөнгө оруулалт, Зээл "Эрдэнэс-Тавантолгой" ХК 2022 онд 355.66 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. | УУХҮСайдын 2020 оны А-292 дугаар тушаалаар байгуулагдсан стратегийн ач холбогдол бүхий Тавантолгойн ордод үйл ажиллагаа эрхэлж байгаа “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлд шүүмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээчдийн баг холбогдох дүгнэлтийг 2021.01.22-ны өдөр төсөл боловсруулагчид өгсөн бөгөөд ЭБМЗ-ийн 2021.04.01-ний өдрийн өргөтгөсөн хурлаар нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г хэлэлцэн хүлээн авсан.<br>Тавантолгойн нүүрсний баяжуулах үйлдвэрийг 2021 оны гуравдугаар улиралд багтаан барьж эхлүүлэх арга хэмжээний тухай тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2021.04.28-ны өдрийн 113 дугаар тогтоолоор батлуулсан.<br>Улмаар Засгийн газрын 2021 оны 113 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 335.6 сая. ам долларын өртөг бүхий жилд 10 сая.тн нүүрс баяжуулах хүчин чадалтай эхний үйлдвэрийн барилгын зураг төсөв боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2021.08.13-ны өдөр зарласан бөгөөд 9 дүгээр сарын 27-ны өдөр хааж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан боловч шалгарсан хуулийн этгээд нь | Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн барилгын материалын татан авалтыг 2022 оны 10 дугаар сард хийж, суурь судалгааны ажлуудыг бүрэн дуусгасан. Үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн захиалгыг хийж, үйлдвэрлэлийг эхлүүлсэн бөгөөд анхдагч нүүрс хадгалах агуулахын суурийн цутгалтын ажил явагдаж байна. Нийт ажлын гүйцэтгэл 20%-тай байна. | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зураг төсөл боловсруулагч Чайна Металлуржикал Инженеринг ХХК-тэй хамаарал бүхий байх тул 2021.11.15-нд тендерийг ахин зарласан байна. Тендерийн материал хүлээн авах хугацаа 2021.12.15-нд дуусах бөгөөд материал хүлээн авсны дараа 28 хоногийн дотор үнэлгээ болон гэрээ байгуулах ажлыг хийхээр хүлээгдэж байна. | | |
| 49 | | 2.7.4. Ачилтын нэгдсэн төв байгуулах. | Бүтээн байгуулалтын ажлын явц | 0 хувь | 100 хувь | 28,452.8 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр 30%-ийг, бүтээгдэхүүн урьдчилан борлуулах гэрээгээр 70%-ийг/<br><br>"Эрдэнэс-Тавантолгой" ХК<br><br>38,126.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ | Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв /салбар төмөр зам, ачих байгууламж/-барилга байгууламжийг барьж байгуулах ажлын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах, хянан баталгаажуулж, барих тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2021.04.07-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор батлуулсан. Улмаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн 2021.11.24-ний өдрийн 16 дугаар хуралдаанаар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрс ачих логистикийн төвийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцээд хүлээн авсан болно. | Тавантолгойн нүүрсний ордын ачилтын нэгдсэн төв байгуулах ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж, хүлээн авсан. Тавантолгойн нүүрсний ордын ачилтын нэгдсэн төвийн үндсэн тоног төхөөрөмжүүдийн худалдан авалтын захиалга хийгдсэн бөгөөд төслийн бүтээн байгуулалтын ажил 2022.04.22-ны өдөр эхэлсэн. Төслийн гүйцэтгэл 44.9%-тай байна. Төслийн ажлын зураг төслийг Өмнөговь аймгийн Ерөнхий архитектур болон холбогдох яам, тамгын газраар баталгаажуулах ажил хийгдэж байна. | 50 |
| 50 | | 2.7.5 Усан хангамжийн системийг барьж байгуулах. | Бүтээн байгуулалтын ажлын явц | 0 хувь | 100 хувь | Хувийн хөрөнгө оруулалт | Тавантолгойн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн бүтээн байгуулалт /нүүрс угаах үйлдвэр, кокс-эрчим хүчний үйлдвэр/-д шаардлагатай 220 л/с усыг Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших | "Тавантолгойн ордыг түшиглэн баригдах төслүүдийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбарыг тодорхойлж шийдвэрлүүлэхтэй | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Эрдэнэс-Тавантолгой" ХК<br><br>72,839.2 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр 100%-ийг/<br><br>71,931.4 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр/ | Цагаан цавын газрын доорх усны ордоос хангах саналыг Засгийн газрын 2021.04.28-ны өдрийн 113 дугаар тогтоолын төсөл, танилцуулгад тусган ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Тавантолгойн нүүрсний ордод түшиглэн байгуулагдах Нүүрс баяжуулах үйлдвэрт шаардлагатай усны хэрэгцээг “Загийн усны хоолой” газрын доорх усны ордоос хангах шугам, хоолой татах барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн 2022 оны төсөвт 72.3 тэрбум төгрөгийг тусгасан. Мөн компанийн зүгээс усны нөөц ашиглахад шаардлагатай дүгнэлт, зөвшөөрлийг БОАЖЯ-ны “Монгол Ус” ТӨҮГ, Галба өөш – Долоодын говийн сав газрын захиргаа зэрэг байгууллагуудаас авсан ба Загийн усны хоолойн газрын доорх усны ордоос Тавантолгой уурхай хүртэл 70 км шугам хоолой татах трассыг баталгаажуулан захирамж гарган, ус хангамжийн системийг цахилгаанаар хангах техникийн нөхцөлийг ЭХЯ болон Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-аар гаргуулсан. | холбогдуулан Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэр болон кокс, эрчим хүчний үйлдвэрт шаардлагатай ус хангамжийг шийдвэрлэх боломжит хувилбарыг боловсруулан ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулга (presentation) бэлтгэн 2022.01.26-ны өдрийн засгийн газрын хуралдаанд танилцуулж, ЗГ-ын 2022.01.26-ны өдрийн 06 дугаар тэмдэглэл гарсан.<br><br>Тавантолгой нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээтэй уялдуулан өмнийн говийн бүтээн байгуулалтад шаардагдах ус хангамжийн найдвартай эх үүсвэрийг хангах ажлын хүрээнд нүүрс баяжуулах үйлдвэрийг усаар хангах “Загийн усны хоолой”-н газрын доорх усны ордоос шугам, хоолой татах ажлын зураг төслийг БХБЯ-ны харъяа Барилга хөгжлийн төвийн шинжээчдийн магадлалаар баталгаажуулсан. Мөн ус татах шугам хоолойн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг батлуулсан. Загийн усны хоолойн газрын доорх усны ордоос ус татах шугам хоолойн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "ЧММ" ХХК, "Эс Энд Эй Трейд" ХХК, "Набсан" ХХК-тай гэрээ байгуулан, барилга угсралтын ажил явагдаж байна.<br>2023.01.06-ны өдрийн байдлаар: Гүний худгийн ажил 77%, Ус цуглуулах шугамын барилга угсралт | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 48%, Усан сангийн барилга угсралт 81%, Ус дамжуулах гол шугамын барилга угсралт 60%, Цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил 81%-тай тус тус гэрээний дагуу гүйцэтгэгдэж байна. Нийт ажлын гүйцэтгэл 69.7%-тай байна. | |
| 51 | | 2.8. Салхитын мөнгөний ордыг төслийн хүчин чадалд хүргэж ашиглах. | Боловсруулсан хүдрийн хэмжээ Төслийн хүчин чадлын ашиглалт | 300.0 мян.тн/ жил<br><br>50 хувь | 600.0 мян.тн/жил<br><br>100 хувь | Хувийн хөрөнгө оруулалт<br><br>46,200.0 /Төрийн өмчит компанийн санхүүжилтээр 100%-ийг/<br><br>"Эрдэнэс силвер ресурс" ХХК | “Эрдэнэс Монгол” ХХК нь үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг “Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хууль”-ийн хүрээнд зарцуулалт хийж, арилжааны банкнуудтай гэрээ хийж 228,493.0 иргэн 6 сая төгрөг, түүнээс доош дүнтэй зээлийн төлбөрөөс бүрэн чөлөөлөгдөж (үүний 43,892.0 иргэн 1 сая төгрөг хүртэлх зээлтэй), 2021.05.21-ний өдөр 194,807 иргэнд 1 сая төгрөгийн өдөр мөнгөжүүлсэн үнэт цаас эзэмшүүлэх замаар байгалийн баялгийн өгөөжөөс хүртээсэн.<br>(Нийт 423,300 тэтгэвэр авагч иргэн).<br>Жилд 600 мянган тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай баяжуулах үйлдвэр-II төслийг хэрэгжүүлэх хүрээнд үйлдвэрийн тоног төхөөрөмжийн худалдан авалт 90%, угсралт суурилуулалт 80%, барилгын материалын татан авалт 90%, барилга угсралтын ажил 80%, дэд бүтцийн ажил 80% гүйцэтгэлтэй байна.<br>Ковид цар тахлын нөлөөлөл, хөл хорио, Монгол Улсын хил, гаалийн хориг зэргээс | Салхит уулын Баяжуулах 1 дүгээр үйлдвэр жилд 300 мян.тн хүдэр боловсруулах хүчин чадалтай бөгөөд 2022 оны 05 дугаар сарын байдлаар 1,194.9 тонн баяжмал боловсруулан тасралтгүй ажиллаж байна.<br>Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр бараа материал, тоног төхөөрөмжийн хомстол үүсч, татан авалт удааширсны улмаас Баяжуулах 2 дугаар үйлдвэр төлөвлөгөөт хугацаанд ашиглалтад оролгүй хойшилсон. 2022 оны 11-р сарын байдлаар 92.6 мян.тн хүдэр олборлож, 33.5 мян.тн хүдэр, 1.97 мян.тн баяжмал борлуулж, 45.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн. ЗГҮАХ-т хамрагдсан зорилтуудын хүрээнд ажлын гүйцэтгэл, тулгамдагдаж байгаа асуудлын талаар холбогдох эрх бүхий албан тушаалтантай холбогдож сар, улирал тутам мэдээлэл авч, хэлтэс, газрын дарга яамны удирлагуудад мэдээлэл танилцуулга бэлтгэн хүргүүлж ажиллаа. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үүдэлтэй шинэ баяжуулах үйлдвэрийн барилгын явц график төлөвлөгөөнөөс хоцорч, үйлдвэрийн тоног төхөөрөмж, барилгын материалууд 2 сар гаруй хугацаатай Хятад, Монголын хил гааль дээр саатаж байгаа зэрэг нь шинэ үйлдвэрийг төлөвлөгөөт хугацаанаас хоцрогдолтойгоор ашиглалтад оруулах нөхцөл байдал үүссэн. Дээрх хил, гаалийн хоригоос үүдэлтэй хүндрэлийг шийдвэрлэх хүрээнд тус яам нь Хилийн Замын-Үүд боомтын зөвлөлд хандаж бүтээн байгуулалтын ажилд шаардлагатай бараа материалыг хил, гаалиар саадгүй нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж ажилласан.<br>Салхитын мөнгөний ордын нөөцийг нэмэгдүүлж, ордын насжилт өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор 2020 оны хайгуулын ажлын хүрээнд хийгдсэн геологи хайгуулын нарийвчилсан ажлын үр дүнд ордын нөөцийг бодитой ба боломжтой /B+C/ зэрэглэлээр 3,169,815.5 тонн хүдрийн нөөцийг ЭБМЗ-өөр 2021.04.15-ны өдөр хэлэлцүүлж Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн.<br>Мөн Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан тус төслийн ажлын гүйцэтгэл, биелэлтийг сар, улирал тутамд авч, хагас жил тутам тайланг нэгтгэн Засгийн газарын хэрэг эрхлэх газарт уламжилж байна. | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй “Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь” MERIT төслийн дэмжлэгтэйгээр “Эрдэнэс силвэр ресурс” ХХК хариуцан хэрэгжүүлэх Салхитын мөнгөний ордын Хаалтын менежментийн төлөвлөгөөг загвар байдлаар боловсруулах төслийг хамтран хэрэгжүүлж байна. | | |
| 52 | | 2.9. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах. | Ашиглалтад орсон ордын тоо | 0 | 1 | Хувийн хөрөнгө оруулалт, зээл<br><br>Монголросцветмет ТӨҮГ<br><br>2022 оны хагас жилийн байдлаар 39.5 тэрбум төгрөг зарцуулсан | Зүүн Цагаан Дэлийн орд газрыг далд аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг (тодотгол) боловсруулж ЭБМЗ-ийн 2021.04.13-ны өдрийн хурлаар шийдвэрлүүлсэн.<br>Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглах бэлтгэл ажлын хүрээнд ТЭЗҮ, БОННҮ, Уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдийг батлуулах ажилд дэмжлэг үзүүлж ажилласан.<br>Мөн төсөл хэрэгжүүлэгч нь цахилгаан дамжуулах 6000 кВт-ын 3.5км түр агаарын шугамыг барьж, уурхайн налуу ам 80м нэвтэрсэн ба 2021 оны эцэст нэвтрэлтийн хэмжээ 120м-130м-т хүрнэ. Уурхайн ажилчдын байрыг засаж ашиглалтад оруулсан. | 2021 оны эцэс, 2022 оны эхээр Зүүн Цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглах ТЭЗҮ, БОННҮ, Уулын ажлын төлөвлөгөө, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулсан байна. Цахилгаан дамжуулах 6000 кВт-ын 3.5 км түр агаарын шугамыг барьсан. 2022 оны хагас жилийн байдлаар налуу ам болон бусад малталтуудын хэмжээнд 485 м нэвтэрч 4673 м3 уулын цулын ажил гүйцэтгэсэн байна. Уурхайн ажилчдын байрыг засаж ашиглалтад оруулсан.<br>Зүүн цагаан дэлийн далд уурхайн эхний ээлжийг 2022.09.28-ны өдөр Улсын комисст хүлээлгэн өгсөн. Зүүн Цагаан дэлийн хайлуур жоншны далд уурхайн 2 налуу гол амны малталт нэвтрэлтийн ажлыг гүйцэтгэж, 2022 оны 12 дугаар сарын байдлаар 1199.5 у.м нэвтэрч, /9894,7 м3 уулын цул нураасан уулын ажил хийж 78.9% гүйцэтгэлтэй байна. Уурхайн доод түвшин 1150 м. Уурхайн дэд бүтэц цахилгаан | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | дамжуулах агаарын шугам барих болон кэмпийн барилга байгууламжийн ажил 85% гүйцэтгэлтэй байна. Зүүн цагаан дэлийн жоншны далд уурхайг ашиглалтад оруулах бэлтгэл ажил 50 хувьд хүрсэн. Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 100%. ЗГҮАХ-т хамрагдсан зорилтуудын хүрээнд ажлын гүйцэтгэл, тулгамдаж байгаа асуудлын талаар холбогдох эрх бүхий албан тушаалтантай холбогдож сар, улирал тутам мэдээлэл авч ажилласан. | |
| 53 | | 2.10. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрүүдийг байнгын ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулж, уурхай, үйлдвэрийг ашиглалтад оруулах. | Байнгын ашиглалтад хүлээн авсан уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн тоо | 104 | 184 | Улсын төсөв, Хувийн хөрөнгө оруулалт | “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах түр заавар”-ын төслийг боловсруулж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021.02.08-ны өдрийн А/16 дугаар тушаалаар батлуулсан.<br>2021.12.31-ний өдрийн байдлаар нийт 39 уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах ажлыг зохион байгуулсан байна. | “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах түр заавар”-ыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2021.02.08-ны өдрийн А/16 дугаар тушаалаар батлуулсан.<br>2022 онд Улсын комисс ажиллуулах тухай хүсэлт гаргасан Багануур ХК, Хуучин андууд ХХК, Монгойн гол ХК, Бэрх Уул ХК, Хавчигийн ам ХХК, Цэзцээ импекс ХХК, Будар минералс ХХК, Мандах дорнын жонш ХХК, Жамц давс ХХК, Эрдэнэмайнинг үйлс ХХК, Тэвхэн ХХК, Айваору ХХК, Дамбат ХХК, Монгол базальт ХХК, Алтан дун дорнод Монгол ХХК, Уулс заамар ХХК, Монжин далай ХХК, Вестернресурс ХХК, Дэмси трейд ХХК, Алтан гол эксплорейшн ХХК, Меланж ХХК, Сэлэнгэ минералс ХХК, Хархорум сүлд ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Оюутолгой ХХК, Есөнхаш Эрдэнэ ХХК, Хан-Алтай ресурс ХХК, Монголросцветмет ТӨҮГ, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Чамин алт ХХК, Хана интернейшнл ХХК, Идэр макс ХХК, Очир мандал хайрхан ХХК, Түмэн айл инвест ХХК, Стархолдинг ХХК-иудын нийт 34 уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаатай нь газар дээр нь болон цахимаар танилцаж, холбогдох дүгнэлт гаргасан. | |
| **Үндсэн чиг үүрэг-3: Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх.** | | | | | | | | | |
| 54 | Зорилт-4: Уул уурхайн салбарын ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хэрэгжилтийг зохицуулах, байгууллагын дэргэдэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороодын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах. | 4.1.Уул уурхайн салбарын ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг хангах. | Боловсруулсан хөтөлбөрийн тоо | 0 | 3 | Улсын төсөв | | Жил бүрийн 4 сард “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ыг Улс орон даяар салбар салбарт зохион байгуулдаг ба Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт ч мөн ХАБЭА-н сарын аяныг өргөн дэлгэр зохион байгуулдаг. Сарын аяныг салбарын хэмжээнд зохион байгуулах тухай салбар хорооны даргын 2022 оны 4-сард А/24 дугаар тушаал, удирдамжийг батлан аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлсэн. Сарын аяны хүрээнд 2022.04.14-ний өдөр Салбарын аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтнуудад “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, шаардлага ISO 45001:2018 стандартын танилцуулах сургалт”-ыг “Монголын алт МАК” ХХК болон Мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн холбоо /МОШПА/ ТББ-тай хамтран зохион байгуулсан. Онцгой байдлын ерөнхий газрын харъяа Уул уурхайн аврах ангитай хамтран “Уурхай, уулын баяжуулах | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үйлдвэрүүдийн аюул, ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах болон салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрхзүйн орчны талаар мэргэшил аргазүйн зөвлөмж өгөх сургалт, зөвлөлдөх уулзалт"-ыг аж ахуйн нэгж, байгууллагуудын ХАБЭА-н ажилтнуудад зохион байгуулсан. "Эрүүл, аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага" болзолт уралдаанд жил бүр уул уурхайн салбарын аж ахуйн нэгж, байгууллагууд идэвхитэй оролцоход дэмжлэг үзүүлэн ажилладаг ба 2018-2021 оны уралдааныг зохион байгуулах ажлын хэсэгт салбар хорооны гишүүдээс орж ажиллаж ирсэн. "Эрүүл, аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага-2021" уралдаанд Уул уурхайн салбарын хэмжээнд "Ачит Ихт" ХХК 1-р байр, "Хүрэн толгой коал майнинг" ХХК 2-р байр тус тус эзэлсэн. Уул уурхайн салбарын мэдээ, мэдээллийг нийтэлдэг "Эрдэс баялгийн тойм" сонин ХАБЭА-н салбар хорооноос хийж хэрэгжүүлж буй ажил, цаашдын зорилтын талаар цуврал нийтлэл, ярилцлагыг 5, 6 дугаар саруудад нийтэлсэн. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдтэй хамтын ажиллагааг идэхвижүүлэн Салбарын аж ахуйн нэгжүүдийн ХАБЭА-н сайн туршлагын түгээн дэлгэрүүлэх чиглэлд | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | туршлага судлах аялалын уурхайнуудын ХАБЭА-н ажилтнуудын хооронд зохион байгуулж байна. 2022 оны 7 дугаар сард салбар хорооны гишүүд “Монголын алт МАК”-ын хийт бетон болон цонх, хаалганы үйлдвэртэй танилцах, туршлага судлах, хөдөлмөрийн эрүүл мэнд, нөхцөлийн талаар зөвлөгөө өгч ажиллав. Орчин цагийн уул уурхайн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд “Mining week” салбар сурталчлах арга хэмжээний хүрээнд “Нэн түрүүнд ХАБ-2022” Уул уурхайн салбарын салбар хуралдааныг 2022.09.14-ний өдөр Оюутолгой ХК болон МОШПА ТББ-тай хамтран Шангрилла зочид буудлын хурлын бага танхимд зохион байгуулав. Бага хуралд танхимаар 140 гаруй хүн, цахимаар 150 гаруй хүмүүс оролцож, сайн туршлага, уурхайчдын ХАБЭА-н тулгамдсан асуудлаар илтгэл, хэлэлцүүлэг өрнүүлэв. Уул уурхайн салбарын 100 жилийн хүрээнд “Алтан бамбай-2022” аврах ажиллагааны тэмцээнийг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай хамтран зохион байгуулж, салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, гамшиг, ослоос хамгаалах, аврах, эрэн хайх бэлэн байдлыг хангах, | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | чадварыг эзэмшүүлэх, туршлага солилцох зорилготойгоор 2022.09.29,30-ны өдрүүдэд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын баяжуулах үйлдвэрийн полигон дээр зохион байгууллаа. Тэмцээнд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 6 баг, Монголын алт МАК ХХК, Бороогоулд ХХК, Баян-Айраг ХХК, Эрдмин ХХК зэрэг багууд урилгаар оролцож, харилцан туршлага судлав. | |
| 55 | Зорилт-5: Байгаль орчныг хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын менежментийн төлөвлөлтөд үнэлэлт дүгнэлт өгөх, хэрэгжилтийг хангуулах. | 5.1. Уурхайн нөхөн сэргээлт, уурхайн хаалтын менежментийн төлөвлөлтөд үнэлэлт, дүгнэлт өгөх, хэрэгжилтийг хангуулах. | Хаалтын менежментийн төлөвлөлтийн тоо | 2 | 6 | Улсын төсөв | | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд уг асуудлыг тусгасан бөгөөд уурхайн хаалтын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх зорилгоор шинээр зүйл тусгахаар ажиллаж байна.<br>Мөн Канад улсын санхүүжилттэй Мерит төслийн хүрээнд Эрдэнэс силвер ресурс ХХК-ийн Салхитын мөнгөний ордын хаалтын менежментийн төлөвлөгөөг загвар байдлаар боловсруулах төслийг хэрэгжүүлж байна. | 50 |
| 56 | Зорилт-6: Уул уурхайн салбарын судалгаа, шинжилгээ, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх. | 6.1. "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв"-ийг байгуулах. | Шинээр байгуулагдсан далд уурхайн музейн тоо | 0 | 1 | Улсын төсөв, хувийн хөрөнгө оруулалт 2,500.0 /Улсын төсөвөөр 100 хувь / 2021 он | Төсөл, арга хэмжээний сургалт, судалгааны төвийн барилгын засвар өргөтгөл, шинэчлэлийн ажил гүйцэтгэх гэрээг "Хөх майдар" ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд гэрээт ажлыг 2021.06.15-ны өдөр хүлээн авахаар ажиллаж байна.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2021.11.29-ний А/287 дугаар тушаалаар "Монголын далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв /Хэнтий, Батноров Сум, Бэрх тосгон/" төсөл, арга хэмжээний газрын доор | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх "Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв" төсөл хэрэгжүүлэх нэгж нь Монгол улсад уул уурхайн хаалтын менежментийн жишиг тогтоох, хаагдсан уурхайг эдийн засгийн эргэлтэд оруулах, уул уурхайн салбарын мэргэжлийн боловсон хүчин, оюутан, залуучуудын сургалт судалгааны бааз, аялал жуулчлалын төвийн бүтээн байгуулалтын ажлыг батлагдсан техник-эдийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | малталт, нэвтрэлтийн ажлын гүйцэтгэлтэй газар дээр нь танилцаж, хүлээн авах үүрэг бүхий Комисс томилогдсон. Тус комиссын Нарийн бичгийн даргаар ажиллаж гарын доор малталт, нэвтрэлтийн ажил гүйцэтгэх гэрээт ажлыг дүгнэн акт үйлдэж хүлээн авсан. | засгийн үндэслэлийн дагуу зохион байгуулж байна.<br>Өнөөгийн байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төслийн талбайд гадна шугам сүлжээ, цахилгаан хангамж, өргөх машины барилга угсралт, сургалт судалгааны төвийн барилга засвар, өргөтгөл шинэчлэл, төв вентиляторын барилгын засвар, газрын доорх 810 метрийн урттай сургалтын болон музейн зориулалт бүхий байгууламжуудын малталт нэвтрэлтийн ажлууд, дэд бүтцийн болон инженерийн хангамжийн ажлууд бүрэн хийгдэж, төслийн бүтээн байгуулалтын 2022 оны төлөвлөгөөний дагуу уурын зуухны барилга, гадна холбоо дохиоллын ажлыг гүйцэтгэж хүлээн авах комиссыг ажиллуулж, мэдээллийн төв болон музейн барилга, гадна тохижилтын ажлын гүйцэтгэгчтэй гэрээг байгуулан гэрээний дагуу ажлыг гүйцэтгэж байна.<br>Монголросцветмет ТӨҮГ-ын хөрөнгө оруулалтаар 27 га буюу 653 000 шоо метр эвдэрсэн талбайн нөхөн сэргээлтийн ажлыг 70 хувийн гүйцэтгэлтэй хийж байна.<br>Төслийн үе шатны ажлын төлөвлөгөөний дагуу “Монголын далд уурхайн музей, сургалт судалгаа, аялал жуулчлалын төв”-ийн Монголын үйлдвэрлэлийн түүхэн танхим, Монголын уул уурхайн үүсэл хөгжлийн танхим, эрдсийн музей болон мэдээллийн төвийн интерьер, тохижилт, | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | засварын ажил, түүхийн танхимуудын үзмэр, оюутны дотуур байрны барилгын ажлыг 2023 оны төлөвлөгөөнд тусгаад байна. | |
| **3. Ерөнхий чиг үүргийн нэр: Газрын тосны салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.** | | | | | | | | | |
| **Үндсэн чиг үүрэг-1: Газрын тосны салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах.** | | | | | | | | | |
| 57 | Зорилт-1: Газрын тосны салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах. | 1.1.Газрын тосны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах. | Батлуулсан хуулийн тоо | 0 | 1 | Улсын төсөв | Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮС-ын 2021 оны А/12 дугаар тушаалаар байгуулав. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдээс санал авахаар 2021.09.09-ний өдрийн 08/2198 дугаартай албан бичгийг хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж, Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлал болон танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо зэрэг судалгааны тайлангуудыг тус тус боловсруулсан.<br>Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 7.2 дахь хэсэгт нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, үзэл баримтлал болон | УУХҮСайдын 2021.01.18-ны өдөр А/12 дугаар тушаалаар газрын тосны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааг хийж, хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төсөлд санал авахаар яамны сайтад 2022.07.07-ны өдөр байршуулсан.<br>Хуулийн төсөл намрын чуулганы жагсаалтад ороогүй тул хүлээгдэж байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | танилцуулгыг боловсруулсан. | | |
| 58 | | 1.2. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах. | Батлуулсан хуулийн тоо | 0 | 1 | Улсын төсөв | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас саналыг авч нэгтгэн 2021.11.17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д яаралтай горимоор өргөн барих тухай 60 дугаар тогтоолыг гаргуулсан. Үүнтэй холбоотой УИХ-ын хэлэлцүүлэгт орох, ЭЗБХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэх зэрэг ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. | Зөвшөөрлийн тухай хууль 2022.06.17-ны өдөр батлагдсантай холбогдуулан “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж 2023.01.01-ний өдрөөс дагаж мөрдөгдөж эхэлнэ. “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл УИХ-ын 2022.12.09-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлагдсан. “7.2.Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүний 30-аас дээш хувийг дангаараа нийлүүлж байгаа гадаадын хуулийн этгээд дотоодын зах зээлд өөрийн хөрөнгө оруулалт бүхий хуулийн этгээд болон өөрийн харъяалал, хяналтад байдаг нэгжээрээ агаарын хөлгийн түшнээс бусад бүтээгдэхүүнээ борлуулахыг хориглоно.” | 100 |
| 59 | | 1.3. Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах. | Батлуулсан хуулийн тоо | 0 | 1 | Улсын төсөв | Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Эксим банк хооронд байгуулсан “Зээлийн ерөнхий хэлэлцээр”-ийн хүрээнд хэрэгжүүлж буй газрын тос боловсруулах үйлдвэрийг төлөвлөсөн хугацаанд багтаан барьж байгуулах, төслийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, төрөөс үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох, эрхзүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор “Газрын тос боловсруулах үйлдвэрийг дэмжих тухай” хуулийн төслийг УИХ-ын чуулганы | - | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2021.01.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. | | |
| 60 | | 1.4. Газрын тосны салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, холбогдох бусад журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангах. | Боловсруулсан журмын тоо | 0 | 1 | Улсын төсөв, Гадаадын зээл тусламж | Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журамд УУХҮСайдын 2021.03.05-ны өдрийн А/45 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж, 2021.04.23-ны өдөр ХЗДХЯ- захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн. | “Газрын тосны салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийг УУХҮСайдын 2022.11.16-ны өдрийн А/287 дугаар тушаалаар батлуулж захиргааны хэм хэмжээнтий актын улсын нэгдсэн бүртгэлийн 6018 дугаарт бүртгүүлсэн. | 100 |
| **Үндсэн чиг үүрэг 2: Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлж, нөөц тогтоох, ашиглалт, олборлолтыг нэмэгдүүлэх.** | | | | | | | | | |
| 61 | Зорилт 2: Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэх, эрлийн гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах, нөөц тогтоох. | 2.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, хэтийн төлөв тодорхойлох. | Хөрөнгө оруулалтын хэмжээ | 43.9 тэрбум. төг | 283.7 тэрбум.төг | Хувийн хөрөнгө оруулалт<br><br>152,858.875 төгрөг (53,937,500 ам.доллар) /хувийн хэвшил/ 2022 он | Газрын тосны хайгуулын талбайд БХГ-ний дагуу үйл ажиллагаа явуулж буй “Метан газ ресурс” ХХК, “Жи Өү Эйч” ХХК, “Түмэн ойл” ХХК, “Смарт-ойл монголиа” ХХК, “Зон Хэн Юу Тиан” ХХК, “Монголын Алт” ХХК болон “Петровис ресурс” ХХК-иудын 2021 оны жилийн хайгуулын ажлын хөтөлбөр төсвийг батлаад байна. Үүнд:<br>-“Метан газ ресурс” ХХК уламжлалт бус газрын тосны хайгуулын БХГ-т Тавантолгой-XXXIII талбайд 1,402,193.67 ам.долларын хөрөнгө оруулалтаар 4800 тууш.м баганат өрөмдлөг, цооногийн каротаж, сорьцлолтын ажил, лабораторийн ажил, тээвэрлэлт, топогеодезийн ажил, байгаль орчны нөхөн сэргээлт, суурин боловсруулалтын ажил гүйцэтгэх.<br>-“Жи Өү Эйч” ХХК уламжлалт бус газрын тосны хайгуулын БХГ-т Номгон-IX талбайд 3,324,960.0 ам.долларын хөрөнгө оруулалтаар эрлийн маршрут, геологийн | Газрын тосны 3, нүүрсний давхаргын метан хийн 8, нийт 11 эрлийн ажил гүйцэтгэх гэрээ хэрэгжиж байна. 2022 онд газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын 12 талбайд 443 тууш.км бичил сейсмийн судалгаа, 1,050тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, 150 км.кв талбайд 3 хэмжээст чичирхийллийн судалгаа, нүүрсний давхаргын метан хийн 21,060 тууш.м өрөмдлөг, газрын тосны хайгуулын 4 цооног тус тус өрөмдөж нийт 33,1 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэхээр төлөвлөгөө, төсөв батлагдсан. 2023 оны эхний улирал гэрээлэгчид тайлан ирүүлсний дараа хөрөнгө оруулалтын дүн гарна.<br>Газрын тосны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.1-т заасны дагуу хайгуулын нээлттэй талбайнууд хамарч буй 14 аймгийн ИТХ-аас санал, дүгнэлт авахаар албан бичиг хүргүүлсэн. Одоогийн байдлаар 5 аймгийн ИТХ хуралдаж тогтоол ирүүлээд байна. Төв, Ховд, Дорнод | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зураглал, геологи, геофизикийн судалгааны боловсруулалт, техникийн мэдээллийн сан бүрдүүлэх, 2 хэмжээст чичирхийллийн судалгаа, судалгааны боловсруулалт, тайлал, тайлан, чанарын хяналт, 5000 тууш.м стратиграфийн цооног өрөмдөх, хайгуулын чөмөг дээжлэлттэй, IFOT хэмжилттэй цооног, туршилтын ажил, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх.<br>-“Түмэн ойл” ХХК газрын тосны хайгуулын БХГ-т Баянтүмэн-XVII талбайд 3,832,365.56 ам.долларын хөрөнгө оруулалтаар 2 хэмжээст чичирхийллийн ажлын тайлал хийж, дахин боловсруулах, 2850 тууш.м өрөмдлөгийн ажил, гидрогеологийн цооног өрөмдөх, геофизикийн судалгаа, шаврын судалгаа, цооногийн туршилт, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх.<br>-“Смарт-ойл монголиа” ХХК газрын тосны хайгуулын БХГ-т Эргэл-XII талбайд 10,783,114.54 ам.долларын хөрөнгө оруулалтаар геологи, геоморфлогийн судалгаа, талбайн өмнөх судалгааны мэдээлэл цуглуулах, 2 хэмжээст чичирхийллийн судалгааны бэлтгэл, параметрийн тест, хэмжилт, боловсруулалт, үр дүнгийн боловсруулалт, 3 хэмжээст чичирхийллийн судалгааны ажлын төлөвлөлт, зураг төсөл, бэлтгэл, параметрийн тест, хэмжилт, хээрийн | аймгийн ИТХ дэмжээгүй бөгөөд Өвөрхангай, Увс аймгийн ИТХ хуралдаж хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлахыг дэмжсэн. Үүнтэй холбогдуулан дэмжсэн тогтоол ирүүлсэн хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай УУХҮСайдын 2022 оны А/294 дугаар тушаал гарсан. Тус тушаалаар газрын тосны хайгуулын Номгон IX, Төхөм X хойд, Цагаан Элс XIII, Зүүнбаян XIV, Дарьганга XXIV талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Тушаалыг АМГТГ-т хүргүүлсэн.<br>Газрын тосны хайгуулын Гурванбаян-XXX талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахаар Баян петролиум ХХК-тай хэлэлцээрээр тохиролцсон гэрээний төсөлд яамдуудаас санал авч байна. Одоогийн байдлаар 17 санал ирсэн бөгөөд ЭЗХЯ-аас санал ирүүлээгүй байна. Саналыг нэгтгэж дуусгаад Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.<br>2022 онд нүүрсний давхаргын метан хийн 1, шатдаг занарын 1 тус тус БХГ байгуулах хүсэлт АМГТГ-т ирсэн.<br>Уламжлалт бус газрын тосны хайгуулын Номгон-IX талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуулын үйл ажиллагаа явуулж буй Австрали Улсын хөрөнгө оруулалттай Жи Өү Эйч ХХК хайгуулын шатанд өрөмдсөн 2 цооногт туршилтын ажил | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулалт, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх.<br>-“Зон Хэн Юу Тиан” ХХК газрын тосны хайгуулын БХГ-т Галба-XI талбайд 3,011,247.6 ам.долларын хөрөнгө оруулалтаар хайгуулын 2 цооног өрөмдөх, цооногийн каротаж, шаврын судалгаа, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх.<br>-“Монголын Алт” ХХК газрын тосны хайгуулын БХГ-т Төхөм-X урд талбайд 17,309,120 ам.долларын хөрөнгө оруулалтаар хээрийн анги зохион байгуулалт, татан буулгалт, 500 тууш км 2 хэмжээст чичирхийллийн хээрийн ажил, хээрийн боловсруулалт, суурин боловсруулалт, тайлал хийх, тайлан бичих, 100 км2 3 хэмжээст чичирхийллийн хээрийн ажил, хээрийн боловсруулалт, суурин боловсруулалт, тайлал хийх, үр дүнгийн тайлан бичих, хайгуулын 5 цооногийн өрөмдлөгийн болон дизайн гаргах, давхарга зүйн цооногийн өрөмдлөг, цооногийн чөмөг чулуун дээж авах, шаврын судалгаа, цооногийн каротаж, цооногийн туршилтын ажил, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх.<br>-“Петровис ресурс” ХХК уламжлалт бус газрын тосны хайгуулын БХГ-т Т-I талбайд 427,999.00 ам.долларын хөрөнгө оруулалтаар астер зургийн тайлал, геофизикийн судалгаа, байгаль орчны | гүйцэтгэсэн ба цооногт хийн урсгал орж ирж туршилтын ажил үргэлжилж байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх, уламжлалт бус газрын тосны хайгуулын БХГ-т Богд-IV талбайд 545,864.00 ам.долларын хөрөнгө оруулалтаар сейсмийн судалгааны тайлал боловсруулах, геофизикийн судалгаа, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэх, уламжлалт бус газрын тосны хайгуулын БХГ-т Онги-V талбайд 467,251.00 ам.долларын хөрөнгө оруулалтаар 2 хэмжээст сейсмийн судалгааны тайлал боловсруулах, 3 хэмжээст сейсмийн судалгааны тайлал боловсруулах, геофизикийн судалгаа, байгаль орчны нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэхээр тус тус хөтөлбөр төсвийг баталсан.<br>Дээрх гэрээлэгчид 2021 онд хайгуулын ажилд нийт 40,676,116.37 ам.доллар зарцуулахаар төлөвлөгөө, төсөв батлагдсан.<br>Газрын тосны хайгуулын Матад-XX талбайн гэрээлэгч “Петроматад” ХХК, Онги-V талбайн гэрээлэгч “Капкорп Монголиа” ХХК, Тариач-XV талбайн гэрээлэгч “Чайна Голден Сий Петролиум Эксплорэйшн Корпорэйшн” ХХК, Арбулаг-XXIX талбайн гэрээлэгч “Макс ойл” ХХК-иуд 2021 оны төлөвлөгөө, төсвийг батлуулахаар ирүүлээгүй. Ковид цар тахлын нөхцөл байдлын улмаас хил, гааль нээгдээгүй байгаатай холбоотойгоор хүн хүч, техник тоног төхөөрөмж орж ирэх боломжгүй байгаа тул ихэнх гэрээлэгчдийн хайгуулын ажил хийгдэх | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боломжгүй болсон. Харин “Жи Өү Эйч” ХХК дотоод нөөц бололцоог ашиглан хайгуулын өрөмдлөгийн ажлыг 2021.03.08-ны өдрөөс эхлүүлсэн ба 2021.12.10-ний өдрийн байдлаар хайгуулын 14 цооног өрөмдөж дууссан. Нийт 3 цооногийн өрөмдлөгийн ажил явагдаж байгаа ба өрөмдлөгийн ажлыг “Эрдэнэ дриллинг” ХХК, “Топ даймонд дриллинг” ХХК-иуд гүйцэтгэж байна. Мөн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт 519 тууш.км 2 хэмжээст чичирхийллийн судалгааны ажил гүйцэтгэсэн ба туслан гүйцэтгэгчээр “Бичил сейсм” ХХК ажилласан. Эдгээр ажлуудад 3 сая гаруй ам.доллар зарцуулсан байна. | | |
| 62 | | 2.2. Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах. | Шинээр байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний тоо | 23 | 32 | Хувийн хөрөнгө оруулалт | АМГТГ-аас 2020.12.30-ны өдрийн 03/5769 дугаар албан бичгээр ирүүлсэн уламжлалт бус газрын тосны хайгуулын Гурвантэс-XXXV талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны талаар АМГТГ болон Тэлмэн Ресурс ХК-ийн хооронд байгуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан Засгийн тогтоолын төсөл, БХГ-ний төсөлд санал авах тухай УУХҮСайдын 2021.02.23-ны өдрийн 01/388 дугаар албан бичгийг бүх яамдад хүргүүлсэн. Сангийн сайдаас БХГ-ний нөхцлийг сайжруулах арга хэмжээ авах тухай санал ирүүлсэнтэй холбоотойгоор гэрээлэгч | Газрын тосны хайгуулын талбайнуудад шинээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулж, хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бэлтгэл ажлыг хангаж байгаа бөгөөд гэрээлэгчгүй байгаа 10 хайгуулын талбайд хийгдсэн хайгуулын ажлын жагсаалтыг гаргуулсан.<br>Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй газрын тосны хайгуулын “Хар Ус II” талбайд Ренова илч ХХК, “Номгон IX” талбайд Өмнөд Монголын газар нутгийн тос ХХК, “Дарьганга-XXIV” талбайд Монголиа шин ий энержи ХХК, “Хэрлэн тохой XXVIII” талбайд Хонгконг Вэлпэк Индастриал ХХК-тай тус тус байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээ цуцлах эрх | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | буюу хөрөнгө оруулагч талтай Гэрээний үлдсэн нөхцлийг сайжруулах талаар хэлэлцээр хийж, БХГ-ний төслийг дахин ирүүлэх тухай УУХҮСайдын 2021.05.11-ний өдрийн 01/1239 дугаар албан бичгийг АМГТГ-т явуулсан ба АМГТГ нь хөрөнгө оруулагч талтай дахин хэлэлцээр хийж, 2021.05.25-ны өдрийн 3/2188 албан бичгээр БХГ-ний төслийг дахин ирүүлсэн. Тус БХГ-ний төслийг хянан, бүх яамдаас санал авч нэгтгэн, Засгийн газрын 2021.07.07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Засгийн газрын 2021.07.07-ны өдрийн 203 дугаар тогтоолоор газрын тосны хайгуулын Гурвантэс-XXXV талбайд уламжлалт бус газрын тосны /нүүрсний давхаргын метан хий/ үйл ажиллагаа явуулах БХГ-г “Тэлмэн Ресурс ХК”-тай эрхийг АМГТГ-т олгосны дагуу 2021.07.27-ны өдөр БХГ-г байгуулсан. | олгох тухай тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2022 оны Засгийн газрын 337 дугаар тогтоол гарсан.<br>Газрын тосны хайгуулын Гурванбаян-XXX талбайд БХГ байгуулахаар Баян петролиум ХХК-тай хэлэлцээрээр тохиролцсон гэрээний төсөлд яамдуудаас санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. | |
| 63 | | 2.3. Газрын тосны хайгуулын талбайд шинээр орд нээж, нөөц тогтоох ажлыг зохион байгуулах. | Нөөц тогтоосон хайгуулын талбайн тоо | 0 | 1 | Хувийн хөрөнгө оруулалт | Газрын тосны хайгуулын Матад XX талбайн Цэн Тогоруу ордын баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн, зөвлөлийн 2020.12.25-ны өдрийн СТР-02-01 дүгээр дүгнэлтийг үндэслэн, УУХҮСайдын 2021.03.02-ны өдрийн “Матад-XX талбайн нөөц бүртгэх тухай” А/36 дугаар тушаалаар газрын тосны нөөцийг “баталгаат (1P)” зэрэглэлээр 1,151,194.0 тонн (8.68 сая баррель)-оор, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 137,931.0 | Матад XX талбайн газрын тосны нөөцийг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн батлуулж, газрын тосны баталгаат нөөц 338,78 сая тн, үүнээс ашиглалтын баталгаат нөөц 43,38 сая тн болсон. Баталгаат нөөц 1 сая тн-р нэмэгдсэн. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 10,2 сая тонн газрын тос олборлож, 9,8 сая тонн газрын тосыг БНХАУ-д экспортлоод байна. Цаашид газрын тосны хайгуулын талбайнуудад нөөц тогтоох боломжтой Галба-11, Тариач-15, Баянтүмэн-17, | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тонн (1.04 сая баррель)-оор, “баталгаат+магадлалтай (2P)” зэрэглэлээр 3,051,724.0 тонн (23.01 сая баррель)-оор, “баталгаат+магадлалтай+боломжтой (3P)” зэрэглэлээр 5,385,942.0 тонн (40.61 сая баррель)-оор ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсэн. | Хөх нуур-18, Давст-31, Ар булаг-29 зэрэг талбайн мэдээллийг 2022.05.18-ны өдрийн Засгийн газрын ээлжит бус цахим хуралдаанд танилцуулсан. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлаар танилцуулга, мэдээлэл бэлтгэн 2022.04.27-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн 25 дугаар тэмдэглэл гарсан. Уг тэмдэглэлд газрын тос боловсруулах үйлдвэр барихтай холбогдуулан газрын тосны хайгуул, ашиглалтын бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайг хууль тогтоомжид заасны дагуу Монгол Улсын газрын нэгдмэл санд бүртгэх, газар ашиглах гэрчилгээ олгох арга хэмжээ авч ажиллахыг Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатарт, газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд дэмжиж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасан. | |
| 64 | | 2.4. Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах. | Олборлосон тосны хэмжээ | 400 мян.тн | 900 мян.н | Хувийн хөрөнгө оруулалт | Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар энэ онд 812 мянган тонн газрын тос олборлон экспортолж, улсын төсөвт 213.2 тэрбум төгрөг төвлөрүүлэх даалгавартай. 2021 оны 12 дугаар сарын байдлаар 629.3 мянган тонн газрын тос олборлож, 590.8 мянган тонн газрын тос экспортолж, улсын төсөвт 180.4 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна. Орлого төвлөрүүлэх төлөвлөгөөний гүйцэтгэл 85 хувьтай байна. | Газрын тосны экспортын үйл ажиллагааг эхлүүлэх, хилийн боомтуудыг нээх тухай УУХҮСайдын 2022.04.08-ны өдрийн 1/935 дугаар албан бичгийг Улсын онцгой комисс болон Гадаад харилцааны сайд нарт хүргүүлсэн. 2022.06.28-ны өдрөөс эхлэн Баянхошууны боомт ажиллаж эхэлсэн бөгөөд 2022 онд нийт 6.28 сая баррель буюу 851 мян.тн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2022.12.30-ны | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | БХГ-ний дагуу газрын тосны ашиглалт, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч компаниуд газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021 онд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөгөө, төсвийг ирүүлсэн.<br>Газрын тосны ашиглалтын БХГ-97 талбайн гэрээлэгч Доншен Газрын тос (Монгол) ХХК-ийн 2021 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2021.05.12-ны өдөр, Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн гэрээлэгч Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2021 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2021.05.25-ны өдөр тус тус хэлэлцэн баталсан. Үүнд:<br>Тосон-Уул XIX талбайн 2021 оны ажлын төлөвлөгөөнд тусгасан ажлууд 2021.12.01-ний өдрийн байдлаар газрын тосны ашиглалтын 35 цооног өрөмдөхөөс (үүнээс 10 цооногт хэвтээ өрөмдлөг) 3 цооног, 1520 метрт перфораци хийхээс 281.2 метрт, 48 үед шингэн хагалбар хийхээс 4 үед, шингэн хагалбар хийсэний дараа цооногоос 33300 тонн шингэн соруулж авахаас 492 тонн шингэн соруулж, 30000 тонн тос шавхалтын аргаар олборлохоос 20189 тонн тос шавхаж, 26 цооногт олборлолтын тоног төхөөрөмж шинээр суурилуулахаас хийгээгүй, 30 цооногт ус шахалтын тоног төхөөрөмж шинээр | байдлаар нийт 2 566 019 баррель буюу 347 939 тонн газрын тос олборлож, 2 605 910 баррель буюу 353 267 тонн түүхий тос БНХАУ-д экспортлоод байна.<br>Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн нийгмийн даатгал, татварын асуудлаар болон газрын тосны нөөцийн талаарх танилцуулгыг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулан Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай 2022.05.24-ний өдрийн 03 дугаар тогтоол гарсан.<br>Мөн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Тосон-Уул-19 болон Тамсаг-21 дүгээр талбайн БХГ хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх талаар Ерөнхий сайдын 2022.05.19-ний өдрийн 78 дугаар захирамжийг Шадар сайд С.Амарсайханаар ахлуулсан Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.<br>Ажлын дэд хэсэг 4 удаа хуралдсан бөгөөд зарим гишүүд Дорнод аймгийн нутгийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, мөн Тосон-Уул-XIX, Тамсаг-XXI талбайн үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлыг судалсан. Ажлын дэд хэсэг гэрээлэгч компанийн үйл ажиллагааг | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | суурилуулахаас 1 цооногт, 6 цооног их засвар хийхээс 1 цооногт, 50 цооногийг хүчлээр угаахаас 7 цооногт, 8 цооногт полимер шахахаас хийгээгүй, 28 үед том хэмжээний шингэн хагалбар хийхээс хийгээгүй, 13 төрлийн судалгаа хийх хийгээгүй, дэд бүтэц гадаргуун байгууламжийн ажлаас Тосон-Уул XIX талбайн халуун усны станцын барилгын ажил хийсэн байна. Тамсаг XXI талбайн 2021 оны ажлын төлөвлөгөөнд тусгасан ажлууд 2021.12.01-ний өдрийн байдлаар газрын тосны ашиглалтын 35 цооног өрөмдөхөөс (үүнээс 10 цооногт хэвтээ өрөмдлөг) 2 цооног, 1600 метрт перфораци хийхээс 34.5 метрт, 56 үед шингэн хагалбар хийхээс 35 үед, 25000 тонн тос шавхалтын аргаар олборлохоос 20230.45 тонн, 6 цооног их засвар хийхээс 1 цооногт хийгдсэн. Төлөвлөгөөнд тусгагдсан 26 цооногт олборлолтын тоног төхөөрөмж шинээр суурилуулах, 30 цооногт ус шахалтын тоног төхөөрөмж шинээр суурилуулах, шингэн хагалбар хийсний дараа цооногоос 33300 тонн шингэн соруулж авах, 50 цооногийг хүчлээр угаах, 23 цооногт полимер шахах, 8 үед том хэмжээний шингэн хагалбар хийх, 11 төрлийн судалгаа хийх, дэд бүтэц гадаргуун байгууламжийн ажил, хатуу хог хаягдлыг цэвэрлэх, дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг ажил хийгдээгүй байна. | сайжруулах, бүтээгдэхүүн хуваах гэрээг шинэчлэх, газрын тосны салбарыг цаашид хөгжүүлэх талаар авах арга хэмжээ гэсэн чиглэлээр нэгдсэн санал, дүгнэлтээ боловсруулж Шадар сайд Засгийн газрын 2022.10.19-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Хуралдаанаас шуурхай авч хэрэгжүүлэх талаар Ажлын хэсэгт үүрэг чиглэл өгөөд байна. Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн газрын тосны экспортын үйл ажиллагаа Баянхошуу хилийн боомт 2022.06.28-ны өдрөөс эхэлсэн бөгөөд Нутгаа аврах Чойбалсанчуудын нэгдэл НҮТББ болон Нутгийн иргэдийн эсэргүүцлийн улмаас газрын тосны тээвэрлэлтийн үйл ажиллагааг зогсоох, зам талбайг хааж экспортын үйл ажиллагааг 10 хоног саатуулсан. Уг үйл ажиллагаатай холбоотой асуудлаар УУХҮЯ, АМГТГ-аас холбогдох хүмүүс Тосон-уул-XIX, Тамсаг-XXI талбай дээр очиж жагсаал цуглаан зохион байгуулсан хүмүүс болон орон нутгийн удирдлагууд, Иргэдийн хурлын төлөөлөгч нар, Дорнод аймгийн цагдаагийн газартай хамтарсан уулзалтыг 2 удаа хийж ТББ-ын зүгээс тавьсан шаардлагыг хэрэгжүүлэх хугацаатай үүргийг Петрочайна Дачин Тамсаг ХХК-д өгч газрын тосны экспортын тээвэрлэлтийг хэвийн үргэлжлүүлэх нөхцлийг хангаж ажилласан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 1997 оны БХГ-т талбайн 2021 оны ажлын төлөвлөгөөнд газрын тосны ашиглалтын 6 цооног өрөмдөх, 2600 метрт перфораци хийх, 33 цооногт каротаж, 6 цооногт олборлолтын туршилт, 6 цооног ус шахалтад шилжүүлэхээс 5, 25 хуучин цооног олборлолтонд шилжүүлэхээс 22, олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан 191 цооногоор нийт 373,083.4 баррель газрын тос олборлож, 21 цооногт олборлолтын тоног төхөөрөмж шинээр суурилуулахаас 22, 6 цооногт ус шахалтын тоног төхөөрөмж шинээр суурилуулахаас 5, 10 цооногт хүчиллэгийн үйл ажиллагаа, 10 цооногт азотын хий шахах үйл ажиллагаанаас 4, 6 төрлийн судалгаа хийхээс 2, дэд бүтэц гадаргуун байгууламжийн 27 ажил, хатуу хог хаягдлыг цэвэрлэх, дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. | 2022.09.21-ний өдөр УУХҮЯ, Ашигт малтмал газрын тосны газар, Петрочайна дачин тамсаг ХХК, Халхгол сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, төлөөлөгч, Матад сумын Засаг дарга, ИТХ-ын дарга, төлөөлөгч нартай хамтарсан хурал зохион байгуулж 2021, 2022 оны Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх гэрээг байгуулсан. | |
| **Үндсэн чиг үүрэг: 3: Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах.** | | | | | | | | | |
| 65 | Зорилт 3: Дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг дамжуулах хоолойн хамт барьж байгуулах. | 3.1.Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах, дамжуулах хоолой барих санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх. | Шинээр баригдсан дамжуулах хоолой | 0 | 1 | Засгийн газрын баталгаатай зээл, хувийн хөрөнгө оруулалт<br><br>176,700.0 Хувийн хэвшил 2021 он | Засгийн газрын 2020.02.19-ний өдрийн хуралдаанаар Дорноговь аймгийн Алтаншираэ сумын нутагт баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэрт шаардлагатай дотоодын түүхий тосыг тээвэрлэх дамжуулах хоолойн дэд бүтцийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаарх танилцуулга хийсэн ба Засгийн газрын хуралдааны 11 дүгээр тэмдэглэлээр төслийн сонгон | Дамжуулах хоолойн инженерчлэл, зураг төслийн ажил нь инженер, геологийн судалгааны, тосны шинж чанарын судалгааны, техникийн зураг төслийн, инженерчлэлийн ажлуудаас бүрдэж байна. 2022.12.10-ны өдрийн байдлаар инженер, геологи судалгааны ажил 100%, тосны шинж чанарын судалгааны ажил 100%, техникийн зураг төсөл (FEED)-ийн ажил 25%-ийн тус тус гүйцэтгэлтэй ба нийлбэр | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шалгаруулалт зарлахыг холбогдох сайд нарт даалгасан. Үүнтэй холбогдуулан ТНБДаргын 2021.01.25-ны өдрийн А/08-р тушаалаар "Түүхий тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлж, барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах" Үнэлгээний хороо байгуулагдсан. Үнэлгээний хороо тос дамжуулах хоолойн төслийг санхүүжүүлэх, инженерчлэл, худалдан авалт, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх сонирхолтой компанийг сонгон шалгаруулалтанд оролцох хүсэлт ирүүлэх урилга, сонгон шалгаруулалтыг олон улсад нэр хүнд бүхий Pipeline and Gas Journal сайтад 2021.03.01-ний өдөр нийтлүүлсэн. Газрын тос дамжуулах хоолой байгуулах төслийг Санхүүжүүлэх, Инженерчлэл, зураг төсөл, худалдан авалт, барилга угсралт (EPC+F)-ын ажлыг гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулах Олон улсын тендерийг 2021.03.01-ний өдрөөс 2 үе шаттайгаар зарласан. Урьдчилсан сонгон шалгаруулалтад 9 орны 22 компани оролцсон бөгөөд тэдгээрээс шалгуур хангасан 15 компанид 2021.04.23-нд тендерийн баримт бичгийг хүргүүлсэн. Тендер ирүүлэх хугацааг 2021.05.23-ны өдөр байсныг тендерт оролцогч компаниудаас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийт 4 удаа сунгаж, тендерийг 2021.10.20-ны өдөр хүлээн авсан. Тендерт БНЭУ-ын Kalpataru | дүнгээр 39%-тай явагдаж байна.<br>Барилга угсралтын үеийн түр кемпүүдийн барилга угсралтын ажил 6 байршилд үргэлжилж барилгын ажил -40%, үйлчилгээний замын ажил -20%, Геодезийн цэг тэмдэгт суулгах ажил -100%, байр зүйн зураглалын судалгааны ажил -100%, геодезийн судалгааны ажлын урьдчилсан тайланг бэлтгэж захиалагчид ирүүлсэн, Геотехникийн судалгааны ажил -90%, дээжлэлт шинжилгээ -90%, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил -70%, БНХАУ-ын Шанхай хот дахь Intertek компанийн лабораторт өгсөн тосны урсацын шинж чанрын шинжилгээний хариуг 2022 оны 12-р сарын 09-ны өдөр хүлээж авсан. Суурь Инженерчлэлийн Загвар (FEED) боловсруулах ажил -25%, БОАЖЯ-аас байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт хийгдсэн. БОННҮ тайлан-90% хийгдэж байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | power transmission limited, Япон улсын Sumitomo corporation, БНХАУ-ын Chinese petroleum pipeline engineering Co.LtD болон Norinco international cooperation LtD компаниудаас тендерийн баримт бичгийг ирүүлж техникийн болон санхүүгийн саналыг үнэлж дуусган оролцогчдод захиалагчаас мэдэгдлийг хүргүүлсэн. | | |
| 66 | | 3.2.Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт дотоодын түүхий эдэд тулгуурласан газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах. | Шинээр байгуулагдсан үйлдвэрийн тоо | 0 | 1 | Гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламж<br><br>652,796.9 /БНЭУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээл/ 2021 он | Технологийн бус барилга байгууламжийн ажлын ерөнхий гүйцэтгэгч Жэй Эм Си Прожектс лимитед компани нь 2020.01.15-ны өдөр үйлдвэрийн талбайн ажлыг эхлүүлсэн. EPC-1 багц ажлын зураг төслийн ажил 90%, бусад барилгууд болох захиргааны барилга-24,7%, эмнэлгийн барилга-67,0%, хоолны газрын барилга-68,2%, лабораторийн барилга 68,1%, нэвтрэх хаалга 1-ийн барилга 45,3%, нэвтрэх хаалга 2-ын барилга 36,6%, засварын газрын барилга-23,5%, агуулахын барилга 31,7%, гал командын барилга-25,6%-ийн тус тус гүйцэтгэлтэй буюу EPC-1 багц ажлын гүйцэтгэл 2021.12.07-ны өдрийн байдлаар 36,0%-ийн гүйцэтгэлтэй. Мөн Бор хөөврийн говиос ус дамжуулах шугам хоолойн ажлууд болох өргөх станцын барилга-31,4%, 11 ширхэг худгийн барилга-31,3%, ус нөөцлөх савны барилга-65,1%, ЦДАШ-22,1%, ус дамжуулах хоолой-17,2%, үйлдвэрийн хашаан доторх авто зам-22,6%, зам талбайн | Технологийн бус барилга байгууламжийн ажил /EPC-1/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл 2022.11.22-ны өдрийн байдлаар 75.0%-тай байна. Эдгээрт Түүхий ус хадгалах сав-98,69%, Оффис, сургалтын төв-80,68%, Хоолны газар-89,82%, Лаборатори-89,17%, Эмнэлгийн барилга-83,84%, Агуулах-58,47%, Нэвтрэх хаалга-1-82,80%, Нэвтрэх хаалга-2-56,32%, Гал унтраах ангийн барилга-68,29%, Засварын цех-51,0%, Үерийн ус цуглуулах талбай-82,5%, Ус зайлуулах хоолой-53,0%, Ус дамжуулах хоолой-95%, 17км авто зам-60,63%, Ус дамжуулах хоолой-/Бор хөөвөр/-72,65%, Худгийн барилга-79,74%, Цахилгаан дамжуулах агаарын шугам-96,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй. Лицензгүй технологийн байгууламжийн ажил /EPC-2/-ын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.06.06-ны өдөр зарласан ба 2022.09.19-ны өдөр тендер хүлээж авсан. Үйлдвэрийн цахилгаан станцын ажил /EPC-3/-ын | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ус зайлуулах хоолой-12,4%, зам талбайн ус хураах талбай-81,6%, замын доорх ус дамжуулах хоолой-82,4, технологийн шугам хоолойн сувагчлал-61,0%-ийн тус тус гүйцэтгэлтэй байна. | ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах түргэвчилсэн тендерийг 2022.05.04-ний өдөр зарласан ба 2022.07.04-ний өдөр тендер хүлээн авсан. EPC-2, EPC-3 багц ажлын тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн БНЭУ-ын “Megha Engineering & Infrastructure Limited” (Мега инженеринг инфрастракчер лимитед) компанитай Инженерчлэл, худалдан авалт, барилгын угсралтын гэрээ байгуулах асуудлыг Засгийн газрын 2022.10.26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК, “Megha Engineering & Infrastructure Limited” компани хооронд 2022.10.28-ны өдөр гэрээ байгуулсан. Лицензтэй технологийн байгууламжуудыг барих ажил /EPC-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, Устөрөгчийн байгууламжийн лиценз эзэмшигч Итали улсын Кинетикс текноложи компанитай, Хүхэр ялгах байгууламжийн лиценз эзэмшигч Франц улсын Аксенс компани, Бензин боловсруулах, Гидрокрекинг, Дизелийн гидроцэвэрлэгээ, Шингэрүүлсэн шатдаг хий ялгах байгууламжуудын лиценз эзэмшигч АНУ-ын ЮүӨүПи Хонивэлл компанитай тус тус гэрээг байгуулсан. | |
| **Үндсэн чиг үүрэг: 4: Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах.** | | | | | | | | | |
| 67 | Зорилт-4: Газрын тосны бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг | 4.1. Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг тогтвортой нэмэгдүүлэх. | Бүтээгдэхүүний хэмжээ | 2.0 сая тонн | 2.4 сая тонн | Хувийн хөрөнгө оруулалт 2,834,500.0 2022 он | Монгол Улсын хэмжээнд оны эхнээс 2021.12.31-ний өдрийн байдлаар нийт 1.8 сая тонн газрын тосны | Газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтвортой хангах, чанарын хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжилтийг хангах. | | | | | | бүтээгдэхүүн импортлон хэрэглэсэн бөгөөд үүний 92.2 хувийг ОХУ, 4.2 хувийг БНХАУ улс, 3.6 хувийг бусад улсаас нийлүүлсэн байна. Засгийн газрын 2020 оны 136 дугаар тогтоолоор 2021 онд газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий нэр бүхий 24 аж ахуйн нэгж 120,350 тонн компанийн нөөц бүрдүүлэхээр баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд АМГТГ тус аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавин ажилласан. 2021.12.28-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд А-80 автобензин 63, Аи-92 автобензин 36, дизель түлш 22, ТС-1 20 хоногийн нөөцтэй байна. Өргөн хэрэглээний АИ-92 автобензинийн үнийг тогтворжуулах, хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх, харилцааг зохицуулах “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам”-ыг боловсруулж, Засгийн газрын 2021.03.17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 68 дугаар тогтоол батлагдсан. Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг сэлгэн хадгалах гэрээний үлгэрчилсэн загвар, мэдээ тайлангийн маягтын загварыг УУХҮСайдын 2021.04.28-ны өдрийн А/91 дүгээр | бүхий нийт 203 аж ахуйн нэгж улсын хэмжээнд шатахууны 89 агуулах, 1483 шатахуун түгээх станцаар дамжуулан газрын тосны бүтээгдэхүүний хангамж, борлуулалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Монгол Улсын хэмжээнд 2022 онд нийт 1.9 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон хэрэглэсэн. Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоолоор 2022 онд газрын тосны бүтээгдэхүүн импортлох, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий нэр бүхий 28 аж ахуйн нэгж 193,500 тонн компанийн нөөц бүрдүүлэхээр баталсан. Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд АМГТГ нь тус аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, нөөцийн бүрдүүлэлтэд тухай бүр хяналт тавьж ажиллаж байна. Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, шатахуун худалдан авах урт хугацааны гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хүрээнд ОХУ-ын Роснефть компанитай хийсэн 2 удаагийн уулзалт, хэлэлцээрийн үр дүнд 2022 оны 8 дугаар сараас дизель түлшний үнийг 5 хувь хямдруулж, 2023 оны 1 дүгээр сараас Аи 92 автобензинийг тонн тутамд 815 ам.доллароор, дизель түлшийг дэлхийн зах зээлийн үнээс 10 хувь хямдруулж авахаар тус тус тохиролцсон. Импортын бусад эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 2022.01.26-ны өдрийн 53 дугаар | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тушаалаар баталсан. Тус тушаал, журмын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж ажиллах тухай УУХҮСайдын 2021.04.30-ны өдрийн 01/1150 дугаар албан бичгийг АМГТГ-т хүргүүлсэн. 2020 онд өргөн хэрэглээний АИ-92 автобензинийн жижиглэнгийн үнийг тогтворжуулахтай холбогдуулан Төрийн өмчит “Эрчис ойл” ХХК болон шатахууны импорт, борлуулалтын үйл ажиллагаа эрхлэгч 17 аж ахуйн нэгжүүдийн хооронд санхүүгийн үүсмэл хэрэгслийг ашиглан дотоодод борлуулах шатахууны үнийг тогтворжуулах гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан. Үүний хүрээнд АИ-92 автобензиний жижиглэн борлуулалтын үнийг 2021.07.01-ний өдөр хүртэл хугацаанд 1450 төгрөгөөр тогтворжуулсан. Тодорхой хүчин зүйлүүдийн нөлөөллөөр дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ тасралтгүй өссөн бөгөөд үүнийг дагаад ОХУ-аас манай улсад нийлүүлж буй газрын тосны бүтээгдэхүүний импортын үнэ сар бүр нэмэгдэж ирсэн. Иймд Засгийн газрын 2020 оны 232 дугаар тогтоолоор байгуулагдсан “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл”-ийн 2021.11.22-ны өдрийн | тогтоолоор “Газрын тосны бүтээгдэхүүний импортын олон талт эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хилийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомт орших улсын хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүн шилжүүлэн ачих байгууламж, агуулах барих зориулалтаар газар ашиглах” шийдвэр гарсан. Үүний дагуу УУХҮСайдын 2022.04.05-ны өдрийн А/60 дугаар тушаалаар Өмнөговь аймгийн Гашуунсухайт, Шивээхүрэн боомт орчмын хилийн зурваст газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулахын байгууламжийг өөрийн хөрөнгөөр барьж байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Гашуунсухайт болон Шивээхүрэнгийн боомтын шилжүүлэн ачих агуулахын байгууламжийн төслийг “Шунхлай групп” ХХК өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шалгарч, УУХҮЯ-тай хамтран ажиллах тухай 2022 оны №21, №22 тоот гэрээг байгуулан үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Энэхүү төсөл хэрэгжиж, газрын тосны бүтээгдэхүүний шилжүүлэн ачих агуулах, байгууламж ашиглалтад орсноор уул уурхайн үйл ажиллагаа эрчимтэй өрнөж буй өмнөд бүсийн шатахууны хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, жил бүр өсөн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | анхдугаар хуралдаанаар шатахууны үнийн асуудлыг хэлэлцсэн бөгөөд АИ-92 автобензиний жижиглэнгийн үнийг 6 сарын хөдөлгөөнт дундаж үнээр тооцон сар бүр өөрчлөлтийг оруулах, аажмаар үнийг зах зээлийн горимд шилжүүлэх тухай зөвлөмжийг гаргасан. | нэмэгдэж буй тус бүс нутгийн хэрэглээг тогтвортой хангах нөхцөл бүрдэх юм.<br>ОХУ-ын Ангарскийн газрын тос боловсруулах үйлдвэрийн ээлжит засвар, үйлчилгээтэй холбоотойгоор 2022 оны 10 дугаар сард нийлүүлэлт удааширч Аи-92 автобензинийн нөөц багассан нөхцөл байдлын үед Роснефть Монголия компани импортлогч аж ахуйн нэгжүүд болон УБТЗ-тай онцгой горимоор шуурхай хамтран ажилласны үр дүнд 10 дугаар сарын сүүлээр Аи-92 автобензинийн хангамж, нийлүүлэлт нэмэгдэж, нөөц хэвийн түвшинд хүрсэн. Мөн тодорхой гадаад хүчин зүйлийн улмаас 11 дүгээр сард дизель түлшний нийлүүлэлт удааширч, нөөц багассан нөхцөл байдлын үед Роснефть Монголия компани импортлогч аж ахуйн нэгжүүд УБТЗ-тай хамтран, дизель түлшний ачилт, тээвэрлэлт, татан авалт, буулгалтын ажлыг шуурхай зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авч, нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр ажилласан.<br>2022.12.30-ны өдрийн байдлаар улсын хэмжээнд А-80 автобензин 39, Аи-92 автобензин 32, Аи-95 автобензин 28, дизель түлш 17, ТС-1 онгоцны түлш 39 хоногийн нөөцтэй байна. | |
| 68 | | 4.2.“.Евро-5” стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах. | Евро-5 стандартын шатахууны эзлэх хувь | 13 хувь | 50 хувь | Хувийн хөрөнгө оруулалт | Манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг 100% импортоор хангаж байгаа бөгөөд 2021.12.10-ны өдрийн байдлаар нийт 1.6 сая тонн газрын тосны | Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэхийг дэмжсэн эрх зүйн орчинг бүрдүүлэх хүрээнд Агаарын тухай хуульд нэмэлт өөрчлөлт | 70 |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүтээгдэхүүн, үүнээс 1.4 сая.тонн шатахуун импортолсон байна. Үүнд: дизелийн түлш 902.9 мян.тонн, автобензин 516.3 мян.тонн байгаагаас К5 /Евро-5/ стандартын шаардлагад нийцсэн автобензин 37233 тонн, дизелийн түлш 120019 тонн, нийт 157252 тонн байгаа нь нийт импортолсон шатахууны 11 хувийг эзэлж байна. ОХУ-ын Роснефть компаниас манай улсад нийлүүлж буй Евро-5 стандартын шатахууны жижиглэн борлуулалтын үнэ литр тутамдаа 150-180 төгрөгөөр өндөр байна. Энэхүү үнийн зөрүүтэй холбоотойгоор Евро-5 стандартын шатахууны импорт, хэрэглээ дорвитой нэмэгдэхгүй байгаа болно. Иймд энэхүү үнийн зөрүүг арилгах зорилгоор автобензин, дизелийн түлшний Онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө багатай экологийн өндөр ангиллын Евро-5 стандартын шатахуунд ногдох онцгой албан татварыг экологийн бага ангиллын стандартын шатахуунаас тодорхой хувиар бага тогтоох эрх зүй, татварын орчин бүрдүүлэх шаардлага тулгарч байна. Энэ хүрээнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, хуулийн төслийг боловсруулан 2021.02.04-ний өдрийн 01/291 дугаар албан | оруулах саналыг 2020, 2021 онд Байгаль орчин, аялал жуулчлын яам, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороонд тус тус хүргүүлсэн. 2022.04.22-ны өдөр батлагдсан Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6 дах хэсэгт “Монгол Улсын стандартаар тогтоосон экологийн хамгийн өндөр ангиллаас доош ангиллын, эсхүл уг ангиллын стандартын шаардлага хангаагүй автобензин, дизель түлшийг жижиглэнгээр худалдан борлуулах” гэж хориглох тухай нэмэлт орсон. Ийнхүү Агаарын чанарыг сайжруулах бүсэд экологийн Евро-5 ангиллын стандартын шаардлага хангаагүй шатахуун жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдсэн.<br>Монгол, Оросын иж бүрэн стратегийн түншлэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрт “Худалдаа эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 2022 оны 24-р хуралдааны Протоколд болон ОХУ-ын “Роснефть” НХН болон Монголын шатахуун импортлогч компаниудын хооронд байгуулсан 2023 он хүртэл шатахуун нийлүүлэх урт хугацааны гэрээний дагуу шатахууныг тогтвортой нийлүүлэх, тэр дундаа К5 /Евро-5/ ангиллын шатахууны нийлүүлэлтийг боломжит | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд 2021 онд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороотой хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар автобензин, дизель түлшний Онцгой албан татварыг экологийн ангилал буюу чанар, стандарттай уялдуулан ялгавартай тогтоох, чанар стандартын шаардлага хангахгүй шатахуун гарган авах зориулалтаар импортолж буй зарим төрлийн газрын тосны бүтээгдэхүүнд Онцгой албан татвар ногдуулах эрх зүйн орчин бүрдүүлэх, Агаарын тухай хуульд нэмэлт оруулах замаар агаарын чанар сайжруулах бүсэд Евро-5 стандартын шаардлагад нийцээгүй шатахууныг жижиглэнгээр худалдан, борлуулахыг хориглох эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг тусгуулахаар 2021.01.12-ны өдрийн 02/67 дугаар бичгээр Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо /ОББҮХ/-нд хүргүүлсэн. Дээрх асуудал ОББҮХ-ны 2021 оны төлөвлөгөөнд тусгагдан батлагдсан ба тус чиглэлээр ОББҮХ-ны ажлын албатай хамтран ажиллаж байна. | хэмжээгээр нэмэгдүүлэх саналыг тусгасан. Улаанбаатар хотын агаарын бохирдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл /3-р үе шат/-ийн хүрээнд УУХҮЯ, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, АМГТГ, Япон улсын Жайка хамтын ажиллагааны байгууллагын хамтарсан Ажлын хэсэг ажиллаж байна. Уг төслийн хүрээнд Евро-5 /K5/ шатахууны хэрэглээг нэмэгдүүлэхэд импорт болон татварын бодлогын зохицуулалт нийт хэрэглэгчийн Евро-5 /K5/ хэрэглээний соёл нэвтрүүлэх, сурталчилан таниулах зэрэг ажлуудыг үе шаттай хамтран хэрэгжүүлэхээр Япон улсын Жайка хамтын ажиллагааны байгууллагын түлшний судалгааны мэргэжилтэнтэй 2022.12.07-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартын шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд автобензин дизель түлшинд ногдуулах онцгой албан татварын хэмжээг экологийн ангилалтай уялдуулан тогтоох талаар дэлгэрэнгүй тооцоо судалгаа, танилцуулгыг УУХҮСайдын 2022.02.24-ний өдрийн 01/469 дүгээр албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн бөгөөд шатахууны гадаад үнэ нэмэгдсэнтэй холбогдуулан дизелийн түлшний Гаалийн албан татварыг “0” хувиар, НӨАТ-ыг “0” хувиар тогтоох асуудлыг ЗГ-ын | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.<br>Газрын тосны зарим бүтээгдэхүүний гаалийн болон онцгой албан татварын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2022.07.28-ны өдрийн 287 дугаар тогтоолын дагуу 2023 оны 1 дүгээр сарыг дуустал импортлосон дизель түлш дээр энгийн болон Евро5 ялгаваргүй онцгой албан татварыг “0” төгрөг болгон тус тус бууруулж шинэчлэн тогтоосон.<br>Манай улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэглээг 100 хувь импортоор хангаж байгаа бөгөөд 2022 онд нийт 1.9 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлон хэрэглэсэнээс, 1.7 сая тонн шатахуун байна. Үүнээс Евро-5 /К5/ стандартын шаардлагад нийцсэн 384 мян.тонн шатахуун байгаа нь нийт импортолсон шатахууны 23 хувийг эзэлж байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 69 | | 4.3.".Шатдаг хийн хадгалалт, түгээлтийн үеийн техник ашиглалт, аюулгүй ажиллагаатай холбогдсон стандарт, дүрмийг боловсронгуй болгох. | Баримт бичиг боловсруулалтын хувь | 0 хувь | 100 хувь | Улсын төсөв | Шингэрүүлсэн байгалийн хийн бага хүчин чадлын үйлдвэрлэл болон хийн ашиглалт. Галын аюулгүй байдлын шаардлага /БНД/, Шингэрүүлсэн байгалийн хийн агуулах. Галын аюулгүй байдлын шаардлага /БНД нормын төсөлд санал боловсруулан Барилгын хөгжлийн төвд 2021.03.22-ны өдрийн 1/1188 дугаар албан бичиг хүргүүлэв.<br>Ашигт малтмал, газрын даргын 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн А/109 тоот тушаалаар "Шингэрүүлсэн нүүрс-устөрөгчийн хий-Автотээврийн түлшний стандарт"-ыг шинэчлэн боловсруулж төслийг 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 1/5186 тоот албан бичгээр Стандарт, хэмжилзүйн газарт хүргүүлэв | АМГТГ-ын Даргын 2022.03.31-ний өдрийн А45 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулагдаж "Хийн хангамж" БНбД /42-01-21/-ийн төсөлд холбогдох дүгнэлт, шүүмжийг Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-т 2022.05.23-ны өдрийн 22/19 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>АМГТГ-ын Даргын 2022.08.19-ний өдрийн А/92, 2023.01.09-ний өдрийн А/.. дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулж шингэрүүлсэн шатдаг хийн "Зөөврийн бутан хий хадгалах зориулалттай сав үйлдвэрлэх байгууламж, үзлэг, туршилт", "Дотоод эзлэхүүн 1 литрээс бага багтаамжтай даралтат саванд бутан хий цэнэглэх тоног төхөөрөмжид тавигдах шаардлага болон аюулгүй ажиллагаа"-ны стандартын төсөл шинээр боловсруулав. | 70 |
| **4. Ерөнхий чиг үүргийн нэр: Хүнд үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх стратегийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлогын нэгдсэн удирдлага, удирдамжаар хангах.** | | | | | | | | | |
| **Үндсэн чиг үүрэг-1: Хүнд үйлдвэрийн салбарын бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтийг зохицуулах, бодлогын удирдлагаар хангах.** | | | | | | | | | |
| 70 | Зорилт-1:<br>Хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох, бодлого, хөтөлбөр, төслийн хувилбар боловсруулах. | 1.1. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлж, батлуулах. | Батлуулсан хуулийн тоо | 0 | 1 | Улсын төсөв | Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэхийг УИХ-ын чуулганаар шийдвэрлэсэн бөгөөд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн. Тус яамнаас боловсруулан 2019.03.20-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулж, дагалдах 5 хуульд (Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн С.Бямбацогтын санаачилсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй нэгтгэх Ажлын хэсэгт орж ажилласан. ҮТПЭЗБТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тайланг хийж гүйцэтгэсэн. Ажлын хэсэг Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хуулийн үзэл баримтлалыг баталсан бөгөөд одоо олон нийтийн хэлэлцүүлгийн шатандаа байна. Мөн хуулийн төсөлд Засгийн газраас санал авахаар хүргүүлсэн. | оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай) нэмэлт өөрчлөлт оруулсан. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг, дагалдах хуулийн төслүүдийн хамт УИХ-ын 2022.07.05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан бөгөөд 2022.08.01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна. | |
| 71 | | 1.2. Хүнд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл боловсруулж, батлуулах. | Батлуулсан хуулийн тоо | 0 | 1 | Улсын төсөв | Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т заасны дагуу Хүнд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааг хийж гүйцэтгэсэн. Хуулийн төслийн тандан судалгааны хүрээнд Аж үйлдвэрийг амжилттай хөгжүүлж байгаа гадаадын 10 гаруй орны сайн туршлагуудаас судалж хуулийн төсөлд тусгасан.<br>-Хуулийн төслийн үзэл баримтлалыг УУХҮСайд, ХЗДХСайд хамтран 2021.03.09-ний өдөр баталсан.<br>-Хуулийн төслийн талаар салбарын мэргэжлийн холбоод, их дээд сургууль, аж ахуйн нэгжүүд болон төрийн захиргааны төв | УИХ-ын даргын 2022.03.30-ны өдрийн 46 дугаар захирамжаар УИХ-ын 2022 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард хэлэлцэх асуудлын дараалалд оруулсан бөгөөд УИХ-ын чуулганаар хэлэлцэхээр хүлээгдэж байна. УУХҮСайдаас Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-аар хэлэлцэж батлсны дараа УИХ-аар хэлэлцүүлэх чиглэлийг 2022.11.22-ны өдөр өгөөд байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагуудаас www.mmhi.gov.mn, www.mrpam.gov.mn цахим хуудсаар 2021.02.18-ны өдрөөс 2021.03.17-ны өдрүүдэд санал авсан.<br>- Хүнд үйлдвэрийн тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газраар хэлэлцүүлэн дэмжигдэж, 2021.11.24-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлээд байна. | | |
| 72 | | 1.3. Хүнд үйлдвэрийг хөгжүүлэхэд шаардлагатай ус хангамж, эрчим хүч, тээвэр ложистик зэрэг дэд бүтцийн төлөвлөлт, судалгаа боловсруулах. | Боловсруулсан судалгаа, баримт бичгийн тоо | 1 | 4 | Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | “Говийн бүсийн үйлдвэр, уурхайн ус хангамжийг нэмэгдүүлэх” хүрээнд Өмнөговь, Дорноговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Манлай, Сайншанд, мандах, Алтанширээ сумдад шинээр байгууллагдаж уурхай, үйлдвэрийн усны хэрэглээний мэдээллийг нэгтгэн гаргаж АМГТГ-ын Геологи, уул уурхайн кадастрын хэлтсийн мэргэжилтэн Д.Мягмарсүрэнтэй хамтран 2021.02.10-ны өдөр АМГТГ-т ажиллаж, дээрх сумдад байгуулагдах үйлдвэр, уурхай болон газрын доорх усны ордуудын байршлын зураглалыг гаргасан. | Эрдэнэт үйлдвэрийг түшиглэн байгуулах Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар Орхон аймгийн Баян-өндөр, Жаргалант сумын нутагт нийт 1217,4 га газрыг улсын тусгай хэрэгцээнд авах талаарх холбогдох судалгаа, мэдээллийг бэлтгэн Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсний дагуу тус яамнаас ЗГ-ын 2022.04.27-ны өдрийн хуралдаанаар “Газрын улсын тусгай хэрэгцээнд авах тухай” асуудлыг хэлэлцүүлж ЗГ-ын 2022 оны 171 дугаар тогтоолоор газрыг тусгай хэрэгцээнд авсан.<br>Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн “уул уурхай, аж үйлдвэрийн салбарын үйл ажилагаанд газрын доорх цэнгэг усны орд ашиглахыг хориглох” заалттай холбоотой Уул уурхай, аж үйлдвэрийн салбарт ашиглаж байгаа газрын доорх цэнгэг усны ордууд болон түүний ашиглалтын талаар судалгаа хийж, статистик, тоон мэдээллийг нэгтгэн | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | боловсруулж, танилцуулга бэлтгэн 2022.05.09-ний өдөр Засгийн газрын ордоны Сүхбаатар танхимд зохион байгуулагдсан хэлэлцүүлэгт танилцуулсан.<br><br>Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд хэрэгжиж байгаа “Хувийн хэвшлийн оролцоогоор дамжуулан олон улсын худалдаа, логистикийг бэхжүүлэх, замын үүд дэх хуурай боомтын урьдчилсан ТЭЗҮ” боловсруулахтай холбогдуулан хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжиж буй төслүүдэд шаардлагатай эрчим хүч, ус хангамжийн мэдээллийг боловсруулж, Хүнд үйлдвэрийн салбарын танилцуулгад нэгтгэн 2022.12.02-ны өдөр СХОГ-ын ахлах шинжээч Д.Дамбад цахимаар хүргүүлсэн. | |
| 73 | | 1.4. Хүнд үйлдвэрийн салбарт ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, холбогдох бусад журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангах. | Боловсруулсан журмын тоо | 1 | 4 | Улсын төсөв,зээл тусламж | “Үйлдвэрлэл /аж үйлдвэрийн салбар/-ийн технологийн түвшний үнэлгээ хийх, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлалыг УУХҮЯ-ны ТНБДаргын 2021.05.31-ний өдрийн “Санал авах тухай” 03/1381 дугаартай албан бичгээр ХХААЯ болон БШУЯ-нд хүргүүлсэн бөгөөд журмын төслийг 2021.06.02-ны өдөр УУХҮЯ-ны https://www.mmhi.gov.mn/ цахим хуудсанд 30 хоног байршуулсан.<br>БШУЯ-ны ТНБДаргын 2021.06.21-ний өдрийн 2/3064, ХХААХҮЯ-ны ТНБДаргын 2021.06.17-ны өдрийн 01/1964 дугаартай албан бичгээр тус тус | -Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэлгээний хэмжээ тогтоох аргачлалыг УУХҮСайд болон ХХААХҮСайдын хамтарсан тушаалаар 2022.06.22-нд батлуулж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5874 дугаарт бүртгүүлсэн.<br>-Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийг УУХҮСайдын 2022.09.22-нд батлуулж захиргааны хэм | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ирүүлсэн саналуудыг журмын төсөлд тусган Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу журмын төслүүдийн салбарын хэлэлцүүлгийг 2021.09.15-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт оролцсон аж ахуйн нэгж, их дээд сургууль ,эрдэм шинжилгээний хүрээлэн, төрийн болон төрийн бус байгууллага, холбооны эрдэмтэн судлаач 20 гаруй төлөөлөлийн санал зөвлөмжийг журмын төсөлд тусган "Хөнгөн болон хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх журам"-ын төслийн журмын нөлөөллийн шинжилгээг ХЗДХСайдын 2018 оны А/147 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Захиргааны хэм хэмжээний актын төсөл бэлтгэх явцад нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал"-ын дагуу гүйцэтгэж, танилцуулгыг бэлтгэн баталгаажуулахаар 2021.11.24-ний өдөр ХХААХҮ-ийн яаманд хүргүүлсэн.<br>- Технологи дамжуулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 7 дугаар зүйлийн 7.7-д тус тус заасны дагуу "Үйлдвэрлэл /аж үйлдвэрийн салбар/-ийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журам болон технологийн түвшний үнэлгээ хийх, үнэлгээний хэмжээг тогтоох аргачлалын төслүүдийг боловсруулж батлуулах үүрэг бүхий ажлын хэсэг УУХҮСайдын 2020.11.04-ний өдрийн А/273 дугаар | хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5959 дугаарт бүртгүүлсэн. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тушаалаар байгуулагдаж, журмын төслийг урьдчилсан байдлаар гарган ХХААЯ, БШУЯ-даас санал авч, төслийг УУХҮЯ-ны цахим хуудсанд http://mmhi.gov.mn/public/more/id/1412 60 хоног байршуулсан. Мөн Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу журмын төслүүдийн салбарын хэлэлцүүлгийг 2021.09.15-ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт оролцсон аж ахуйн нэгж, их дээд сургууль ,эрдэм шинжилгээний хүрээлэн, төрийн болон төрийн бус байгууллага холбооны эрдэмтэн судлаач 20 гаруй төлөөллийн санал зөвлөмжийг журмын төсөлд тусган “Хөнгөн болон хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журам”-ыг БШУСайд, УУХҮСайд, ХХААХҮСайдын “Журам батлах тухай” 2021.11.08-ны өдрийн А/381 / А/274 / А-313 дугаар хамтарсан тушаалаар батлуулан, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 5553 дугаарт бүртгүүлж, захиргааны хэм хэмжээний актыг УУХҮЯ-ны цахим хуудсанд байршуулсан. | | |
| **Үндсэн чиг үүрэг-2: Тэргүүний технологи, инновацийг нэвтрүүлэх, нутагшуулах, дамжуулах, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах замаар хүнд үйлдвэрийг хөгжүүлэх.** | | | | | | | | | |
| 74 | Зорилт-2: Хүнд үйлдвэрлэлийг цогцолбороор хөгжүүлж, нэмүү өртөг шингэсэн | 2.1. Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах. | Үйлдвэр байгуулах ажлын явц | 0 хувь | 100 хувь | 52,000.0 Хувийн хэвшил /Гадаад, дотоодын | “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн хэрэгжүүлж байгаа төслийн технологи өөрчлөгдөх нөхцөл байдал үүсч өмнө сонгосон технологиос хөрөнгө | Засгийн газрын 2022.04.13-ны өдрийн 148 дугаар тогтоолоор Эдийн засаг хөгжлийн яам /хуучнаар/ болон “Кью Эс Си” ХХК-ийн хооронд 2014 онд байгуулсан | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | бүтээгдэхүүний сүлжээг бий болгоно. | | | | | хөрөнгө оруулалт, зээл/ 2021 он<br><br>Хувийн хөрөнгө оруулалт 31,926.7 сая төг. 2022 он | оруулалт болон цахилгаан эрчим хүчний зарцуулалт 2-3 дахин багатай технологи болох Мини домен зуух бүхий гангийн үйлдвэр байгуулах “Монгол ган цогцолбор-1” төслийн ТЭЗҮ-ийг шинээр боловсруулах ажлыг БНХАУ-ын металлургийн инженерингийн компани болох “MCC-CERI” компаниар /712.5 сая төгрөг/ гүйцэтгүүлж, 2021.09.30-ны өдрийн УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж, дүгнэлт гаргасан. | “Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээг цуцалсан.<br>Уг тогтоолын дагуу ТӨБЗГ-аас Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг төрийн өмчит компанийн статустай болгож, бүтцийг баталж, удирдлагыг томилсон.<br>“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК нь Засгийн газрын "Шинэ сэргэлтийн бодлого"-ын Аж үйлдвэрийн сэргэлтийн бодлогын хүрээнд "Шинэ сэргэлт- Монгол ган” хэлэлцүүлгийг 2022.07.04-ний өдөр зохион байгуулсан.<br>Тус компани нь “Монгол ган цогцолбор I” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, 2022-2023 онд хийгдэх ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд дараах ажлууд хийгдсэн.<br>Төслийн цахилгаан хангамжийн ТЭЗҮ, зураг төслийн ажлыг улсын төсвийн хөрөнгөөр хийлгэх, 2023 оны төсөвт суулгаж өгөх хүсэлтийг УУХҮСайдын 2022.08.17-ны өдрийн 01/2232 дугаар албан бичгээр Эрчим хүчний сайд Н.Тавинбэхэд, мөн өдрийн 01/2233 дугаар албан бичгээр Барилга, хот байгуулагын сайд Б.Мөнхбаатарт, УУХҮСайдын 2022.08.25-ны өдрийн А/2288 дугаар албан бичгээр Сангийн сайд Б.Жавхланд тус тус хүргүүлсэн.<br>Мөн “Монгол ган цогцолбор I” төслийг хэрэгжүүлэхэд шаарпагатай 85.11 га газрыг үндэсний хэмжээний | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх зориулалтаар Улсын тусгай хэрэгцээнд авах асуудлыг шийдвэрлэж өгөх хүсэлтийг УУХҮСайдын 2022.09.15-ны өдрийн 01/2468 дугаар албан бичгээр БХБСайдад хүргүүлсэн.<br>“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК нь "Монгол ган цогцолбор I" төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулах гүйцэтгэгчийг 2022 оны 9 дүгээр сард сонгон шалгаруулсан.<br>"Эрдэнэс судалгаа хөгжлийн төв" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу ТЭЗҮ-ийг шинэчлэн боловсруулж, төслийн ТЭЗҮ-д шинжээч томилж, ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг 2022.10.17-ны өрийн 01/941 дугаар албан бичгээр УУХҮЯ-нд ирүүлсэн.<br>УУХҮСайдын 2022.10.31-ний өдрийн А/278 дугаар тушаалаар төслийн ТЭЗҮ-д дүгнэлт гаргах шинжээчийн хэсгийг томилон ажиллуулж, дүгнэлт гаргуулсан.<br>Улмаар 2022.12.09-ний өдрийн ЭБМЗ-ийн өргөтгөсөн хуралдаанаар ТЭЗҮ-ийг хэлэлцүүлэн шийдвэрлэж хүлээн авсан. | |
| 75 | | 2.2.Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад оруулах. | Үйлдвэр байгуулах ажлын явц | 75.8 хувь | 100 хувь | 30,772.4 Хувийн хэвшил /Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээл/ 2021 он | Орхон аймагт “Бэрэн групп” ХХК-ийн хэрэгжүүлж байгаа Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, үйлдвэрийг бүрэн ашиглалтад оруулах асуудлаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайд, Дэд сайд нар тус компанийн захирал Б.Мөнхтөртэй уулзаж | “Бэрэн групп” ХХК-ийн 2014 оноос Орхон аймагт хэрэгжүүлж байгаа 200 мян.тн/жил хүчин чадалтай ган бүтээгдэхүүний үйлдвэрийн төслийн хэрэгжилт 75 орчим хувьтай байна. Тус компани нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2014 онд 22.7 сая ам.доллар, 2018 онд 4.5 сая | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хувийн хөрөнгө оруулалт<br><br>30,772.4 сая төг.<br>2022 он | төслийн хэрэгжилтийн явцтай тухай бүр танилцах, тулгамдаж байгаа асуудлыг шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авсан.<br>Мөн тус компанийн хэрэгжүүлж байгаа Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийн төслийг бүрэн ашиглалтад оруулахад шаардлагатай санхүүжилт, зээлийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор төслийн хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулга, холбогдох материал хүргүүлэх тухай УУХҮСайдын 2021.10.25-ны өдрийн 01/2561 дугаар албан бичгийг ЗГХЭГ-ийн дарга Ц.Нямдоржид хүргүүлсэн.<br>УУХҮСайдын 2021.11.04-ний өдрийн 01/2697 дугаар албан бичгээр тус яамны зүгээс төслийг үргэлжлүүлэх, үйлдвэрийг ашиглалтад оруулахыг бодлогоор дэмжин ажиллаж байгаа тухай албан бичгийг “Бэрэн групп” ХХК болон түүнтэй хамаарал бүхий аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтын явц, үйлдвэрийн техник, технологийн талаар санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн /УУХҮСайдын 2020.08.28-ны өдрийн А/218 тоот тушаалаар байгуулагдсан/ санал, зөвлөмж, дүгнэлтийн хамт Хөгжлийн банкинд хүргүүлсэн.<br>Тус компаниас үйлдвэрийг ашиглалтанд оруулахад | ам.доллар, нийт 27.2 сая ам.долларын зээлийн санхүүжилт авсан ба үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлүүлээгүйн улмаас уг зээл эргэн төлөгдөөгүй байна. Цаашид үйлдвэрийг ашиглалтанд оруулахад шаардагдах 30.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмж олгох хүсэлтийг тус компаниас Хөгжлийн банк болон УУХҮЯ-нд гаргасан ба УУХҮЯ болон Хөгжлийн банкны зүгээс боломжит хувилбарыг судалж, удаа дараагийн уулзалтуудыг зохион байгуулсан.<br>ХҮБГ-аас 2022 онд төслийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:<br>2022.01.04-ний өдөр УУХҮСайдад “Бэрэн групп” ХХК-ийн Орхон аймагт хэрэгжүүлж байгаа “Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэр”-ийн төслийн явц, тулгамдаж байгаа асуудлын талаар тус компанийн захирал Б.Мөнхтөр танилцуулсан. УУХҮСайдаас үйлдвэрийг ашиглалтад оруулах каледарчилсан төлөвлөгөө гарган шахуу тооцоотой ажиллаж үйлдвэрийг яаралтай ашиглалтад оруулах үүрэг даалгавар өгсөн.<br>Тус төслийг ШСБ-ын хөгжлийн төслүүдийн жагсаалтад оруулж, төслийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан, төслийн хэрэгжилт, явцын талаар 7 хоног бүр тайлан авч, ЭЗХЯ-нд хүргүүлэн ажилласан. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шаардагдах 15 сая ам.долларын санхүүжилтийг нэмж олгох хүсэлтийг Хөгжлийн банкинд гаргасан бөгөөд банкны зүгээс дэмжих саналтай байна. Одоогоор санхүүжилтийн боломжит хувилбарыг судалж байна. Хөгжлийн банкны дэд захирал С.Цэрэндаш, Нөөцийн удирдлагын хэлтсийн захирал А.Хүчитбаатар нартай төслийн нэмэлт зээл, санхүүжилтийн асуудлаар 2021.12.07-ны өдөр уулзалт зохион байгуулж харилцан тохиролцсоны дагуу УУХҮЯ болон Хөгжлийн банк хооронд хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийг дэмжин хамтран ажиллах тухай санамж бичиг байгуулсан. | Дээрх ажлын хүрээнд тус төслийн санхүүжилтийг шийдвэрлэх, үйлдвэрийг ашиглалтад оруулах асуудлаар Хөгжлийн банкны холбогдох удирдлагуудтай удаа дараагийн уулзалтуудыг ХҮБГ-аас зохион байгуулан ажилласан.<br>2022.08.12-ны өдөр Хөгжлийн банкны Бизнес, хөгжил хариуцсан дэд захирал З.Батырбек тус компанийн өр, зээлийн асуудлын талаар УУХҮЯ-ны ХҮБГ-ын дарга Д.Даваадоржид танилцуулсан. Мөн энэ асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлэх тухай ХҮБГ-ын Даргын 2022.08.16-ны өдрийн 07/2216 дугаар албан бичгийг Хөгжлийн банкинд хүргүүлсэн.<br>“Бэрэн групп” ХХК, түүний хамаарал бүхий компаниудын тус банкнаас авсан зээл, өрийн асуудлыг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх хүсэлтийг Хөгжлийн Банкнаас хүргүүлсэн талаар мэдэгдсэн ба эцсийн шийдвэр гараагүй байна. | |
| 76 | | 2.3. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах. | Үйлдвэр байгуулах ажлын явц | 16.4 хувь | 100 хувь | 11,350.0 Хувийн хэвшил /Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт/<br><br>Хувийн хөрөнгө оруулалт | Төслийн ажил Ковид-19 цар тахлын улмаас 2020-оос 2021 оны 12 сарын байдлаар зогсонги байдалд байна.<br>Төслийн 2021 оны санхүүжилтыг толгой компани /“Монзол групп“ ХХК/-ийн хөрөнгө оруулалтаар шийдсэн.<br>Цутгуурын цех, дулаан боловсруулах цехийн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн захиалга хийгдэж, 3.567 тэрбум | Дорноговь аймагт МДМУ ХХК-ийн хэрэгжүүлж буй хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах төслийн ажил ковид-19 цар тахлын улмаас 2021-2022 онуудад зогсонги байдалд байна. Төслийн зарим санхүүжилт толгой компани /“Монзол групп“ ХХК/-ийн хөрөнгө оруулалтаар шийдэгдэж цутгуурын цех, дулаан боловсруулах цехийн шаардлагатай тоног | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 11,350.0 сая төг.<br>2022 он | төгрөгийн урьдчилгаа тоног төхөөрөмж нийлүүлэгч компани /БНХАУ-ын "Qianxi ADI Machanical Casting" Co.Ltd/-д төлсөн боловч төлөвлөгөөний дагуу газар дээр нь очиж тоног төхөөрөмжийн сонголт хийн оруулж ирэх, мөн БНХАУ-аас мэргэжилтэн оруулж ирэх асуудлууд Ковид-19 цар тахлын хилийн хөл хорионы улмаас шийдэгдэхгүй байна. | төхөөрөмжүүдийн захиалга хийгдэж, 3.567 тэрбум төгрөгийн урьдчилгаа төхөөрөмж нийлүүлэгч компанид төлсөн боловч төлөвлөгөөний дагуу БНХАУ /"Qianxi ADI Machanical Casting" Co.Ltd компани/-д төлөх нэмэлт санхүүжилт шийдэгдээгүйн улмаас тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хийгдэхгүй, мөн мэргэжилтэн оруулж ирэх асуудал шийдэгдэхгүй, төслийн ажил зогсонги байдалтай байна. | |
| 77 | | 2.4. Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах /"Болдтөмөререөгол" ХХК/. | Үйлдвэр байгуулах ажлын явц | 20 хувь | 80 хувь | Хувийн хөрөнгө оруулалт | "Болд төмөр Ерөө гол" ХХК өөрийн санхүүжилтээр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт нийт 140 га талбайд "Хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах төсөл"-ийг 2019-2025 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.<br>Цогцолборын хэмжээнд нийт 420 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалтаар жилд 500 мянган тонн хүчин чадалтай ширэмний үйлдвэр бүхий 5 үйлдвэр байгуулагдах ба эхний 4 үйлдвэр нь ширэмний үйлдвэрээ түүхий эдээр хангах зорилготой.<br>Эхний шатанд газрын асуудал (140 га)-ыг бүрэн шийдвэрлэж, дэд бүтцийг бий болгох хүрээнд 12 км төмөр зам, 6,3 МВт-ын цахилгааны дэд станц, 110 кВ, 10 кВ-ын 9,4 км цахилгаан дамжуулах агаарын шугамууд барьж байгуулаад байгаа ба жилд 2 сая тонн хүчин чадалтай төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэрийг 2019 онд эхлүүлж энэ онд | "Алтан ширээт аж үйлдвэрийн парк"-ийн 2022 онд төлөвлөсөн бүтээн байгуулалтын ажил дараах байдалтай байна.<br>✓ Төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан.<br>✓ НБҮ-ийн барилгын ажил, тоног төхөөрөмж суурилуулах ажил хийгдэж байна.<br>✓ Паркийн усан хангамжийг шийдэх зорилгоор "Бор хөөвөр"-ийн гүний усны орд дээр ус цуглуулах байгууламж байгуулах ажил, ажилчдын 5 блок байр барих, нүүрс ачиж, буулгах талбайн газар, шорооны ажлыг 2022 оны 5 дугаар сард тус тус эхлүүлсэн.<br>Төслийн ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ХҮБГ-аас 2022 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:<br>✓ 2022.01.04-ний өдөр "Болдтөмөр Ерөө гол" ХХК-ийн удирдлагууд хэрэгжүүлж | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ашиглалтанд оруулахаар туршилт тохируулгын ажлыг 2021 оны 9 дүгээр сард эхлүүлээд байна.<br>Мөн үйлдвэрлэлийн усан хангамжийг шийдэх зорилгоор Бор хөөвөр болон Долоодын говиос гүний ус дамжуулах 103 км урттай шугамын трассын зураглал хийгдсэн бөгөөд ТЭЗҮ боловсруулах нэгдсэн ажлын явц 70% гүйцэтгэлтэйгээр явагдаж байна.<br>Улмаар 1 сая тонн хүчин чадалтай нүүрс угаах үйлдвэрийг 2021-2022 онд, жилд 1.5 сая тонн хүчин чадалтай коксын үйлдвэрийг 2022-2023 онд, жилд 1.5 сая тонн хүчин чадалтай төмрийн хүдрийн хорголжийн үйлдвэрийг 2023-2024 онд, жилд 500 мян.тонн хүчин чадлалтай ширэмний үйлдвэрийг 2024-2025 онд барьж байгуулахаар төлөвлөн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажил хийгдэж байна.<br>Мөн нүүрс угаах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлсэн ба газар шороо, суурийн ажил 90 %-тай байна. | байгаа төслийн ажлын явц, 2021 оны гүйцэтгэл, 2022 онд хийгдэх ажил, тулгамдаж байгаа асуудлын талаар ХҮБГ-ын дарга Д.Даваадоржид танилцуулсан.<br><br>✓ ХҮБГ-ын даргын өгсөн үүрэг даалгаврын дагуу тус компаниас 2022.01.05-ны өдрийн 21/11 дугаар албан бичгээр төслийн хүрээнд 2022 онд хийгдэх ажлын календарчилсан төлөвлөгөөг ирүүлсэн.<br>✓ 2022.03.02-ны өдрийн ЗГ-ын хуралдаанд “Алтан ширээт аж үйлдвэрийн парк”-ийн төслийн бүтээн байгуулалтын явц болон цаашид хийгдэх ажил, тулгамдаж байгаа асуудлын талаар УУХҮСайд танилцуулсан.<br><br>✓ “Монголын эдийн засгийн чуулган 2022”-ын бэлтгэл ажлын хүрээнд 2022.03.24-ний өдөр зохиогдсон “Аж үйлдвэрийн сэргэлт” хэлэлцүүлгийн үеэр “Алтан ширээт аж үйлдвэрийн парк”-ийн зарим үйлдвэрийг түүхий эд /коксжих нүүрс/-ээр тогтвортой хангах боломж бүрдүүлэх зорилгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК болон “Болдтөмөр Ерөө гол” ХХК-ийн хооронд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан.<br><br>✓ Төслийг ШСБ-ын хөгжлийн төслүүдийн жагсаалтад оруулж, төслийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан, төслийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хэрэгжилт, явцын талаар 7 хоног бүр төсөл хэрэгжүүлэгчээс тайлан авч, ЭЗХЯ-нд хүргүүлэн ажилласан. | |
| 78 | | 2.5. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн парк байгуулах. | Үйлдвэр байгуулах ажлын явц | 5 хувь | 100 хувь | Хувийн хөрөнгө оруулалт, зээл 40,099.1 сая төг. | Тус зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.<br>1. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах төслийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг 2020.12.15-ны өдөр, Техник технологийн түвшний үнэлгээг 2020.09 сард, БОННҮ-ний тайланг 2021.02.09-ний өдөр тус тус холбогдох мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн.<br>2. УУХҮЯамны ЭБМЗ-ийн Боловсруулах үйлдвэрийн салбар хуралдаанаар хэлэлцүүлсэн паркийн техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу дэд бүтцийн нарийвчилсан зураг, төсөл боловсруулах, барьж байгуулах ажилд нийт 136.0 тэрбум төгрөгийг тусгасан ба 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 4.8 тэрбум төгрөг тусгагдсан нь паркийн төмөр зам, авто зам, ус хангамж, ариутгах татуургын систем барих зураг төсөл боловсруулах, цахилгаан хангамжийн ТЭЗҮ боловсруулах тендерийн сонгон шалгаруулалтыг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас зохион байгуулан ажиллаж байна.<br>3. Засгийн газрын 2021.05.05-ны өдрийн 129 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-т үйлдвэрлэл, технологийн паркийн үйл | ҮТП-ийн авто зам, төмөр зам, усан хангамж, ариутгал татуургын системийн зураг төсөл, төсвийг 100% гүйцэтгэж БХБЯамны Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан, цахилгаан хангамжийн ТЭЗҮ-ийг ЭХЯамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, батлагдсан зураг төсөл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу ус хангамж болон ариутгах татуургын системийг 2023 оны 6 дугаар сард, авто замыг 2023 оны 7 дугаар сард, төмөр замыг 2023 оны 8 дугаар сард, цахилгаан хангамжийн системийг 2024 оны 2 дугаар сард ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж, дэд бүтцийг барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтын ажлыг эхлүүлээд байна.<br>- ҮТП-ийн Автозамын зураг төсөл төсвийг барьж байгуулах ажлын тендерийг 2022.06.30, 2022.09.26-нд 2 удаа зарласан. Шаардлага хангасан оролцогч материал ирүүлээгүй тул 2022.11.25-нд дахин тендер зарласан.<br>- Төмөр зам барьж байгуулах ажлын тендерийг 2022.10.06-нд нээж, 3 компани материал ирүүлсэн боловч шаардсан материал дутуу ирүүлсэн тул тендер хүчингүй болсон. Тендерийг 2022.11.07-ний | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон.<br>4. Орхон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021.07.01-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор тус паркийг байгуулах зорилгоор нийт 1217,4 га талбайг улсын тусгай хэрэгцээнд авах саналыг дэмжсэн. Үүний дагуу парк байгуулах газрыг улсын тусгай хэрэгцээнд авах санал хүргүүлэх тухай УУХҮСайдын 2021.07.08-ны өдрийн 01/1764 дугаар албан бичгийг БХБЯ-нд хүргүүлсэн. | өдөр дахин зарласан. 2022.12.12-ны өдөр нээнэ.<br>- Ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлын тендер 2022.10.06-нд нээсэн бөгөөд нийт 7 оролцогчийн ирүүлсэн материалд үнэлгээ хийгдэж дууссан ба шаардлага хангах оролцогч байгаагүй тул Тендерийг 2022.11.07-ний өдөр дахин зарласан. 2022.12.12-ны өдөр нээнэ.<br>- Паркийн цахилгаан хангамжийн ТЭЗҮ-ийг Эрчим хүчний яам хүлээн аван, хариуцан ажиллаж байна. Диспетчерийн үндэсний төвтэй горимын тооцоо хийлгэсэн. 3 ширхэг дэд станц тус бүр дээр техникийн нөхцөл гарсан. ЭХЯ хариуцан цахилгаан хангамжийн нарийвчилсан зураг төсөл хийлгэхээр техникийн даалгавар боловсруулж боловсруулсан, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан тендер зарлахаар ажиллаж байна.<br>- Засгийн газрын “Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах тухай” 2022 оны 171 дүгээр тогтоолын дагуу Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын нутаг дэвсгэрт Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн үйлдвэрлэл технологийн парк барих зориулалтаар 1217.4 га газар ашиглах 2022/185 дугаартай гурвалсан гэрээг УУХҮЯ, ГЗБГЗЗГ, Орхон аймгийн засаг дарга хооронд 2022.10.25-ны өдөр | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгуулж, тус гэрээний дагуу ҮТП-ийн 2022.11.14-ний өдрийн №000000019 дугаартай Газрын гэрчилгээг УУХҮЯ-ны нэр дээр аваад байна. | |
| 79 | | 2.6. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барих. | Үйлдвэр байгуулах ажлын явц | 0 хувь | 95 хувь | Хувийн хөрөнгө оруулалт, зээл<br><br>123,446.0 сая төг. | Засгийн газрын 2021.05.05-ны өдрийн 129 дүгээр тогтоолын 2 дахь хэсэгт зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. БНХАУ-ын China ENFI Engineering Co., Ltd (ENFI) болон China nonferrous metal industry's foreign engineering and construction Co., Ltd (NFC) консорциум нь “Зэсийн баяжмалыг тасралтгүй ажиллагаатай хос SKS технологиор боловсруулах металлурги-химийн үйлдвэр байгуулах төсөл”-ийн ТЭЗҮ-ийг боловсруулж дуусссан ба төслийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны дэргэдэх ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Энэ хүрээнд элементийн хүхэр үйлдвэрлэх технологийн “үйлдвэрлэлийн туршилт”-ын ажлыг гүйцэтгэхээр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь БНХАУ-ын “China ENFI Engineering” компанитай хамтран ажиллаж байна. Туршилтын үр дүнд үндэслэн боловсруулагдаад буй ТЭЗҮ-д тодотгол хийнэ. | Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь БНХАУ-ын “China ENFI Engineering” компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн 2022.06.23-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Зэсийн үнэ 8340 $/тн-ны түвшинд 762 сая ам.долларын хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан.<br>Тус ТЭЗҮ-г үндэслэн Зэсийн баяжмал хайлуулах боловсруулах үйлдвэрийн төслийн нарийвчилсан инженерийн зураг төсөл боловсруулах ажлын техникийн даалгаврыг “Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ”-ын “Үйлдвэрлэл, технологийн парк төслийн нэгж” боловсруулсан. Үүний дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Худалдан авах ажиллагааны газарт 2022.09.22-ны өдөр хүргүүлсэн ба Үнэлгээний хороо байгуулагдаж тендер зарлахаар ажиллаж байна.<br>Валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан тус ажлын төсөвт өртөгт өөрчлөлт оруулсан бөгөөд Эрдэнэт үйлдвэрийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахаар ажиллаж байна.<br>Зэсийн баяжмал хайлуулах үйлдвэрээс гарах хүхрийн давхар исэл агуулсан хийг | 70 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжан Уйгарын ӨЗО-ны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн “Xinxin Metals” компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулахаар төлөвлөсөн. Туршилт явуулах үйлдвэрлэлийн болон иргэний барилга байгууламжийн нарийвчилсан зураг төслийн ажлууд 100%, тоног төхөөрөмжийн захиалга, худалдан авалт 100%-ийн гүйцэтгэлтэй байгаа ба үлдсэн тоног төхөөрөмжүүд үйлдвэрлэгдэх шатанд байна. Барилга байгууламжийн суурийн ажил 2022 оны 8 дугаар сараас хийгдэж эхэлсэн.<br>Үндсэн тоног төхөөрөмжүүдийн үйлдвэрлэлийн хяналт шалгалтуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн ба үйлдвэрлэгчийн агуулахаас тээвэрлэхэд бэлэн болоод байна. Гэвч БНХАУ-д үүсээд буй Ковид-19 цар тахлын хорио цээрийн улмаас үйлдвэрлэгдсэн тоног төхөөрөмжүүдийг төсөл хэрэгжүүлэх талбай руу тээвэрлэх боломжгүй байгаа тул туршилтын ажлын гүйцэтгэлийн хугацааг 2023.11.10-ны өдөр дуусгах төлөвлөгөөг гүйцэтгэгчээс ирүүлсэн.<br>Тус төлөвлөгөөтэй холбогдуулан Зэсийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрээс гарах хүхэрт хийнээс элементийн хүхэр ялган авах туршилтын ажлыг эрчимжүүлэх талаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2022.10.07-ны өдрийн "Үйлдвэрлэлийн туршилтын ажлын тухай" албан бичгийг БНХАУ-ын “China ENFI engeneering” корпорацийн Ерөнхийлөгч Liu Cheng болон “ENFI судалгаа хөгжлийн институт”-ын захирал Yao liang нарт хүргүүлээд байна.<br>Мөн туршилтын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тээвэрлэлт болон төсөл хэрэгжүүлэх талбайн бүтээн байгуулалтын ажлыг оновчтой зохион байгуулж, үйлдвэрлэлийн туршилтын ажлыг 2023 оны I улиралд багтаан бүрэн дуусгахад “China ENFI Engineering” корпорацид дэмжлэг үзүүлэх хүсэлтийг БНХАУ-ын холбогдох төрийн байгууллагад зохих журмын дагуу уламжлах хүсэлтийг УУХҮСайдын 2022.11.10-ны өдрийн 01/2938 дугаар албан бичгээр БНХАУ-аас Монгол Улсад суугаа элчин сайд Цай ВэньРуйд хүргүүлсэн. “China ENFI engeneering корпораци”-аас 2022.11.15-ны өдөр ирүүлсэн албан бичигтээ туршилтын үйлдвэрийг 2023.05.30-нд барьж дуусган, туршилтын ажлын үр дүнг 2023.06.30-ны өдрийн дотор гаргасан байх тухай албан ёсоор мэдэгдсэн.<br>“China ENFI engeneering корпораци”-ийн зүгээс зэсийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн төслийн хөгжүүлэлт, нийт хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүний гарцын чиглэлээр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-тай хамтран ажиллах сонирхолтой байгаагаа 2022.11.23-ны өдрийн албан бичгээр илэрхийлээд байна. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2022.12.19-ний өдрийн өргөтгөсөн шуурхай хурлаас өгөгдсөн чиг үүргийн дагуу Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар China ENFI Engineering компанид 2022.12.22-ны өдөр дахин албан бичиг хүргүүлсэн. China ENFI Engineering компани болон Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайд Т.Бадрал нарт туршилтын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тээвэрлэлтийг эрчимжүүлэх асуудлаар 2022.12.23-ны өдөр албан бичиг хүргүүлсэн. /Төслийн хэрэгжилт-4.6/ | |
| 80 | | 2.7. Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулах. | Үйлдвэр байгуулах ажлын явц | 0 хувь | 100 хувь | Хувийн хөрөнгө оруулалт, зээл<br><br>83,685.5 сая төг. | Засгийн газрын 2021.05.05-ны өдрийн 129 дүгээр тогтоолоор Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутаг дэвсгэрт уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах зориулалтаар Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-т үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Уг тогтоолын 2 дахь хэсэгт исэлдсэн хүдрээс нуруулдан уусгах SX/EW технологиор катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын | Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын захиалгаар “Майнинг Шорт Лонг Терм” ХХК-ийн боловсруулсан Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг УУХҮЯ-ны ЭБМЗ-ийн Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх салбар хуралдааны 2022.06.24-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн боловч Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Ерөнхий захирлын өргөтгөсөн зөвлөлийн 2022.10.13-ны өдрийн хурлаас "Гүйцэтгэгч | 30 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хөрөнгөөр санхүүжүүлж, ашиглалтад оруулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад даалгасан. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас “SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил” гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг 2021 онд зохион байгуулсан бөгөөд “Майнинг шорт лонг терм” ХХК-тай 2021.09.17-ны өдөр гэрээ байгуулсан. Үйлдвэр байгуулахад шаардлагатай бүтээн байгуулалтын ажлыг 2022 онд эхлүүлж, 2023 онд үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. | компанийн боловсруулсан ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын техникийн зөвлөлөөр хэлэлцэх"-ээр шийдвэрлэсэн. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Техникийн зөвлөлийн 2022.11.04-ний өдрийн хурлаар Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг хэлэлцэж Эрдэнэт үйлдвэрийн мэргэжилтнүүдийн өгсөн санал, шүүмжийн дагуу ТЭЗҮ-ийг засварлан боловсруулах, үүнд шаардлагатай хугацааг харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгах, ТЭЗҮ-ийг засварласны дараа Техникийн зөвлөлөөр дахин хэлэлцүүлж дэмжсэн тохиолдолд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх”-ээр шийдвэрлэсэний дагуу гэрээний хугацааг 2023.03.31-ний өдөр хүртэл сунгах саналыг Эрдэнэт үйлдвэрийн ХОХААБГ-т, Техникийн зөвлөлийн шийдвэрийг гүйцэтгэгч компанид тус тус албан бичгээр хүргүүлсэн байна. ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 30%. /Төслийн хэрэгжилт- 8.6%/ | |
| 81 | | 2.8.Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах. | Үйлдвэр байгуулах ажлын явц | 0 хувь | 100 хувь | Гадаадны шууд хөрөнгө оруулалт | Засгийн Газрын 2020.06.01-ний өдрийн 212 дугаар тогтоолоор Ашигт малтмал хайх эрх олгогдсон ба тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2020.08.26-ны өдрийн 308 тоот шийдвэрээр Баянхонгор | Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх ажлын хүрээнд “Эрдэнэс Монгол” ХХК-д 3 удаа албан бичиг хүргүүлж, “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн удирдлагатай 4 удаа уулзалт хийж, ажлыг эрчимжүүлэх талаар цахимаар 2 удаа | 50 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумдын нутагт орших Хүрэнцав нэртэй 1704.51 гектар, Мухар хар толгой нэртэй 4313.57 гектар, Довжоот нэртэй 1393.37 гектар, Халзан нэртэй 453.89 гектар талбай нийт 7865.34 гектар талбай бүхий 4 тусгай зөвшөөрлийг олгосон бөгөөд эдгээр талбайг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар төслийн тодорхой хэсгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх зорилгоор Хүрэнцав нэртэй талбайд геологийн эрэл хайгуул,геофизикийн ажил гүйцэтгэх тендер зарлан ажиллаж байна.<br>Компанийн эзэмшлийн хайгуулын тусгай зөвшөөрлийг барьцаалан зээл олгох боломжийн талаар арилжааны банкуудад хандсан бөгөөд арилжааны банкуудаас хайгуулын тусгай зөвшөөрөл барьцаалан зээл олгох боломжгүй тухай хариу ирүүлсэн.<br>“Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2021.10.01-ний өдрийн А/100 дугаар тушаалаар байгуулагдсан үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ, төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаар санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсэг ажиллаж Ажлын хэсгийн эцсийн дүгнэлтийг 2021.12.01-ний өдөр гаргаад байна. | мэдэгдсэн. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.7.7 дахь хэсэгт заагдсан арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан 2022 онд гүйцэтгэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, баталгаажуулах, үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулах төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх болон төсөл хэрэгжүүлэгчийг нээлттэй сонгон шалгаруулах ажлыг 2022 оны I улиралд багтаан зохион байгуулахаар тус төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг ханган ажиллах талаар УУХҮСайдын 2022.01.06-ны өдрийн 01/43 дугаар албан бичгийг “Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлсэн. Төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг шийдвэрлэх болон төсөл хэрэгжүүлэгчийг нээлттэй сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахаар ажлын даалгавар боловсруулах Ажлын хэсгийг “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн захирлын 2022.03.21-ний өдрийн А-22/03 тушаалаар байгуулсан. “Үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн ТЭЗҮ-ийн төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол, ижил төстэй үйлдвэрүүдийн харьцуулсан судалгаа, төслийн санхүүжилтийн талаарх санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий” Ажлын хэсгийг “Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2021.10.01-ний | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Мөн төслийг эрчимжүүлэх ажлын хүрээнд үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн төсөлд оролцох саналаа илэрхийлсэн БНХАУ-ын уул уурхайн тоног төхөөрөмжийн Шинхай компанийн төлөөлөлтэй УУХҮЯ-ны ХҮБГ, “Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн төлөөлөл 2021.11.25-ны өдөр цахим уулзалтыг зохион байгуулж үнэт металл цэвэршүүлэх үйлдвэрийн төслийн хөрөнгө оруулалт, хүчин чадал, өртөг зардал, төслийг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны талаар санал солилцсон.<br>Төслийн хэрэгжилтийн явцтай тухай бүр танилцах, тулгамдаж байгаа асуудлыг шуурхай шийдвэрлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор төсөл хэрэгжүүлэгчтэй сар бүр уулзалт хийх хуваарь гарган 2021.11.22-ны болон 2021.12.06-ны өдрүүдэд “Эрдэнэс Алт ресурс” ХХК-ийн төлөөлөлтэй хийсэн уулзалтыг зохион байгуулан, тодорхой чиглэл удирдамжийг өгч ажилласан. | өдрийн А/100 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг БНКазУ-ын “Сымбат инженеринг” ХХК-ийн боловсруулсан ТЭЗҮ-ийг хянаж, бодит байдалтай нийцэхгүй, хөрөнгө оруулалтын зардлыг хэт өндөр байна гэж дүгнэсэн.<br>Бүгд Найрамдах Казахстан Улсаас Монгол Улсад суугаа Элчин Сайдын яамны 2022.07.18-ны өдрийн 30-309 дугаар захидлаар “Сымбат инженеринг” ХХК үнийн санал дахин ирүүлснийг УУХҮСайдын 2022.08.02-ны өдрийн 01/2111 дүгээр албан бичгээр “Эрдэнэс Монгол” ХХК-д хүргүүлсэн. Элчин Сайдын яамнаас 2022.07.18-ны өдрийн 30-309 дугаар захидлаар “Сымбат инженеринг” ХХК үнэт металл цэвэршүүлэх үйлдвэр барихад 80 сая ам.долларын санхүүжилтийг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх боломжтойг уламжилсан саналд “Эрдэнэс алт ресурс” ХХК нь санал болгож буй хөрөнгө оруулалтыг хүлээн авч бүх талаар хамтран ажиллах саналаа илэрхийлж, 2022.08.31-ний өдрийн ЕА 22/65 албан бичгээр хүргүүлсэн байна.<br>Тус төслийн ТЭЗҮ боловсруулсан “Сымбат инженеринг” ХХК-ийн захирал Мейрам Тлеужанов 2022.11.21-23-ны өдрүүдэд Монгол Улсад ирж, “Эрдэнэс алт ресурс” ХХК-тай уулзалт хийсэн. | |
| 82 | | 2.9. Оюутолгойн ордыг түшиглэн зэсийн баяжмалыг | Үйлдвэр байгуулах ажлын явц | 0.2 хувь | 20 хувь | Гадаадын шууд хөрөнгө оруулалт | ЗГ-ын 2017 оны 88 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын | Засгийн газрын 2017 оны 88 дугаар тогтоолын дагуу “Зэсийн баяжмал | 90 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх. | | | | 4,267.9 сая төг. 2021 он<br><br>443.9 сая төг. 2022 он | 2018.12.12-ны өдрийн “Газрыг тусгай хэрэгцээнд авах тухай” 378 дугаар тогтоолоор зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих зорилгоор Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт орших 466 га газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэх зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулахад хууль, санхүүгийн зөвлөгөө авах зорилгоор өмгөөллийн “Монгол өмгөөлөгч” ХХН-тэй гэрээ байгуулан ажиллаж, гүйцэтгэсэн тайланг хүлээн авсан. Мөн үйлдвэрийг Оюу-толгойн баяжуулах үйлдвэртэй холбох салаа төмөр зам болон эрчим хүчний дэд бүтцийн техникийн нөхцлийг боловсруулаад байна. Засгийн газрын 2017 оны 88 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт заасны дагуу үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулж хамтран ажиллах хөрөнгө оруулагчийг сонгох бэлтгэл ажлын хүрээнд хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах хамтарсан ажлын хэсэг байгуулах, хөрөнгө оруулагчтай байгуулах гэрээний төслийг багтаасан ажлын даалгавар боловсруулж, батлуулах, хөрөнгө оруулагчийн урьдчилсан сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, жагсаалт гаргах, эцсийн шалгаруулалтын | боловсруулах үйлдвэр барих төслийн “Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах аргачлал” болон “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний төслийг боловсруулж хамтран батлахаар УУХҮСайдын 2022.02.24-ний өдрийн 01/471 дүгээр албан бичгээр Сангийн яаманд, 2022.04.12-ны өдрийн 01/985 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн. Сангийн яамнаас аргачлал болон хөрөнгө оруулалтын гэрээний төслийг хамтран батлах боломжгүй талаар 2022.04.01-ний өдрийн 01/1858 дугаар албан бичгээр мэдэгдсэн. Эдийн засаг, хөгжлийн яамнаас 2022.07.19-ний өдрийн 01/765 албан бичгээр санал ирүүлсэн.<br>“Рио тинто Монгол” ХХК-д төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах талаар тодорхой санал ирүүлэх тухай УУХҮСайдын 2022.04.26-ны өдрийн 01/1179 дугаар албан бичиг хүргүүлсэн. Тус компаниас 2022.05.17-ны өдрийн албан бичгээр “Төслийн эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах, шаардагдах хөрөнгө оруулалт татах боломжийг судлах” ажлыг гүйцэтгэн өгөх талаар мэдэгдэж, нууцлалын гэрээ байгуулан ажиллаж байна. Төслийн "Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах аргачлал” болон “Хөрөнгө оруулалтын гэрээ”-ний төслийг АНУ-ын Олон улсын хөгжлийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | даалгавар боловсруулах, эцсийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах зэрэг цаг хугацаа шаардсан ажлуудыг эхлүүлээд байгаа бөгөөд шалгарсан хөрөнгө оруулагчтай байгуулах хөрөнгө оруулалтын гэрээний төсөлд талуудын саналыг тусган 2022 оны 2 дугаар улиралд багтаан ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Мөн “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах” төслийн хэрэгжилтийн явц, цаашид авах арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулгыг УУХҮСайдын 2021.11.04-ний өдрийн 01/2698 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Цаашид төслийн хэрэгжилтийн явцтай тухай бүр танилцах, тулгамдаж байгаа асуудлыг шуурхай шийдвэрлэх, хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор төсөл хэрэгжүүлэх нэгжтэй сар бүр уулзалт хийх хуваарь гарган ажиллаж байна. | агентлаг /USAID/-ийн Азийн Товчооны гэрээ хэлцлийн түншүүдтэй хамтран олон улсад мөрдөгдөж байгаа жишиг аргачлалын дагуу боловсруулахаар 2022 оны 06 дугаар сараас эхлэн ажилласан. Энэ хүрээнд яамдууд болон техникийн, хуулийн багтай тус бүр 4 удаа, цахимаар 6 удаа уулзалт зохион байгуулж санал хүргүүлсэн.<br>•Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичигт тусгагдах хөрөнгө оруулалт, усны эх үүсвэр, эрчим хүчний асуудлаар 2022.08.16,19-ний өдрүүдэд БОАЖ-ын Дэд сайд, Эрчим хүчний Дэд сайд болон холбогдох газрын дарга мэргэжилтнүүдтэй уулзалт хийсэн.<br>•Уулзалтын дагуу “Хамтран ажиллах тухай” УУХҮСайдын 2022.08.30-ны өдрийн 01/2339 дүгээр албан бичгийг БОАЖСайдад, 2022.08.30-ны өдрийн 01/2340 албан бичгийг Эрчим хүчний Сайдад тус тус хүргүүлж ус хангамж, эрчим хүчний эх үүсвэрийг шийдвэрлэх боломжит хувилбаруудыг баталгаажуулж авсан. (Усны газраас 2022.09.27-ны өдрийн 01/1091, ЭХЯ-аас 2022.10.07-ны өдрийн а/3862 дугаар албан бичгүүд тус тус ирсэн).<br>•Монгол Улсын Засгийн газар “Оюу толгой” ХХК-тай байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээний 3.21-д заасан техникийн шалгуур үзүүлэлтүүдийн талаар “Рио Тинто Монгол” ХХК-иас | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 2022.10.07-ны өдрийн албан бичгээр зэс хайлуулах үйлдвэрт олон улсын зах зээлийн үнэ, стандартад суурилсан арилжааны нөхцөлөөр Оюутолгойн зэсийн баяжмалыг нийлүүлэх боломжтойг мэдэгдсэн.<br>•Эцэслэн боловсруулсан баримт бичгүүдийг 2022.11.28-ны өдөр Англи, Монгол хэл дээр хүлээн авсан. Хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах урьдчилсан шалгаруулалтын баримт бичиг болон тендерийн баримт бичгийг 4 бүлгээр боловсруулсан. Үүнд:<br>1.Төслийн тухай мэдээлэл<br>2.Тендерийн журам, маягтууд<br>3.Техник болон инженерийн асуудлууд<br>4.Хөрөнгө оруулалтын гэрээний загвар<br>Хөрөнгө оруулагчийн урьдчилсан шатны сонгон шалгаруулалт, тендерийн баримт бичигт Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамнаас санал авах тухай УУХҮСайдын 2022.12.21-ний өдрийн 01/3357 албан бичгээр хүргүүлээд байна. | |
| **5. Ерөнхий чиг үүрэг: Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, зохицуулах, хэрэгжүүлэх.** | | | | | | | | | |
| **Үндсэн чиг үүрэг-1: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.** | | | | | | | | | |
| 83 | Зорилт-1:<br>Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, аппаратын дотоод ажил болон олон нийттэй харилцах, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын | 1.1. Яамны дотоод ажил болон олон нийттэй харилцах, бодлого, стратеги, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэн гаргах, тайлагнах. | Үйл ажиллагааны үнэлгээний хувь | 92 хувь | 95 хувь | Улсын төсөв | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаварыг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжилтийг тайлагнасан.<br>Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, байгууллагын үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөртэй уялдуулан 2021 оны үйл ажиллагааны болон холбогдох бусад төлөвлөгөөг | -“Алсын хараа–2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг түүний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг хугацаанд нь гаргаж ХШҮДАГ-т хүргүүлсэн. Хэрэгжилтийг УУХҮСайдын 2022.07.01-ний өдрийн 01/1890 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг нэгтгэн тайлагнах. | | | | | | нэгтгэн боловсруулах, тайлагнах ажлыг тухай бүр хуулийн хугацаанд зохион байгуулж ажилласан.ТНБД-ын 2021.02.06-ны өдрийн А/15 дугаар тушаалаар байгуулсан салбарын болон яамны стратеги төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын 2020-2024 оны Стратеги төлөвлөгөөг боловсруулан УУХҮСайдын 2021.04.19-ний А/81 дугаар тушаалаар батлуулсан.<br>УУХҮЯамны 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж 2021.01.27-ны өдөр батлуулсан.<br>“Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-д тусгагдсан 7 зорилтын 59 арга хэмжээ, “Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого”-д тусгагдсан 6 зорилтын 32 арга хэмжээ, “Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-д тусгагдсан 5 зорилтын 14 арга хэмжээний хэрэгжилтийг хуулийн хугацаанд нэгтгэн боловсруулж, ХШҮДАГ-т хүргүүлсэн.<br>УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хамаарах 2 зорилт, 3 арга хэмжээний хэрэгжилт, 2 дугаар хавсралтын 15 төсөл, арга хэмжээний биелэлт, 3 дугаар | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тус яамны эрхлэх асуудлын хүрээнд туссан зорилт, арга хэмжээ, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд 2022.11.25-ны өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn)-д байршуулж баталгаажуулсан. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2022.12.01-ний өдрийн 01/3176 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/.<br>УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд УУХҮСайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг нэгтгэн тогтоосон хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2022.01.18-ны өдрийн 01/131 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн/.<br>УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын асуудлаар тусгагдсан 17 зорилт, 72 арга хэмжээний | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хавсралтын 3 хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн биелэлтийн тайланг 2021 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэж ХШҮДАГ-т 2021.12.20-ны өдөр хүргүүлсэн.<br>УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн геологи, уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хамаарах зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийн тайланг 2021 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэж ХШҮДАГ-т 2021.12.24-ний өдөр хүргүүлсэн.<br>Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д тусгагдсан зорилтын чиг үүрэгт хамаарах хэрэгжилтийн тайланг ТНБДаргын 2021.11.12-ны өдрийн 03/2782 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. | 2021 оны хэрэгжилтийг нэгтгэн тогтоосон хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2022.01.18-ны өдрийн 01/132 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/.<br>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2021 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг нэгтгэн тогтоосон хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг “Тайлан хүргүүлэх тухай” УУХҮСайдын 2022.07.01-ний өдрийн 01/1891 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/.<br>Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийг /нийт 179 шийдвэрийн 269 зүйл, заалтын/ нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлсэн.<br>Засгийн газрын 374 дүгээр тогтоолын дагуу Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг сар бүр гарган ХШҮДАГ-т хүргүүлж байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тус яамны эрхлэх асуудлын хүрээнд туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 2022.10.31-ний өдрийн байдлаар, 2022.11.25-ны | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | өдрийн байдлаар нэгтгэн ХШЗДАГ-т хүргүүлсэн. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг "Тайлан хүргүүлэх тухай" УУХҮСайдын 2022.12.01-ний өдрийн 01/3176 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/. Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т тусгагдсан УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээний төслүүдийн 2021 оны хэрэгжилтийг нэгтгэн тогтоосон хугацаанд нь ХШҮДАГ-т хүргүүлсэн. /2022.01.18-ны өдрийн 01/131 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн./ Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийг нэгтгэн тогтоосон хугацаанд ХШҮДАГ-т хүргүүлсэн. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг "Тайлан хүргүүлэх тухай" УУХҮСайдын 2022.06.16-ны өдрийн 03/1695 дугаар албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн./ Засгийн газрын 374 дүгээр тогтоолын дагуу Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд тус яамны эрхлэх асуудлын хүрээнд туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг сар бүр нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлж байна. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг "Тайлан хүргүүлэх тухай" УУХҮСайдын 2022.12.01-ний өдрийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | 01/3176 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн/. УУХҮСайдын эрхлэх асуудлын хүрээнд батлагдсан Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн (137 шийдвэрийн 241 зүйл, заалт) хэрэгжилтийн тайланг 2022 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн ХШҮДАГ-т 2022.06.22-ний өдөр хүргүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан Улсын Их Хурлын тогтоолын нийт 4 шийдвэрийн 6 зүйл, заалтын биелэлтийг нэгтгэж 2022.11.09-нд ХШҮДАГ-т хүргүүлсэн. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд болон Төрийн нарийн бичгийн даргын 2021 онд баталсан нийт 412 тушаалын биелэлтийн хэрэгжилтийг нэгтгэж ХШҮДАГ-т хүргүүлсэн. Гадаадын зээл тусламжаар хэрэгждэг төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн ХШҮДАГ-т хүргүүлсэн. /Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг УУХҮСайдын 2022.02.21-ний өдрийн 01/437 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн./ Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дах хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | тогтоох, тайлан гаргах журам", Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 9.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсгийг ТНБДаргын 2021.11.22-ны өдрийн А/91 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Монгол Улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Шинэ сэргэлтийн бодлого 2022-2025, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын стратеги төлөвлөгөө (2020-2024), УУХҮЯ-ны стратеги төлөвлөгөө (2020-2024) зэрэг бодлогын баримт бичигт үндэслэн газруудын саналыг авч нэгтгэн боловсруулж, байгууллагын удирдлагын зөвлөлийн 2022.01.05-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, ТНБДаргаар батлуулан УУХҮСайдаар хянуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан. УУХҮЯ-ны 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэмэлт өөрчлөлтийг Батлагдсан төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 246 дугаар тогтоолын дагуу "Архив албан хэрэг хөтлөлтийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нийтлэг журам"-ын дагуу УУХҮЯ-ны архивт хүлээлгэн өгсөн. УУХҮЯ-ны 2021 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэж ХШҮДАГ-т 2022.01.04-ний өдөр хүргүүлсэн. Засгийн газрын 2021 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Архив албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын дагуу УУХҮЯ-ны 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг УУХҮЯ-ны архивт хүлээлгэн өгсөн. /УУХҮЯ-ны 2021 оны нэгдсэн тайланг УУХҮСайдын 2022.03.31-ний өдрийн 01/823 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн./ | |
| **Үндсэн чиг үүрэг-2: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэй боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах.** | | | | | | | | | |
| 84 | Зорилт-2: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө, боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах. | 2.1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хүний нөөцийн хөгжлийн стратегийн баримт бичгийн төслийг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах. | Батлуулсан баримт бичгийн тоо | 0 | 1 | Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | УУХҮЯ-ны 2021 оны Сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Тайлант оны жилийн эцсийн байдлаар нийт Төрийн албанд шинээр томилгодсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 4, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 5, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагч, Бусад цаг үеийн шинжтэй мэргэшүүлэх сургалтуудад /Мерит төслийн шугмаар болон ЖҮХ, ХЭҮК, ТАЗ, АТГ/ давхардсан тоогоор нийт 128 гаруй албан хаагчийг сургалтад хамруулсан байна. Мөн Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн зардлын 2021 | УУХҮЯ-ны 2022 оны Сургалтын төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Тайлант оны хагас жилийн байдлаар нийт Төрийн албанд шинээр томилгодсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 9, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 9, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч, Бусад цаг үеийн шинжтэй мэргэшүүлэх сургалтуудад /Мерит төслийн шугмаар болон ЖҮХ, ХЭҮК, ТАЗ, АТГ/ давхардсан тоогоор нийт 100 гаруй албан хаагчийг сургалтад хамруулсан байна. Мөн Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж, тэтгэлгийн зардлын 2022 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оны төлөвлөгөөг АМГТГ-аас ирүүлсэн саналын дагуу Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. | оны төлөвлөгөөг АМГТГ-аас ирүүлсэн саналын дагуу Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. | |
| **Үндсэн чиг үүрэг-3: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль тогтоомжийн талаар олон нийтэд сурталчилан таниулах.** | | | | | | | | | |
| 85 | Зорилт-3: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн боловсруулах бусад эрх зүйн актын төсөл боловсруулах, өргөн барихад дэмжлэг үзүүлэх. | 3.1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн боловсруулах бусад эрх зүйн актын төсөл боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах. | Боловсруулсан хууль тогтоомж, эрх зүйн актын тоо | 108 | 112 | Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | 1.УУХҮСайдын 2018 оны А/28 дугаар тушаалаар байгуулагдсан Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмын шинэчилсэн найруулгын төсөл болох “Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ын төслийг Геологийн бодлогын газарт мэргэжил арга зүйн зөвлөгөөгөө өгч хамтран ажилласан.<br>2.Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд боловсруулагдсантай холбогдуулан АМГТГ, ҮГА болон яамны дотоод нэгжийн хүрээнд саналыг нэгтгэн судалж, Зөрчлийн тухай хуульд оруулах Уул уурхай, геологи, хүнд үйлдвэр, газрын тосны салбарын хамаарах асуудлаар хуульд оруулах саналыг ХЗДХЯ-нд хүргүүлсэн.<br>3. Монгол Улсын Засгийн газрын 2021.11.10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдсэн Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шинэчлэлийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын хавсралтад заасан Төрийн эзэмшлийн хувь хэмжээг хэвээр хадгалах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалттай холбогдуулан тус яамны | 1.Геологи, уул уурхайн салбарын эрх зүйн орчинтой холбогдуулж, УУХҮСайдын 2021.10.27-ны өдрийн А/273 дугаар тушаалаар батлагдсан “МУ-ын Ерөнхий сайдын 2021 оны 01 дүгээр албан даалгаврын 12.8-д заасан Уул уурхайн хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулах, хүнээс хамааралгүй, ил тод, шуурхай болгох арга хэмжээний хүрээнд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрээр олгох нөхцөл боломжийг судлах, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг ажиллан, УУХҮСайдын 2022.04.12-ны өдрийн А/67 дугаар тушаалаар “Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ыг батлуулан захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 5821 дугаарт бүртгүүлж чиг үүргийн хүрээнд хянаж, туслалцаа үзүүлэн оролцов.<br>2.Геологийн бодлогын газраас боловсруулсан Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг хянаж, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | эрхлэх асуудлын хүрээнд хамаарах ШТАББ ТӨҮГ, ГТЛ ТӨҮГ, ГСТ ТӨҮГ-уудыг Төрийн эзэмшлийн хувь хэмжээг хэвээр хадгалах жагсаалтад оруулахаар СЯ болон ЗГХЭГ-т удаа дараа саналыг боловсруулан хүргүүлж ажиллав. | УУХҮСайдын 2022.05.02-ны өдрийн А/87 дугаар тушаалаар батлуулан захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 5828 дугаарт бүртгүүлж чиг үүргийн хүрээнд хянаж, туслалцаа үзүүлэн оролцов.<br>3. СХОГ-аас боловсруулан Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайлангийн дараах захиргааны статистик мэдээллийн маягт, түүнийг нөхөх зааврыг УУХҮСайдын 2022.05.31-ний өдрийн А/123 дугаар тушаалаар батлуулан захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 5852 дугаарт бүртгүүлж чиг үүргийн хүрээнд хянаж, туслалцаа үзүүлэн оролцов.<br>4.Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулах үүрэг бүхий Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн байнгын хорооны дэд ажлын хэсэгт ажиллан 2022.06.15-ны өдөр Үйлдвэржилтийн байнгын хорооны хурлаар хэлэлцүүлж Улсын Их Хурлын 2022.06.16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн. Тус хууль нь 2022.07.05-ны өдөр батлагдаж, 2022.08.01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.<br>5.Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд УУХҮЯ, АМГТГ болон ҮГА нартай хамтарсан | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | уулзалт хийж, санал солилцож, уг хуулийн төсөлд саналыг хүргүүлэв.<br>6.Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах Ажлын хэсгийг УУХҮСайдын 2020.12.25-ны өдрийн А-332 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсэг нь 2021.01.27-ны өдрөөс 2021.05.21-ний өдрийг хүртэл хугацаанд вакуумжин ажиллах хугацаандаа Канад, Австрали, Оросын холбооны улс, Казакстан зэрэг 10 гаран улсын уул уурхайтай холбоотой хууль тогтоомжийг судлан Хууль тогтоомжийн тухай хуульд заасан судалгаа, хуулийн төслийн үзэл баримтлал, Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаас өмнө салбарын холбогдох мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллага, судлаачид болон төрийн зарим байгууллагын төлөөлөлтэй нийт 21 удаагийн уулзалт зохион байгуулж хуулийн өөрчлөлттэй холбоотой санал, үзэл санааг сонсох, нэгдсэн нэг байр сууринд хүрэх зорилт тавин ажилласан. Мөн ажлын хэсгийн судлаачдын багийн гишүүдээс Хууль тогтоомжийн тухай хуульд заасан холбогдох судалгаа, тайланг хийгээд байна. Үүнд: | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үр нөлөө, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, хуулийн төслийн зардлын тооцоо зэрэг болно. Мөн үзэл баримтлалын төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас санал авахаар хэлэлцүүлгийг зохион байгуулж байна.<br>7.Хүнд үйлдвэрийн газраас боловсруулан УУХҮС, БСШС, ХХААХҮС нартай хамтран баталсан “Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох” журмыг батлуулан захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 5553 дугаарт бүртгүүлж чиг үүргийн хүрээнд хянаж, туслалцаа үзүүлэн оролцов.<br>8.Газрын тосны тухай, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг УУХҮСайдын 2021 оны А/12 дугаар тушаалаар байгуулав. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу холбогдох төрийн байгууллага болон аж ахуйн нэгжүүдээс санал авахаар ГТБГ-ын Даргын 2021.09.09-ний өдрийн 08/2198 дугаар албан бичгийг хүргүүлж, ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулсан. Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, хуулийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төслийн үзэл баримтлал болон танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо зэрэг судалгааны тайлангуудыг тус тус боловсруулсан. Тус хуулийн төслийг 2022 оны УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангасан. УУХҮСайдын 2022 оны А/44 дүгээр тушаалаар Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас санал авч, саналын товъёог нэгтгэсэн. Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль УИХ-ын чуулганаар хэлэлцэн дэмжигдэж, батлагдаад байна.<br>9.Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг УУХҮСайдын 2020.11.02-ны өдрийн А/270 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан.<br>Хуулийн төслийн үзэл баримтлалыг 2020 оны 8 дугаар сард Сангийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан. Хуулийн төслийг батлагдсан үзэл баримтлалдаа нийцүүлэн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу яамны цахим хуудас, “Нээлттэй нийгэм форум” болон “Олборлох үйлдвэрийн ил тод байдлын санаачилга” төслийн цахим хуудсанд тус тус байршуулж санал авч, хуулийн төслийн хэлэлцүүлгийг иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан 2020.10.06-ны өдөр зохион байгуулж, саналыг тусгасан. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хуулийн төсөл, дагалдах хуулийн болон дүрэм, журам боловсруулах үүрэг бүхий олон улсын болон дотоодын зөвлөх 2020 оны 12 дугаар сараас ажиллаж, өмнө боловсруулсан хуулийн төсөлд тулгуурлаж шинэчилсэн хуулийн төсөл, танилцуулгыг боловсруулсан. Ажлын хэсгийн гишүүд нь хуулийн төслийн бичвэрийг эцэслэж, Улсын Их Хурлын 2022 оны намрын чуулганд багтаан өргөн мэдүүлэхээр ажиллаж байна. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай анхдагч хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд шилжүүлэн хүргүүлсэн болно.<br>10.ГТБГ-аас боловсруулсан Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага болон тайлангийн хүснэгтийн загварын төслийг хуулийн хүрээнд хянаж, засч сайжруулан журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг хянаж, УУХҮСайдын 2022.11.16-ны өдрийн А/287 дугаар тушаалаар батлуулан ЗЕХ-д заасны дагуу ХЗДХЯ-нд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэн оролцож, 6017 дугаарт бүртгүүлэв.<br>11.ГТБГ-аас боловсруулсан Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн төслийг хуулийн хүрээнд хянаж, засч сайжруулан журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг мөн хянаж, УУХҮСайдын 2022.11.16-ны өдрийн А/288 дугаар тушаалаар батлуулан ЗЕХ-д заасны дагуу ХЗДХЯ-нд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэн оролцож, 6018 дугаарт бүртгүүлэв.<br>12.ХҮБГ-аас боловсруулсан Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн үйл ажиллагааны дүрмийн төслийг хуулийн хүрээнд хянаж, засч сайжруулан журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг мөн хянаж, УУХҮСайдын 2022.09.22-ны өдрийн А/245 дугаар тушаалаар батлуулан ЗЕХ-д заасны дагуу ХЗДХЯ-нд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэн оролцож, 5959 дугаарт бүртгүүлэв.<br>13.ХҮБГ-аас боловсруулсан Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх журмын төсөл, Технологийн түвшний үнэлгээний хэмжээг тогтоох аргачлалын төслийг хуулийн хүрээнд хянаж, засч сайжруулан Захиргааны ерөнхий хуульд заасан нөхцөл шаардлагыг хангасан эсэхийг мөн хянаж, УУХҮСайдын 2022.06.22-ны өдрийн А/135/А/200 дугаар тушаалаар батлуулан ЗЕХ-д заасны дагуу ХЗДХЯ-нд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхэд хууль зүйн туслалцаа үзүүлэн оролцож, 5874 дугаарт бүртгүүлсэн. | |
| **Үндсэн чиг үүрэг-4: Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх.** | | | | | | | | | |
| 86 | Зорилт-4:<br>Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтын гэрээний талаар гадаад орон, олон улсын эрх зүй, туршлагыг судлах, | 4.1. Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт татах чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хоёр | Байгуулсан гэрээ, хэлэлцээрийн тоо | 3 | 7 | Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж | “Эрдэс баялгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Байгалийн нөөц, баялгийн яам хоорондын харилцан ойлголцлын Санамж бичиг”-ийн төсөлд хятадын талаас ирүүлсэн саналыг тусган 2021.10.07-ны өдөр хүргүүлсэн бөгөөд санамж бичгийг хоёр тал | 1.Монгол, Австралийн Гадаад харилцааны яам хоорондын ээлжит зөвлөлдөх уулзалтын яриа хэлэлцээрийн сэдэвт санал хүргүүлэх тухай албан бичгийг боловсруулан 2022.01.26-ны өдрийн 03/204 тоот албан бичгээр ГХЯ-д;<br>2.Монгол Улсын Ерөнхийлөгч 2021 оны 12 дугаар сард ОХУ-д албан ёсны айлчлал хийж, Монгол Оросын иж | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
